

**ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

**2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр, Лхагва гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-4
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	5-64

---

**1.Орон сууц захиалах, худалдан авахтай холбоотой захиалгын гэрээ байгуулан хохирсон иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын хүрээнд хохирсон иргэдийн төлөөллийн санал, хүсэлт, холбогдох байгууллагын тайлбар, мэдээллийг сонсох**

6-55

**2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай/**

55-56

**3.Ахмад настнуудаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин, хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлж, цалингийн итгэлцүүрээр тэтгэврийг шинэчлэн тогтооход ахмадуудын тэтгэврийн хэмжээ багассан асуудлаар ирүүлсэн өргөдлийг судлан, санал, дүгнэлт болон шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт**

56-64

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Өргөдлийн байнгын хорооны  
05 дугаар сарын 20-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 27 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бат-Эрдэнэ, П.Мөнхтулга;  
Чөлөөтэй: Ж.Батсуурь, Д.Ганмаа, Ж.Золжаргал, Ц.Идэрбат,  
Г.Лувсанжамц;  
Эмнэлгийн чөлөөтэй: С.Замира, Р.Эрдэнэбүрэн.

**Нэг.Орон сууц захиалах, худалдан авахтай холбоотой захиалгын гэрээ байгуулан хохирсон иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын хүрээнд хохирсон иргэдийн төлөөллийн санал, хүсэлт, холбогдох байгууллагын тайлбар, мэдээллийг сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, мөн яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга О.Одбаяр, Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Найрамдал, Дахин төлөвлөлтийн хэлтсийн дарга В.Мөнхжаргал, Нийслэлийн орон сууцны бодлогын газрын дарга Д.Алтанзул, мөн газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Ж.Болортуяа, Нийслэлийн орон сууцны корпорацын Хуулийн хэлтсийн дарга С.Дорждэрэм, “Улаанбаатар орон сууцжуулалт” хязгаарлагдмал хувьцаат компанийн газрын дарга Б.Пүрэвсүрэн, Хот байгуулалт, хотын стандартын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга М.Мэндсайхан, Барилгын техник, хяналтын улсын ахлах байцаагч Б.Содномпил, Д.Ганчимэг, Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны дарга С.Цогтгэрэл, Улсын ерөнхий прокурорын газрын Эрүүгийн хууль тогтоомжийг хангуулах газрын дарга О.Мөнхбаатар, мөн газрын ахлах прокурор Р.Батнасан, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн шалгах албаны дэд бөгөөд Залилах гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга Б.Батдэлгэр, мөн газрын Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч Б.Ууганбаатар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаны дарга Э.Бямбажав, мөн албаны Дотоод хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Даваадорж, төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн төлөлөл “Танан ордос капитал” хязгаарлагдмал хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Мөнх-Оргил, “Өргөө ногоон хөгжил” хязгаарлагдмал хувьцаат компанийн гүйцэтгэх

захирал Д.Санжаа, мөн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ж.Жаргалсайхан, Монголын багш нарын “Шинэ зуун зөвлөлдөх зөвлөл” төрийн бус байгууллагын төлөөлөл Б.Цэрэндолгор, “Авес Гранд” хязгаарлагдмал хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Л.Чадраабал, мөн компанийн өмгөөлөгч Б.Нандин-Эрдэнэ, “Сэд дэвжих” хязгаарлагдмал хувьцаат компанийн төлөөлөл Ж.Ариунболд, Б.Сүхбат, “Андын зам констракшн” хязгаарлагдмал хувьцаат компанийн төлөөлөл Э.Лхагвасүрэн, “Марч констракшн” хязгаарлагдмал хувьцаат компанийн захирал Н.Бадралбат, “Алаг хайрхан бугат” хязгаарлагдмал хувьцаат компанийн төлөөлөл Э.Мөнгөнбагана, “Эрхэт Монгол” хязгаарлагдмал хувьцаат компанийн Барилга хариуцсан дэд захирал, Н.Лувсаншарав, орон сууцны захиалга хийн хохирсон иргэдийн төлөөлөл Ш.Солонго, Б.Одгэрэл, Э.Бямбаням, Б.Дашбат, Ж.Ганболд, Д.Гантөмөр, Б.Шинэбаатар, П.Бат-Эрдэнэ, Б.Алтанчимэг, Д.Энхбаяр, Э.Алтантөгс, М.Амарсанаа, Ц.Энхболд, Б.Сонгуульмаа, Д.Найдан, Ц.Цэцгээ, Ш.Болормаа, Я.Эрдэнэсүх, Б.Төмөр, Ц.Баярмаа, Л.Дэмбэрэл, С.Баярхүү, Ч.Сонинтуяа, Э.Даниел, Г.Санчирмаа, М.Отгонбат, Л.Нямсүрэн, И.Наранцэцэг, С.Сансартуяа, Ц.Насанбуян нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, зөвлөх Л.Зулцэцэг, референт Г.Нямсүрэн, С.Уянга, өргөдөл, гомдол хариуцсан ажилтан Д.Оюун, Хяналт шалгалтын газрын референт Б.Хэрлэн нар байлцав.

Орон сууцны залилах гэмт хэргийн нөхцөл байдлын талаарх Цагдаагийн ерөнхий газрын мэдээллийг Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн шалгах албаны дэд бөгөөд Залилах гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга Б.Батдэлгэр танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан орон сууцны захиалга хийн хохирсон иргэдийн төлөөлөл Ц.Баярмаа, Ч.Сонинтуяа, Л.Нямсүрэн, Ш.Солонго, Б.Дашбат, Ж.Ганболд, Б.Шинэбаатар, Б.Алтанчимэг, Д.Энхбаяр, Д.Найдан, Я.Эрдэнэсүх, И.Наранцэцэг, Г.Санчирмаа, Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах, О.Саранчулуун, Ц.Мөнхтуяа, Б.Баярбаатар, Б.Пунсалмаа, С.Ганбаатар, О.Номинчимэг, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, мөн яамны Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Найрамдал, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн шалгах албаны дэд бөгөөд Залилах гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга Б.Батдэлгэр, Улсын ерөнхий прокурорын газрын Эрүүгийн хууль тогтоомжийг хангуулах газрын ахлах прокурор Р.Батнасан, Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны дарга С.Цогтгэрэл, Нийслэлийн орон сууцны бодлогын газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Ж.Болортуяа, “Марч констракшн” хязгаарлагдмал хувьцаат компанийн захирал Н.Бадралбат, “Өргөө ногоон хөгжил” хязгаарлагдмал хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Санжаа, “Танан ордос капитал” хязгаарлагдмал хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Мөнх-Оргил нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, О.Саранчулуун, С.Ганбаатар, П.Сайнзориг нар үг хэлэв.

*Уг асуудлыг 13 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, зөвлөх Л.Зулцэцэг, референт, Г.Нямсүрэн, С.Уянга, Хяналт шалгалтын газрын референт Б.Хэрлэн нар байлцав.

Байнгын хорооны дарга О.Номинчимэг тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**О.Номинчимэг:** “Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Ж.Золжаргал, Г.Лувсанжамц, Ц.Мөнхтуяа, М.Сарнай, Б.Пунсалмаа нар ажиллахаар тогтов.

*Уг асуудлыг 13 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Ахмад настнуудаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин, хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлж, цалингийн итгэлцүүрээр тэтгэврийг шинэчлэн тогтооход ахмадуудын тэтгэврийн хэмжээ багассан асуудлаар ирүүлсэн өргөдлийг судлан, санал, дүгнэлт болон шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, мөн газрын шинжээч Б.Баянжаргал, Э.Цэрэнбат, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, мөн газрын ахлах мэргэжилтэн З.Пунцагцэрэн, Үндэсний статистикийн хорооны Нийгмийн статистикийн газрын дарга Ш.Ариунболд, мөн хорооны Эдийн засгийн статистикийн газрын дарга М.Оюунжаргал, Үнийн статистикийн хэлтсийн дарга Г.Мөнх-Оргил, Нийгмийн статистикийн хэлтсийн статистикч Г.Урангоо нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, зөвлөх Л.Зулцэцэг, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын тавьсан асуултад Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, О.Номинчимэг нар үг хэлэв.

*Уг асуудлыг 13 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 3 цаг 29 минут үргэлжилж, ирвэл зохих 21 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр 13 цаг 56 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
10 цаг 27 минут.

### **ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**О.Номинчимэг:** Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Өргөдлийн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанд нийт 21 гишүүнээс 11 гишүүн ирснээр Байнгын хорооны хуралдаан эхэлж байна.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн, Мягмардашийн Сарнай гишүүн, Халтмаагийн Баттулга гишүүн, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн, Дүгэрийн Рэгдэл гишүүн, Чинбатын Ундрэм гишүүн, Жанчивын Галбадрах гишүүн, Отгоны Саранчулуун гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг нар өнөөдөр Байнгын хорооныхоо хуралдаанд оролцож байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Өнөөдөр ирцдээ орчихсон гишүүд маань Байнгын хорооныхоо хуралдаанд оролцъё, ирье. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 3 асуудал бид хэлэлцэхээр төлөвлөсөн байгаа.

1 дүгээрт, Орон сууц захиалах, худалдан авахтай холбоотой захиалгын гэрээ байгуулан хохирсон иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын хүрээнд хохирсон иргэдийн төлөөллийн санал, хүсэлт, холбогдох байгууллагын тайлбар, мэдээллийг сонсоно.

Үүний дагуу 2 дугаарт, Байнгын хорооны тогтоолын төсөл буюу Хянан шалгах ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай асуудал дээр хэлэлцэж батална.

3 дугаарт, Ахмад настнуудаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлж, цалингийн итгэлцүүрээр тэтгэврийг шинэчлэн тогтооход ахмадуудын тэтгэврийн хэмжээ багассан асуудлаар ирүүлсэн өргөдлийг судлан, санал, дүгнэлт болон шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсоно.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

**Эхний асуудал буюу орон сууц захиалах, худалдан авахтай холбоотой захиалгын гэрээ байгуулан хохирсон иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын хүрээнд хохирсон иргэдийн төлөөллийн санал, хүсэлт холбогдох байгууллагын тайлбар, мэдээллийг хэлэлцэж эхэлье.**

Өнөөдрийн энэ одоо хэлэлцэх гэж байгаа асуудал бол бидний яг энэ хаврын чуулганаар анхаарч бас хэлэлцэх асуудлын тоонд орсон байгаа. 12 сард хаврын чуулганаар хэлэлцэх асуудлыг бид батлахдаа энэ асуудлыг манай Өргөдлийн байнгын хорооны маш олон гишүүд дэмжсэн. Энэтэй холбоотой Өргөдлийн байнгын хороонд одоогоор 12 багц төсөлтэй холбогдуулан 600 гаруй иргэдийн өргөдөл, гомдол бичгээр ирсэн байгаа.

Тэгээд энэ бичгээр ирсэн өргөдөл, гомдлын дагуу бид бас хэд хэдэн арга хэмжээ, үйл ажиллагааг зохион байгуулсан байгаа. Энэ оны 03 сард юуны түрүүн Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоотой хамтран уулзаад, түүний дараа төрийн байгууллагууд буюу Хот байгуулалтын яам, Санхүүгийн зохицуулах хороо, цагдаа, нийслэл, улсын бүртгэл гэх мэтчилэн төрийн байгууллагуудтай хамтарсан хуралдаан хийж, цаашид энэ тулгамдаж байгаа асуудал гарахгүй байх, урьдчилан сэргийлэх асуудал дээр санал, бодлоо солилцсон.

Үүний дагуу бол энэ санал, дүгнэлтийг Хууль зүйн яам, хууль санаачлагч гишүүдэд уламжилж хууль, эрх зүйн асуудлыг нь сайжруулах тал дээр санал, дүгнэлтээ явуулсан.

Иргэд маань өнөөдөр олон иргэд бас энд Өргөдлийн байнгын хороонд дуу хоолойгоо өргөхөөр ирсэн байна. Ажлын албанаас хүмүүсээ суулгая. Оролцогчид маань суудлаа эдэлчихсэн үү, эхлэх үү, болж байна уу? Ингээд өнөөдөр хэлэлцэх Өргөдлийн байнгын хороогоор хэлэлцэх эхний асуудалдаа оръё.

Эхний асуудал бол орон сууц захиалах, худалдан авахтай холбоотой захиалгын гэрээ байгуулан хохирсон иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын хүрээнд хохирсон иргэдийн төлөөллийн санал, хүсэлт холбогдох байгууллагын тайлбар, мэдээллийг бид нээлттэй Байнгын хороогоороо хэлэлцэж байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа иргэдийн төлөөлөл, төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн төлөөлөл болон албан тушаалтнууд ирсэн байна. Тэгээд энэ асуудлыг бид түрүүн хэлсэн хаврын чуулганаар нэлээн анхаарч ажиллана гэж Байнгын хорооныхоо төлөвлөгөөнд оруулсан.

Үүний мөрөөр бол 2025 оны 12 дугаар сараас эхэлж хохирсон иргэдийн санал, хүсэлтийг авсан байгаа. 2026 оны 01 дүгээр сарын 14, 03 сарын 13, 03 сарын 17 бол төрийн байгууллагуудтай, Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоонуудтай уулзаж, дахин энэ асуудал гарахгүй байх тал дээр хууль, эрх зүйн хувьд бодлогын ямар шийдлүүд хэрэгтэй байгаа талаар санал солилцож, хууль санаачлагч нарт энэ мэдээллийг хүргүүлж, бид хууль санаачлагч нараас хурдан хуулийн төслөө оруулж ирэх тал дээр ажилласан.

Мөн өнгөрсөн долоо хоногийн 05 дугаар сарын 13-ны өдөр хохирсон иргэдийн төлөөлөл болон холбогдох албан тушаалтнуудтай уулзалтыг зохион байгуулж, саналуудыг ерөнхийдөө нэгтгэн авсан байгаа. Ингээд иргэдийнхээ өргөдөл, гомдлыг судлан авч үзэж бид бас ер нь бол өнгөрсөн хугацаанд бид Засгийн газарт тодорхой хэмжээний үүрэг чиглэл өгсөн. Өргөдлийн байнгын хорооноос хамтарсан ажлын хэсэг байгуулж, энэ асуудлууд дээр анхаарах гэсэн үүрэг чиглэл өгсөн боловч төдийлөн бас ахицтай явахгүй байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Бат-Амгалангийн захирамжаар Барилгын яаман дээр ажлын хэсэг байгуулагдаж, яг энэ барилгатай холбоотой дуусаагүй барилга, цаашдын арга хэмжээтэй холбоотой ажлын хэсэг бол одоо яг ажиллаж байгаа. 06 сарын эхээр санал, дүгнэлтээ танилцуулахаар ажиллаж байгаа гэсэн мэдээлэл байгаа.

Бид гэхдээ ер нь энэ асуудлыг авч үзээд олон жилийн ужгирсан асуудал байгаа. Түүрүү долоо хоногт ч гэсэн бас манай зарим Өргөдлийн байнгын хорооны гишүүд иргэдтэйгээ уулзсан байгаа. Аль аль дээр нь хууль, эрх зүйн орчныг нь сайжруулах, одоо байгаа иргэдийнхээ асуудлыг шийдэж хохиролгүй болгох дээр нь төр ямар дэмжлэг, бодлогын асуудлуудыг шийдэх вэ гэдэг дээр иргэдийнхээ бас энэ дуу хоолойг сонсож, Улсын Их Хурал нь энэ дээрээ бас манлайлж арга хэмжээ авч ажиллахгүй бол энэ олон жил болсон энэ явдал үнэхээр иргэдийн маань тэвчээрийг барсан байна. Цөхөрсөн байна.

Энэ дээр Өргөдлийн байнгын хороо гэж байгуулагдсан бол арга хэмжээ авч, Улсын Их Хурал шийдвэр гаргагч гүйцэтгэх засаглалын анхаарлын төвд оруулж бас энийг шийдүүлэх нь бидний бас үүрэг гэж харж байгаа.

Тийм ч учраас өнөөдөр бид нар Өргөдлийн байнгын хороон дээрээ энэ асуудлыг нээлттэй хэлэлцэж, ажлын хэсэг, хянан шалгах ажлын хэсэг байгуулж, цаашдын арга хэмжээ авах асуудал дээр шуурхайлсан энэ ажлуудыг хийхээр төлөвлөсөн байгаа юм.

Ингээд бид бол мэдээж олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мөн хохирогч иргэд маань өөрсдөө бас ийм төлөөлөл бий болгож, энэ дээрээ мэдээлэл солилцож байгаа юм байна. Энэ асуудлуудыг нийгэмд ялангуяа шийдвэр гаргагч нарт илүү ойлгуулж, анхаарлын төвд нь оруулж, бодлогын шийдлийнх нь энэ эрэмбэд нь дээгүүр тавиулах асуудал дээр бид анхаарна.

Эхнээсээ бол мэдээж энэ зарим компаниудтай холбоотой асуудлууд энд анхаарал орж бас үйл ажиллагаа хийгдэж байгаа, хариу тайлбарууд ирж байгаа асуудлууд бол байгаа гэдгийг харж байна.

Гэхдээ бид бол энийг үргэлжлүүлж Улсын Их Хурлынхаа хэмжээнд бас арга хэмжээ авахаар ажиллах нь, ажиллаж байгаа гэдгийг хэлье. Ингээд өнөөдөр бид энэ нээлттэй иргэдийнхээ санал, хүсэлтийг сонсох, төрийн байгууллагууд нь мэдээллээ өгөх, Улсын Их Хурлын гишүүд төлөөлөл нь энэ дээр санал бодлоо хэлж, цаашид авах арга хэмжээн дээрээ бас оролцох энэ хэлэлцүүлэг дээр оролцож байгаа төрийн байгууллага болон иргэдийнхээ төлөөллийг танилцуулъя.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Баяраа ирсэн байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга Одбаяр ирсэн байна. Хот

байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Найрамдал ирсэн байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Дахин төлөвлөлтийн хэлтсийн дарга Мөнхжаргал ирсэн байна. Инженерийн хэлтсийн дарга Батболд ирсэн байна.

Нийслэлээс, Нийслэлийн орон сууцын бодлогын газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Болортуяа ирсэн. “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-ийн газрын дарга Пүрэвсүрэн ирсэн байна. Хот байгуулалт, хотын стандартын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Мэндсайхан ирсэн. Улсын Ерөнхий прокурорын газрын Эрүүгийн хууль тогтоомжийг хангуулах газрын дарга Мөнхбаатар ирсэн байна. Улсын Ерөнхий прокурорын газрын Эрүүгийн хууль тогтоомжийг хангуулах газрын ахлах прокурор Батнасан ирсэн байна.

Мөн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, техник хяналтын улсын ахлах байцаагч Содномпил болон Ганчимэг нар ирж байна. Хот байгуулалтын яамнаас бол нэлээн том бүрэлдэхүүнтэй энэ дээр бас анхаарч ажиллаж байгаа учраас энд бас одоогийн явц, мэдээлэл, та бүхний саналыг бас сонсохоор идэвхтэй бас ирсэн байна гэдгийг хэлмээр байна. Энд ирсэн байгаа билүү? Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар ирсэн байна. Түр Засгийн газрын хурал бас давхардаж орж байгаа учраас яг энэ дээр асуудлаа танилцуулах гээд түр гарсан байгаа юм байна. Мягмар дарга бол удахгүй бас ороод ирнэ. Мөрдөн шалгах албаны дэд бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн шалгах албаны дэд бөгөөд Залилах гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга цагдаагийн хурандаа Батдэлгэр ирсэн байна. Залилах гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч Ууганбаатар ирсэн байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаны дарга, хурандаа Бямбажав ирсэн байгаа. Шийдвэр гүйцэтгэх албаны Дотоод хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Даваадорж ирсэн байгаа.

Энэ байгууллагуудтай бид нар бас өмнөх 2, 3 уулзалт дээр ихэнх нь байсан байгууллага асуудлуудаа мэдэж байгаа. Яг энэ өнөөдөр ирж байгаа иргэдийнхээ энэ төслүүдтэй холбоотой мэдээллийг бүгдээрэнг нь мэдээлж тодорхой ахицтай, эсвэл тодорхой асуудлуудыг шийдэх асуудал дээр юу байгаа талаараа бүгдийг нь нарийвчилж бас энэ төрийн байгууллагуудыг өөрсдөө бэлдэж ирээрэй гэдэг чиглэлийг Өргөдлийн байнгын хорооноос өгсөн байгаа.

Орон сууц захиалгын хохирсон иргэдийн төлөөлөл маань бас ингээд 30-аад иргэдийн төлөөлөл ирсэн байна. “Авес Гранд” ХХК-ийн энэ компанитай холбоотой төсөл дээр хохирогчийн төлөөлөл иргэн Солонгоо, Одгэрэл, Бямба ням нар ирсэн байна. “Эбо Даймонд” гэдэг компанитай холбоотой асуудал дээр Дашбат гэдэг иргэдийн төлөөлөл ирсэн байна. “Алаг хайрхан бугат” ХХК гэдэг компанитай холбоотой асуудал дээр Ганболд, “Марч констракшн” ХХК-ийн хохирогчийн төлөөлөл Гантөмөр, Шинэбаатар. Би яах вэ ингээд иргэдийнхээ төлөөллийг хэлчихье. Угаасаа иргэд маань энэ дээр үгээ хэлэхээр бид бас дэг дээрээ оруулсан байгаа. Энэ орон сууц захиалгатай холбоотой асуудал дээр Бат-Эрдэнэ, Алтанчимэг, Энхбаяр, Алтантөгс, Амарсанаа, Энхболд, Сонгуульмаа, Найдан, Цэцгээ, Болормаа, Эрдэнэсүх гээд 18 иргэдийн төлөөлөл ирсэн байна.

Дахин төлөвлөлттэй холбоотой асуудлаас үүдэн хохирсон иргэдийн төлөөлөл 2 төсөлтэй холбогдуулан Төмөр, Баярмаа, Дэмбэрэл, Баярхүү, Сонинтуяа, Даниел, Санчирмаа, Даниел гээд энэ 6 иргэний төлөөлөл ирсэн байна.

Мөн манай дээр ирсэн багц бас нэг асуудал “Багш 5000, эмч 3000” хөтөлбөр гэдэг ийм орон сууцын хөтөлбөр явсан. Энэ хөтөлбөрт хамрагдаад хохирсон иргэдийн төлөөлөл Санчирмаа, Отгонбат, Нямсүрэн, Наранцэцэг гэсэн энэ төлөөллүүд бас ирсэн байгаа юм байна.

Мөн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн төлөөлөл бас өнөөдрийн манай нээлттэй хуралдаанд ирсэн байна. “Ток таун” төсөл хэрэгжүүлэгч “Ток Таун” гэдэг төслийн хэрэгжүүлэгч “Танан ордос капитал” ХХК-ийн гүйцэтгэх захирал Мөнх-Оргил ирсэн байна. Багш, эмч хөтөлбөр буюу үүнд оролцсон “” ХХК-ийн гүйцэтгэх захирал Санжаа, Өргөө ногоон хөгжил ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн Жаргалсайхан, “Монголын багш нарын шинэ зуун дахь зөвлөл” ТББ-аас Цэрэндолгор нар төлөөлөн ирсэн байна.

“Авес гранд сити апартамент” гэдэг компанийг төлөөлөн гүйцэтгэх захирал Чадраабал ирсэн байна. “Авис гранд сити апартамент”-ын мөн энэ компанийн өмгөөлөгч Нандин-Эрдэнэ бас төлөөлж ирсэн байна. Смарт таун 2 төслийн хэрэгжүүлэх “Сэд дэвжих” ХХК-г төлөөлөн Ариунболд, Сүхбат нар ирсэн байна. Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо “Дээдсийн өргөө” хотхоны “Андын зам констракшн” гэдэг компанийг төлөөлж Лхагвасүрэн ирсэн байна. “Марч констракшн” компани Поларис гээд төсөлтэй холбоотой энийг төлөөлж Нямдоржийн Бадралбат гэдэг хүн ирсэн байна.

Өргөдлийн байнгын хорооны гишүүдэд бид Өргөдлийн байнгын хороон дээр ирсэн орон сууц захиалахтай холбоотой хэргүүдийн багц мэдээллийг та бүхэнд хайрцагар болон цахимаар бүгдэд нь өгсөн байгаа. Нэмэлтээр авах бол бас ажлын албан дээр байна. Бидэнд бол 12 ийм багц төслийн асуудал дээр 600 гаруй иргэдийн өргөдөл ирсэн. Багцлаад асуудлууд нь юу юм, ямар нөхцөл байдалтай байгаа юм. Шүүх дээр, цагдаа дээр очсон уу, эсвэл төсөл хэрэгжүүлэгч компанитайгаа бас ярилцаж байгаа юу? Аль дүүрэгт байрлаж байгаа юм гэдэг нарийвчилсан мэдээллүүдийг та бүхэнд бас хүснэгтлээд тараасан байгаа. Энэ мэдээллийг бас авч танилцсан байх гэдэгт найдаж байна.

Ингээд өнөөдрийн байнгын хорооны энэ асуудал дээр хуралд оролцож байгаа та бүхэнд хуралдааны дэгийг танилцуулъя.

Эхний ээлжид бид Цагдаагийн ерөнхий газраас энэ залилантай холбоотой, орон сууц залилантай холбоотой одоогийн нөхцөл байдлын талаар мэдээлэл бэлдэж ирсэн байгаа. PowerPoint-той. Энийг товч бас ер нь энэ нөхцөл байдал ямар хэмжээнд хүрчхээд байгаа вэ гэдэг мэдээллийг Цагдаагийн ерөнхий газраас маань танилцуулна.

Үүний дараа хохирсон иргэдийн төлөөллөөс дарааллын дагуу иргэд маань санал, хүсэлтээ ямар нөхцөл байгаа гэдгээ нээлттэй ярина. Ингээд энэ ярихад бол дарааллын дагуу 3 минутад багтаагаад тулгарч буй асуудлаа, мөн саналаа, мөн оролцож буй төрийн байгууллага болон төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдээс асуух асуулт байх юм бол асууж асууна. Энд нь бол холбогдох албан тушаалтан, төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн төлөөлөл 3 минутад бас багтаан хариулах ийм дэгтэй байгаа.

Мэдээж манай Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулийн дагуу мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх иргэн албан тушаалтан өөрийгөө танилцуулан мэдээллийн үнэн, зөвийг хариуцдаг. Тэгээд мэдээллээ

санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, худал мэдээлэл ирүүлэхийг бол хориглосон байдаг. Тэгээд үүний дагуу төрийн албан хаагчид маань бас хариултуудаа өгнө. Мөн төсөл хэрэгжүүлэгч иргэд маань ч гэсэн яг энэ бодит мэдээллүүдээ өгнө гэдэгт найдаж байна.

Мөн хуралдаанд оролцогч хуралдааны дэгийг сахин мөрдөх үүрэгтэй бөгөөд хуралдааны дэгийг зөрчвөл түүнийг хуралдаан даргалагчийн шийдвэрээр бол танхимаас гаргадаг бид дэгтэй байгаа. Мөн оролцогчид хуралдааны явцад бусдыг ялгаварлан гадуурхах, доромжлох яриаг нь таслах, сонсгол даргалагчийн зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хүч хэрэглэх зохисгүй үйлдэл гаргаж болохгүй гэсэн бид нар Дэгийн хуультай байгаа гэдгийг сануулъя.

Ингээд хэлэлцэж байгаа асуудал руугаа оръё. Эхний ээлжид Цагдаагийн ерөнхий газраас мэдээлэл танилцуулах уу? PowerPoint-той 1 номер Батдэлгэр хурандаа манай Байнгын хорооны ажлын алба энэ дэлгэц дээр бүгдэд нь харах байдлаар PowerPoint өгчхөөрэй. Та бас индэр дээр гараад ч танилцаж болно шүү. Өөрт амар гэвэл тэгэх үү? Тэгье. Мөрдөн. Шалгах албаны дэд бөгөөд Залилах гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга, цагдаагийн хурандаа Батдэлгэр мэдээлэл танилцуулъя эхлээд.

**Б.Батдэлгэр:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хурандаа Батдэлгэр танилцуулж байна. Орон сууцтай холбоотой залилах гэмт хэргийн нөхцөл байдлыг та бүхэнд товч танилцуулъя. Бид сүүлийн 3 жилийн байдлаар та бүхэнд холбогдох мэдээллийг танилцуулахаар бэлдэж ирсэн байна.

Монгол Улсад цагдаагийн байгууллагад 2024 онд 44673 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 15889 залилах гэмт хэрэг бүртгэгдсэн. Үүнээс 456 буюу 2.8 хувийг орон сууцтай холбоотой залилах гэмт хэрэг эзэлж байна. 2025 онд 47480 хэрэг бүртгэгдсэний 16906 нь залилах гэмт хэрэг бүртгэгдсэн бол үүнээс 512 орон сууцтай холбоотой залилах гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Энэ онд буюу 2026 оны эхний 4 сарын байдлаар 18112 гэмт хэрэг бүртгэгдсэнээс залилах төрлийн гэмт хэрэг 6870 хэрэг бүртгэгдсэн. Үүнээс орон сууцтай холбоотой залилах гэмт хэрэг 199 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

24 онд 456 орон сууцтай холбоотой залилах гэмт хэрэгт 820 иргэнд 32.5 тэрбумын хохирол учирсан байна. 2025 онд 512 орон сууцтай холбоотой залилах гэмт хэрэгт 1445 иргэнд 62.8 тэрбумын хохирол учирсан байна. 2026 оны эхний 4 сарын байдлаар 199 хэрэгт 1348 иргэн 22.9 тэрбумын хохирол учирсан статистик тоо мэдээтэй байна.

Өнөөдрийн байдлаар цагдаагийн байгууллагад 995 иргэн хохирсон 64.5 тэрбумын хохиролтой, 79 иргэн, 22 хуулийн этгээдэд холбогдох хэрэг шалгагдаж байна. Мөрдөн шалгах албаны даргын 2012 оны 02 сарын 12-ны өдрийн тушаалаар орон сууцтай холбоотой хэргийг шалгах ажлын хэсэг байгуулсан.

Энэ ажлын хэсгийн хүрээнд бид нар өнөөдрийн байдлаар нийтдээ 232 хэргийг шийдвэрлэн ажиллаж байна. Цаашдаа бид Мөрдөн шалгах албаны төв байран дээр болон харьяа дүүрэг, орон нутгийн цагдаагийн газар хэлтсүүдэд холбогдох ажлын хэсгүүдийг байгуулсан нэр бүхий аж ахуйн нэгжүүдэд холбогдох хэргүүд дээр мөрдөн шалгах ажиллагааг богино хугацаанд шуурхай хийж хэрэгжүүлэхээр ажиллаж байгааг та бүхэнд танилцуулъя.

Бид мөрдөн шалгах ажиллагаа явуулах явцад бол иргэд маань 2, 3, 4 жил бас энэ хугацаанд залилуулснаа ойлгож ухаарч энэ мэдээ, мэдээллээ цагдаагийн байгууллагад ирүүлдэг. Бид гомдол, мэдээллийг хүлээж аваад хэрэг бүртгэх мөрдөн байцаалтын хэргүүдээ нээж мөрдөн шалгах ажиллагааг явуулдаг. Энэ хугацаанд бол 1 бус иргэний асуудал яригддаг учраас мөрдөн шалгах ажиллагаа хэдийгээр явагдаж дууссан ч гэсэн дараагийн иргэн шинээр гомдол гаргасан тохиолдолд бид нар тухайн хэргийг үргэлжлүүлээд бас мөрдөн шалгах ажиллагааг бас явуулдаг. Ингэхээр бидэнд бас багагүй хугацаа зарцуулагддаг.

Дээрээс нь мөн тухайн байгууллагуудын үйл ажиллагаа явуулсан хугацааны, бүхий л хугацааны санхүүгийн баримтуудыг хүлээн авч аудитын болоод Шүүх шинжилгээний ерөнхий газарт эдийн засгийн шинжилгээний дүгнэлтүүдийг бас гаргуулдаг. Энэ дүгнэлтүүдийг гаргуулахад бас багагүй хугацаа өнгөрдөг. Цаашлаад мөрдөн шалгах ажиллагааны явцад хэрэг, прокурор, шүүхийн шатанд бас нэгтгэгдэх асуудлууд бас байдаг. Мөн бид цагдаагийн байгууллагаас орон сууцын залилантай болоод бусад энэ залилах гэмт хэрэгтэй, гэр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн байгууллагын урьдчилан сэргийлэх албанаас энэ оны эхний 4 сарын байдлаар 15 аж ахуйн нэгж, 3298 ажилтан, алба хаагч, 31255 иргэнийг оролцуулсан урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан.

Мөн энэ хүрээнд 15 рийл, 18 постер, хэвлэлийн мэдээ 4-ийг, пост 9-ийг бэлтгэн нийлүүлж, юу бэлтгэн танилцуулж, давхардсан тоогоор 11 сая 871 иргэнд холбогдох мэдээллийг хүргээд байна. Бид холбогдох байгууллагууддаа Хууль зүй, дотоод хэргийн ямаараа дамжуулаад бас саналуудыг хүргүүлсэн. Бас хуулийн төслүүд бас энэ цаг үед бас явж байгаа. Энэ давхардаж байр, орон сууцыг зарах асуудлыг бас хууль, эрх зүйн орчинд бас бүртгэлийн системээр бас бүртгэдэг байх, мөн санхүүгийн болоод орон сууц, барилга барих бас чадамжгүй, туршлагагүй аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрөл олгож байгаа, мөн энэ явцын хяналтыг тавих, дээрээс нь энэ дутуу гүйцэтгэлтэй барилга дээр гэрчилгээ гаргадаг зэрэг асуудлуудыг бас бид нар эрх зүйн орчны хүрээнд хууль, дүрэм, журамдаа бас нэмэлт, өөрчлөлт оруулах саналтай байгаагаа бас тухай бүр илэрхийлсэн гэдгийг бас танилцуулъя. Танилцуулж дууслаа. Баярлалаа.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Өнөөдөр манай хуралдаанд бас манай Өргөдлийн байнгын хорооны гишүүн Сайнхүүгийн Ганбаатар гишүүн бас ирсэн байна. Түүрүүн ирц танилцуулчихад. Мөн энд холбогдох хуулийн төсөл дээр санаачилж бас бичиж удахгүй Улсын Их Хуралд өргөн барих гэж байгаа Сайнзориг гишүүн маань Өргөдлийн байнгын хорооны хуралдаанд бас ирлээ.

Батдэлгэр хурандаа бол сая ерөнхийдөө залилантай холбоотой мэдээллийг өглөө. Гэхдээ бид нарын өнөөдөр хэлэлцэж байгаа асуудал бол бас бүгд залилангийн асуудал биш байгаа. Ер нь манай Өргөдлийн байнгын хороон дээр ирж байгаа асуудал бол зарим нь үнэхээр хууль, эрх зүйн энэ зохицуулалт хийдэлтэй байгаа учраас залилангийн талбар болж иргэдийгээ хохироосон залилангийн шинж чанартай кэйсүүд байгаа. Зарим нь бол үнэхээр барилгын компани өөрсдөө энэ орон сууц бариад иргэдийн орон сууц худалдах гэрээ хийсэн боловч ямар нэгэн учир шалтгаанаас болоод хойшилсон, хууль, эрх зүйн орчин сул дутмагаас болоод хойшилж удааширч тэн дээр иргэд иргэдийн бас нөгөө хэрэглэгчийн эрхийг хамгаалах энэ асуудлууд тусгагдаагүй байдаг учраас хохирч байгаа иргэд байгаа. Тэгэхээр бид нар бас энэ асуудлуудыг ялгаж шал салгаж ярих ёстой. Олон төрлийн асуудал байгаа учраас. Энд ирсэн бас компаниуд маань

бид нарын зарыг, мэдэгдлийг хүлээн авч ирэлц оролцож бас өөрсдийнхөө нөхцөл байдлыг танилцуулахаар ирсэнд Өргөдлийн байнгын хорооны гишүүдийнхээ өмнөөс бас талархаж байгаа гэдгийг хэлмээр байна.

Ингээд дэгийн дагуу өнөөдөр иргэд маань эхлээд үгээ хэлж, асуулт асуух бол асууна. Үүний дараа Улсын Их Хурлын гишүүд маань Байнгын хорооныхоо дэгийн дагуу асуулт, хариулт, иргэдийнхээ асууж чадаагүй, тодруулж чадаагүй асуудлыг дэмжиж бас асууна. Өөрсдийнхөө байр суурийг тодорхойлох асуудлуудаа бас асуухаар бид ингэж төлөвлөсөн байгаа гэдгийг хэлье.

Бид өнөөдөр ирж байгаа иргэдийнхээ төлөөллийг 3 багц түрүүн асуудалд авч үзсэн байгаа. Энэ хувьцаат орон сууцын хөтөлбөрийн асуудал байна. Хувьцаа гаргангаа орон сууц захиалга авсан дахин төлөвлөлттэй холбоотой асуудал байна. Мөн энэ дахин төлөвлөлт биш орон сууцын захиалгатай холбоотой ингээд 3 багц байгаа. Тэгэхээр өнөөдөр эхлээд бид дахин төлөвлөлттэй холбоотой асуудлаа бас эхлээд яг энэ иргэдийнхээ үгийг сонсьё гэж бодож байна. Дахин төлөвлөлттэй холбоотойгоор 2 компанитай холбоотой төсөлтэй холбоотой иргэд маань өргөдөл, гомдлоо гаргасан.

Эхнийх нь “Грийн ресурс констракшн” ХХК гэдэг төсөл хэрэгжүүлэгчтэй БГД-т байрлах Хөх сувд хотхоны захиалгатай холбоотой хохирсон иргэдийн төлөөлөл бол ирсэн байгаа. Тэгээд яагаад би энийг бас хамгийн эхэнд хэлмээр байна гэхээр өнөөдөр бол энэ компани төлөөлөл нь бол Байнгын хороонд ирсэнгүй. Өмнөх 7 хоногт бид нар хаалттай уулзалт хийхэд бол ирж бас учир нөхцөл байдлаа хэлсэн байгаа.

Тэгээд энэ дээр иргэдийн маань ч гэсэн бас хэлэх байх. Тодорхой асуудлыг бас хурдан шийдээч ээ гэдэг асуудлыг хэлсэн боловч тэр асуудал маань шийдэгдээгүй байгаа гэсэн мэдээллийг бол бичгээр бид нарт өгөөд өнөөдрийн хуралдаанд бас ирээгүй байна. Тэгэхээр эхлээд “Грийн ресурс констракшн”-аас төлөөлөөд 3 иргэн ирсэн байна. Энэ 3 иргэнээс 1 нь төлөөлж үг хэлэх, саналаа хэлэх ёстой байгаа Төмөр, Баярмаа, Дэмбэрэл гуай байна. Хэн нь хэлэх билээ? Баярмаа юу? Баярмаа аль микрофон дээр сууж байна? Энэ иргэдийг төлөөлөөд Хөх Сувд хотхоны төсөлтэй холбоотойгоор Баярмаа асуулт асууж, байр сууриа илэрхийлэх нь. 6 номерын микрофоныг өгье.

**Ц.Баярмаа:** Сайн байцгаана уу? Өнөөдрийн хуралдаанд хүрэлцэж ирсэн та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Бидний хувьд нийслэлийн дахин төлөвлөлтийн орон сууцын захиалга өгсөн иргэд байгаа. Тус төсөл маань нийслэлийн БГД-ийн 10 дугаар хороонд 2021 оноос хойш захиалга өгсөн. Өнөөдрийн байдлаар 5 жил бид орон сууцдаа орж чадаагүй, барилгын ажил сүүлийн 1.8 жил огт явагдаагүй. Энэ хугацаанд мөн ялгаагүй бидэнтэй адилхан газрын эздийн асуудал бас яригддаг. Жишээлбэл 2012 онд газраа чөлөөлөөд газар чөлөөлөхдөө 001 тоот гэрээгээр газраа чөлөөлсөн иргэн 12 жилийн хугацаанд орон сууцдаа орж чадаагүй хүлээлттэй байх жишээний. Одоо бид өнгөрсөн хугацаанд төслийг хэрэгжүүлэгч “Грийн Ресурс” компанитай хэд хэдэн удаагийн уулзалтыг хийсэн байдаг. Энэ удаагийн уулзалт дээр бид нар ерөөсөө ямар нэгэн гаргалгаанд бол хүрээгүй.

Дээрээс нь бид 2026 оны 04 сарын 20-ны өдрөөс хойш тасралтгүйгээр бүтэн 1 сарын хугацаанд барилгын гадна талбайд гэр бариад тайван жагсаал цуглаан хийж өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалах гэж байна. Энэ өнгөрсөн хугацаанд бидний гэрээг бол шинэчилье гэсэн асуудал яригддаг. Анх бол 2022 онд хийгдсэн

гэрээг маань 26 оны 05 сарын 17-ны байдлаар шинэчилж ирүүлэхдээ маш олон заалтыг бол хасаж ирүүлсэн байдаг. Жишээлбэл, би энэ дээр татварын хуулийг зөрчсөн гэрээг бидэнд санал болгож байна гэдгийг цохон дурдмаар байгаа юм. НӨАТ-ын баримт олгоно гэсэн заалтыг шинэчилсэн гэрээн дээр хасаж оруулж ирсэн.

Тэгээд өнгөрсөн хугацаанд 2022 оноос хойш хэрэгжиж байгаа энэ гэрээний үүргийг шинэ шинэчилсэн гэрээн дээр хадгална гэдгийг ерөөсөө тусгаж өгөөгүй ийм асуудлууд яваад байгаа. Бид бол тал талын шатны байгууллагуудад хандаж үзсэн боловч яг өнөөдрийн байдлаар бид нар хуулийн хүрээнд, өмгөөллийн хүрээнд очоод мухардалд хүрчхээд байгаа юм.

Тэгэхээр бид энэ Байнгын хорооны хуралдаан дээр юуг илүү асууя гэж бодсон бэ гэхээр Байнгын хорооноос ажлын хэсэг байгуулаад тус компаниуд дээр шалгалт оруулаад яг хаана нь ингээд энэ төсөл гацчихаад байгаа юм бэ, үнэхээр иргэдээс хамаараад байгаа юм уу, туслан гүйцэтгэгчээс хамаараад байгаа юм уу юм уу, төрөөс хамаараад байгаа юм уу энэ бүх асуудлыг ажлын хэсэг байгуулаад хуулийн хүрээнд яаралтай шийдэж, маш олон иргэдийн эрх зөрчигдөөд байгаа энэ асуудлыг төрийн хэмжээнд анхаарч өгөөч ээ гэдэг хүсэлтийг тавихаар ирсэн юм. Баярлалаа.

**О.Номинчимэг:** Тэгээд энэ төсөлтэй холбоотойгоор бид бас өнөө түрүү 7 хоногт уулзсан уулзалт дээр бас манай Сарнай гишүүн мэдэж байгаа. Мөнхтуяа гишүүн мэдэж байгаа. Золжаргал гишүүн өнөөдөр түр чөлөөтэй байгаа учраас оролцоогүй байна. Тэгээд яг энэ төсөлтэй холбоотой бид нар энэ уулзалтын үеэр хэлсэн. Дэмбэрэл гуай өнөөдөр ирсэн байна. Дэмбэрэл гуай байна уу? Дэмбэрэл гуай асуудал бол байгаа. Тэгээд өнөөдөр энийг ер нь яаралтай бид нар ингэж шахаж явах нь зүйтэй юм байна гээд шийдээд ингэсэн бас нэг учир шалтгаан бол Дэмбэрэл гуайн асуудал байгаа.

Тэгээд Дэмбэрэл гуай анх энэ 2013 онд дахин төлөвлөлтөд энэ төсөл ороод 13 онд өөрийнхөө газрыг чөлөөлж өгсөн боловчиг 13 жилийн дараа одоог хүртэл орон сууцад орж чадаагүй ийм нөхцөлтэй байгаад байгаа юм. Тэгээд газрыг нь чөлөөлөөд авсан уу? Авсан. Тэн дээр яах вэ байршлын асуудал яригддаг юм байна лээ. БГД-ийн асуудал болохоор манай тойргийн гишүүд Одонтуяа гишүүн Засаг даргаар ажиллаж байсан. Золжаргал гишүүн бас нэлээн сайн энэ асуудлыг ойлгож мэдээд бас яаралтай шийдвэрлэх хэрэгтэй байна гэдэг асуудлыг хэлж байсан. Тэгээд энэ асуудал энэ хүнийг бүтэн 13 жил газрыг нь чөлөөлж авчхаад одоо хүртэл байранд оруулаагүй байгаа явдал бол хууль, эрх зүйн асуудал гэхээсээ илүү бараг хамгийн ойлгомжтой асуудал байгаад байгаа байхгүй юу. Энэ хүний асуудлыг яаралтай шийдэж өгөөч ээ гэсэн боловчиг бидэнд бол яах вэ өнөөдөр өглөө хариу ирсэн байна л даа. Өнөөдөр төслийн энэ компанид тодорхой хугацаанд та нар энэ хүмүүс энэ ойлгомжтой байна шүү дээ 13 жилийг нь хүлээж байгаа хүнд байрыг нь шийдэж өг гэдэг асуудал байсан боловч ерөөсөө хариултыг нь бол хангалтгүй гэж би харж байгаа. Бичгээр өнөө өглөө дөнгөж бидэнд мэдээлэл гүйцэтгэх захирал Ганзоригоос ирсэн байна. “Грийн ресурс”-оос.

Тэгээд энэ хүн бол байранд 8 дугаар 800-гийн Си гэдэг байранд л орох ёстой юм гээд. Тэгээд 13 жил хүлээлгэжхээд энэ төсөл орсны дараа л байна гэдэг хариултыг өгч байгаа нь бол маш зохимжгүй байна гэж харж байгаа. Тэгэхээр энэ дээр бол бид ялт ч үгүй ажлын хэсэг байгуулахаар бас ажиллаж энэ асуудлыг

шийдэхийн төлөө Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн, тойргийн гишүүд ч гэсэн анхаарч ажиллана гэдгийг нэмж хэлье.

Тэгэхээр Баярмаагийн хувьд бол энэ төсөлтэй холбоотойгоор яаралтай ажлын хэсэг байгуулж, хянан шалгаж өгөөч ээ гэдэг асуудлыг ярьж байгаа тээ. Өнөөдөр байгууллага маань ирээгүй учраас бас тодорхой нарийн тэнд асуултад хэлэлцүүлэг бол явахад хэцүү, боломжгүй байгаа. Бид өмнө нь ярилцахад байгууллага маань туслан гүйцэтгэгч нартай, түүнтэйгээ нийлж байгаад 1байрыг 2 иргэнд, 3 иргэнд ингээд давхар бас зарсан асуудлууд байгаад байгаа. Энэний хариуцлагыг хэн хүлээх вэ гэдэг асуудал бас маш их тулгамдаж байгаа байгаад байгаа.

Тэгээд хариуцлагаас зугтах асуудал байхгүй. Дахин төлөвлөлтөд хэн гэрээлэгчээр орсон байна. Энэ бол өөрөө төрийн өмнө бас үүрэг хүлээх ёстой шүү гэдгийг бид анхааруулж хэлсэн байгаа. Тэгэхээр энэ байгуулагдах ажлын хэсэг бол энэ дээр анхаарч ажиллана гэдгийг хэлмээр байна.

Дараагийн иргэн “Басмаа констракшн”-тай холбоотой Сонинтуяа 1 номерын микрофоныг өгье.

**Ч.Сонинтуяа:** Энэ Өргөдлийн байнгын хорооныхоо хуралд бид бүхнийг хүрэлцэн оролцуулж байгаад бас маш их баярлалаа. Минийх болохоор бол, миний нэрийг бол Сонинтуяа гэдэг. Манайх болохоор СБД-ийн 9 дүгээр хороонд баригдаж байгаа “Басмаа” гээд 132 айлын орон сууцын асуудлаар байгаа. 2013 онд бол 7 дугаар хороо нэрээр дахин төлөвлөлтөөр энэ газрыг чөлөөлсөн. 2015 оноос эхлэн ер нь бол захиалгаа авч эхэлсэн. 15 оноос хойш өнөөдрийг хүртэл 11 жил энэ байр ашиглалтад ороогүй байна. Энэ байр ашиглалтад ороогүйгээс болоод ерөнхийдөө 200 гаран хохирогч бол энд бол хохирсон. Сэтгэл санаа, мөнгө санхүү, амьдрал, амь насаараа ингээд хохирсон иргэд бол байгаа. Энэ дээр би юу гэж хэлэх гээд байна вэ гэхлээр хаа хаанаа хяналт ерөөсөө байхгүй юм болов уу гэж харж байгаа.

Дахин төлөвлөлт гэдэг нэрээр хэрвээ байр баригдаж байгаа бол энэ дахин төлөвлөлт чинь өөрөө хотын өнгө өнгөц, түгжрэл, утаа гэдэг ч юм уу тэр тал руугаа ингээд олон тал руугаа чиглэсэн байдаг байх. Гэтэл хяналтаа тавьж чадахгүй байж байж дахин төлөвлөлт гэж ярих бас аягүй хүндрэлтэй байгаад байгаа байхгүй юу.

Дээрээс нь энэ хууль хяналтын байгууллага аягүй хариуцлагагүй ханддаг. Хууль хяналтын байгууллагаар явахаар бид нар нэмээд санхүү мөнгөөрөө, цаг заваараа хохирдог. Жишээлбэл, энэ “Басмаа” компанийн энэ байран дээр байцаагч нар нь бол маш олон удаа солигддог. Ингээд удаа дараа ингээд байцаагч солигдох толонд байцаалт өгөөд явдаг. Дараагаар нь ингээд очоод авангуут энийг ямар хүн хүлээж авсан, өмнө нь ямар хүн энэ хүнд ямар өргөдөл өгөөд ямар хэдэн хохирогч байгаа юм, хэдэн хүн тэр хүнтэй уулзсан юм гэдгийг дараагийн байцаагчдаа дамжуулж өгдөггүй юм байна лээ.

Тэгэхлээр ингээд хуулийн хяналтын байгууллагад бол хандана гэдэг маань итгэл алдарсан ерөнхийдөө бүх хохирогч нарын хувьд бол аягүй итгэл алдарсан асуудал болж байгаа.

Дээрээс нь Улсын бүртгэлийн газарт 30-70 хувийн гүйцэтгэлтэй байж байж бүртгэл үүсгэх ийм эрх байдаг юм байна лээ. Тэрийг яг ямар үндэслэлээр бас

ингээд бүртгүүлээд байдаг юм бол оо? Тэрийг бас аягүй их гайхаж байгаа. Тэгээд бас Барилга, хот байгуулалтын яам бас энэ юуг өгөхдөө, эрхийг өгөхдөө, барилга барих эрхийг өгөхдөө ямар үндсэн дээр энэ тендерийг өгөөд байдаг юм, ямар үндэслэл дээр энэ барилга барих зөвшөөрлийг өгөөд байдгийг бас ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхлээр ингээд давхар давхар энэ улсын байгууллагуудын ийм сул хяналтгүй байдлаас болоод ард иргэд маш ихээр хохирч байна. Эндээс болоод үнэхээр их хохирч байна. Одоо бүхэл бүтэн 11 жил газраа чөлөөлсөн хүн маань ингээд 13 жил жишээлбэл байрандаа ороогүй. 13 жил газраа чөлөөлж өгсөн хүн маань эцэг, эхээ алдаад, хань ижлээ алдаад энэ байрандаа орж чадахгүй одоо хүртэл ингээд байж байна.

Тэгээд энэ хуульд хяналтын байгууллага, дахин төлөвлөлтийн газар энэ Барилга, хот байгуулалтын яам эд нар маш ийм хяналттай ажиллаж болдоггүй юм уу? Жишээлбэл барилга баригдлаа гэнгүүт эхний 3 давхар баригдчихсан байгаа барилга дээр юу гэдэг юм энэ барилга 5 жилийн дотор, эсвэл 3 жилийн дотор баригдчихсан байх ёстой гэдэг ч юм уу тийм юмыг хэрэгжүүлж болдоггүй юм уу? Эсвэл тэрийгээ хянаад явж болдоггүй юм уу? Төлөвлөлтийн.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Хяналттай холбоотой асуулт хөндөж байна. Бас л дахин төлөвлөлттэй холбоотой 12 жил болж байгаа төсөл байна тээ? СБД 14 онд анх барилгын суурь тавигдсан гэж байна. Энэ хяналттай холбоотой, хяналт сул байгаатай холбоотой маш ийм олон асуудал байгаа. Тэгэхээр барилгын яам хариулах уу? Одоо та бүхэн энэ хяналтыг сайжруулах тал дээр бодлогын хүрээнд ямархуу арга хэмжээ авч байна? Хууль, эрх зүйн орчноо бас өөрчлөх гээд ажиллаж байгаа гэж би ойлгож байгаа. Танай дээр ирсэн мэдээлэл ямар юутай байна? Дахин төлөвлөлтөөс бас нийслэлээс ирсэн байгаа тулгамдаж байгаа асуудал байвал бас хэлээрэй. 5 номер Найрамдал.

**Б.Найрамдал:** Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, газрын дарга Найрамдал. Орон сууцын энэ зөрчилтэй холбоотой иргэддээ 05 сарын 05-нд салбарын сайд хүлээж авч уулзсан. Ингээд тодорхой үүрэг чиглэлүүдийг өгөөд өнөөдрийн байдлаар Барилга, хот байгуулалтын яаман дээр ажлын хэсэг гараад ажиллаж байгаа.

Ажлын хэсгийн дүн тайланг 06 сарын 01-нд сайдад танилцуулаад ингээд сайд эргэн танилцуулах ийм чиг үүрэгтэйгээр явагдаж байна. Манай тус яаман дээр нийтдээ Өргөдлийн байнгын хороо төрийн бус байгууллагууд иргэдээс ирсэн гомдолтой холбогдуулан 32 төсөл, арга хэмжээ, 1 гомдол бол анх ирсэн. Ингээд ажлын хэсэг гараад өнөөдрийн байдлаар бид бүхэн жагсаалт гаргаад ингээд тухайн байршлуудыг үнэн, зөв нэршлээр нь тодорхойлох ажлыг хийгдээд явж байгаа. Үүн дээр нийтдээ өнөөдрийн байдлаар бид бүхэнд 52 төсөл, арга хэмжээг татан авч энэ тандалт судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээд ингээд явж байгаа.

Үүнтэй холбоотойгоор бид бүхэн бас энэ байршлуудыг тодорхойлох иргэдийн бас өгсөн зарим мэдээллийн нөгөө нэршлийг үнэн бодитой болгох байдлаас зөвшөөрөл олгож байгаа байгууллагууд руу бол бид нар албан тоотуудыг явуулсан. Ингээд холбогдох хуулийн дагуу өнөөдөр барилгын зөвшөөрлийг бол, барилгад олгож байгаа үе шатын зөвшөөрлүүдийг бол аймаг, нийслэлийн Засаг дарга нар бол олгож байгаа эрх, үүргээрээ.

Энэ дээр бол архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг батлах, барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг олгох гэх мэтчилэн төлөвлөлттэй холбоотой зөвшөөрөл гэх мэтчилэн зөвшөөрлийг бол нийслэл дээр олгогдоод ингээд явж байгаа. Үүнтэй холбоотойгоор бид нар бол тодруулгуудаа аваад явж байгаа. Одоо яаман дээрээ хийгдэж байгаа ажлын хэсэг дээр бол өнөөдрийн байдлаар бид бүхэн 52 төсөл, арга хэмжээний 25 төсөл, арга хэмжээн дээр нь газар дээр нь очих, мөн тухайн төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай уулзалт, хандалтуудыг хийгээд явж байгаа.

Товчхон мэдээллээ цааш нь үргэлжлүүлээд хэлээд дуусгачихъя гэж бодож байна. Өнөөдрийн байдлаар архитектур төлөвлөлтийн даалгаварт 25 төсөл, арга хэмжээ байна. Загвар зураг баталсан 16 төсөл, арга хэмжээ байна. Техникийн нөхцөл бүрэн олгогдсон 8 төсөл, арга хэмжээ байн. Магадлалын дүгнэлт баталгаажсан 16 төсөл, арга хэмжээ байна. Барилгын ажлын эхлэх зөвшөөрөл олгогдсон 16 төсөл, арга хэмжээ байна. Мөн мэдээллийг тодруулах ийм 20 төсөл, арга хэмжээ өнөөдрийн байдлаар явж байна.

52 төсөл, арга хэмжээнээс барилгын ажлын явц болон газар дээрх нөхцөл байдал дээр бас бид бүхэн танилцаад явж байгаа. Үүнтэй холбоотойгоор барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа 15 төсөл, арга хэмжээ байна. Барилгын ажил удааширсан байгаа 4 төсөл, арга хэмжээ байна. Барилгын ажил зогссон 15 арга хэмжээ байна. Барилгын ажил буюу огт барилгын үйл ажиллагаа эхлээгүй байгаа төсөл, арга хэмжээ бол 4 байна.

Ингээд шүүхийн шүүх хяналтын байгууллагад явж байгаа 4 шүүхийн шийдвэр гарсан 2.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Нэгдсэн мэдээлэл бол тусдаа юу яах байх. Одоо яг энэ иргэдийн яг энэ тухайлсан асуудал дээрээ бид нар анхаарч байгаа тийм үү тээ? Бодлогын асуудал бол мэдээж явж байгаа. Тэгэхээр сая энэ “Басмаа констракшин”-тай холбоотой хэлж байгаа юм 1 дүгээрт хяналт. 2 дугаарт хариуцсан байцаагч ерөөсөө их солигддог. Ингээд хэрэг маань ерөөсөө удаашраад байдаг гэдэг асуудал ярьж байна. Энэ дээр “Басмаа констракшин”-тай холбоотой эрүүгийн хэрэг нээгдсэн байна уу, энэ дээр хэр удаж байгаа юм бэ, хэдэн удаа солигдоод байна анхаарч байгаа юм байна уу гэдгээр цагдаа мэдээлэл байна уу энэ дээр? Микрофонтой газар очиж суух байх даа. Зөвхөн дугаартай микрофон дээр очихоор байна уу? Түр солигдчихъё. 1 номер дээр.

**Б.Батдэлгэр:** Цагдаагийн ерөнхий газар мөрдөн шалгах албаны дэд дарга хурандаа Батдэлгэр. “Басмаа констракшн”-д холбогдох 2 хэрэг Чингэлтэй, СБД-ийн цагдаагийн хэлтсүүдэд хэрэг бүртгэлтийн хэрэг нээгээд шалгагдаж байна. Сая иргэн Сонинтуяагийн өгсөн мэдээллийг бас бид тэмдэглэж авлаа. Тэгээд энэ мөрдөн байцаагч, мөрдөгч солигдсон асуудлуудыг бид нар бас нягтлаад газар дээр нь бас иргэнд бас мэдээлэл хариу өгье.

**О.Номинчимэг:** Энэ асуудлууд дээр манай гишүүд бас дараа нь асуулт асуух, үг хэлэхдээ энэ хөндөх асуудлуудыг бас хөндөж бид нар бодлогын хүрээнд асууж болно. Гол нь иргэд бол иргэд өөрсдийнхөө үнэхээр давж туулж байгаа асуудлууд, бид нар бол өмнө нь уулзалтаар үнэхээр ингээд хувь хүний хувьд ч гэсэн эмзэглүүлмээр зөндөө асуудал байгаа. Энийгээ та бүхэн маань сайн байр сууриа илэрхийлж, нээлттэй, энэ төлөөлж байгаа хүмүүстээ илэрхийлээсэй гэж би

хүсэж байна. Тэгж байж бид нар энд дорвитой арга хэмжээ авах тал дээр ч гэсэн анхааралд оруулж явах ёстой байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

Дараагийнх нь бид энэ “Багш 5000, эмч 3000” хөтөлбөрт хамрагдсан хохирсон иргэдийн төлөөллөөс сонсьё гэж бодож байна. Хувьцаат орон сууцын хөтөлбөртэй холбоотойгоор энэ дээр төлөөлж хэлэх хүн 6 номерын микрофон дээр та нөхцөл байдлаа, ямар асуудал болсон гэдгээ бас хэлээрэй гээд хэлмээр байна.

**Л.Нямсүрэн:** Хохирогч бид нарын өргөдлийг хүлээн авч явж өнөөдөр Өргөдлийн байнгын хурлаар авч үзэж байгаад баяртай байна. Хувьцаат орон сууц төслийн хохирогч бид өнөөдөр төлөөлөл болоод 48 багшийг нь төлөөлөөд 1 тэрбум 75 сая төгрөгийн ийм хохиролтой ийм асуудлаар Өргөдлийн байнгын хороонд хандсан.

Энэ “Өргөө ногоон хөгжил” буюу анхны компани бол “Ногоон хөгжил” хувьцаат компанийн байсан. “Ногоон хөгжлийн үндэсний нэгдэл” хувьцаат компани. 2020 оноос өгсүүлээд “Багш 5000, эмч 3000” гэсэн төсөл хэрэгжүүлэхээр энэ үйл ажиллагааг эхлүүлсэн байгаа. Энэ төслийг хэрэгжүүлэхдээ “Монголын багш нарын шинэ зуун зөвлөлдөх зөвлөл” ТББ-тай хамтарч энэ үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ энэ тухайн компани нь бол ямархуу байдлаар явуулж зохион байгуулалт хийсэн бэ гэхлээр энэ үйл ажиллагааг бол Монголын багш нарын 7 дугаар хурлаас гарсан багш нарыг орон сууцжуулах хөтөлбөр дээр үндэслэж 1 дүгээрт явуулсан байгаа.

2 дугаарт, Боловсрол, шинжлэх ухааны яамны тухайн үеийн сайд Энх-Амгалан сайдтай бол уулзаж багш нарын төлөөллийг уулзаж тухайн үеийн Боловсрол, шинжлэх ухааны яам энэ асуудлыг дэмжсэн байгаа. 2021 оны 03 дугаар сард одоогийн Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх тухайн үеийн Монгол Ардын намын дарга мөн энэ асуудал дээр багш нарын асуудлыг дэмжиж Боловсрол, шинжлэх ухааны яаманд хүсэлт гаргаж дэмжиж ажиллана уу гэсэн хүсэлт явуулсан.

Дээрээс нь энэ төслийг хэрэгжүүлэх гээд тухайн байгууллага тухайн сургуулиудын үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудыг бол нэлээн үйлдвэрчний хорооны дарга нарыг хамруулсан. Ингээд бол 2022 оны 08 дугаар сар гэхэд нийтдээ бол 1729 багштай гэрээ хийснээс 666 багш нь бол гэрээгээ цуцалж, 105 багш нь бол орон сууцад орж, 658 багш бол одоо хүртэл, өнөөдрийг хүртэл бол орон сууцад ороогүй, буцаалтаа авч чадаагүй ийм хохиролтой байгаа юм.

Тэгэхээр энэ төсөл нь ямар төсөл байсан гэх дээр өөрөөр хэлбэл 1 дүгээрт хүүгүй, 2 дугаарт урьдчилгаагүйгээр та бүхэн орон сууцад орно. Тэгээд үл хөдлөх хөрөнгөө барьцаалаад, хувьцаа гаргуулаад, хувьцаанаасаа ноогдол ашгаа аваад ингээд орон сууцад орно гэсэн ийм 36 сарын хугацаатай ийм гэрээ байгуулсан.

Ингээд гэрээний хугацаа саяын миний хэлсэн өөрөө 105 багш байранд орсон. Өөр багш нар байранд ороогүй. Яваандаа яасан асуудал яаж хүндэрсэн бэ гэхлээр нөгөө олон багш нар орж чадахгүй учраас буцаан олголтын асуудлыг 2022 оны сүүлээс шийдсэн. Өөрөөр хэлбэл энэ төсөл хэрэгжээд 2 жил, бараг 3 жил орчим болоод ерөнхийдөө буцаан олголт эхэлсэн байгаа. Тэгээд тэрнээс хойш бол үлдсэн багш нарыг бол мөнгийг нь буцаан олгоно, орон сууцад оруулна гэдэг байдлаар нэлээн удаан хүлээлтэд оруулсан.

Энэ гэрээнд заасан асуудлыг бол бид нар бол нэлээн хүлээцтэй хандсан. Багш нар бол идэвхтэй хурал зөвлөгөөнд нь идэвхтэй оролцож, компанийн зүгээс тавьсан асуудал дээр нэлээн хүлээцтэй хандсан. Ингээд 2023 оноос хойш байр худалдан авах үйл ажиллагаа байхгүй, компанийн үйл ажиллагаа доголдолд орсон учраас компани бидэнтэй яасан бэ гэхлээр Мастер гэрээ гэдэг гэрээ анхны гэрээ өөрчлөгдсөн. Мастер гэрээ гэж гэрээ нь дараа нь дагаад 5 гэрээ батлагдсан. Энэ яах вэ гэх дээр Монголын Санхүүгийн зохицуулах хорооноос бид нар зөвшөөрөл авч байгаа, удахгүй ингээд нөгөө хаалттай хувьцаа гаргана гэж хэлээд “Стандарт инвест” компанитай бид нартай гэрээ байгуулаад.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Баярлалаа танд. Энэ асуудалтай холбоотой бид бас Санхүүгийн зохицуулах хороог дуудсан байгаа. Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны дарга Цогтгэрэл ирсэн байгаа. Тэгээд энэ асуудлыг бас манай Байнгын хороон дээр өмнөх гишүүд маань бас хаалттай хуралдаан дээр бид нэлээн хэлэлцэж нарийвчилж энийг бас судлах ёстой гэдэг дээр та бүхнийхээ бас дуу хоолойг ингээд сонсохоор урьсан байгаа гэдгийг хэлмээр байна.

Тэгээд энэ орон сууцын асуудал чинь ерөөсөө зүгээр орон сууц биш бараг хувьцаа хэлбэрийн ийм санхүүгийн хэлбэр рүү шилжээд явж байгаа дээр бид энд ямар хяналт тавьж байна гэдэг дээр маш сайн анхаарахгүй бол дараа дараагийн бараг ийм шатдаа орж байгаа харагдаж байгаа. Тэгээд энэний жишээ бол энэ “Багш 5000, эмч 3000” гэдэг энэ төсөл байгаа юм байна гэдгийг харж байна.

Одоо ингээд орон сууц захиалга буюу 8 багц асуудалтай холбоотой иргэдийнхээ байр суурийг сонсьё гэж бодож байна. “Авес гранд” ХХК-ийн хохирогчдын төлөөлөл Солонгоо таныг хэлнэ үү гэж урьж байна. 2 номерын микрофон.

**Ш.Солонго:** Өнөөдрийн Байнгын хорооны хурлаар та бүхэн энэ нийт орон сууц захиалаад тохирсон иргэдийн асуудлыг ингээд бас төрийн хэмжээнд авч хэлэлцэж байгаад бас та бүхэндээ талархал илэрхийлье. Ер нь бол энэ нийт орон сууц захиалаад тохирсон иргэдийн асуудал бол бүр гамшгийн хэмжээнд хүрлээ манайхан. Одоо та бүхэн бол өнөөдөр нэг цөөхөн хэдэн гишүүд л энэ нийт орон сууц захиалаад хохирсон иргэдийг яриад байна. Энэ залиланг яриад байна. Би бол бүх 126 гишүүн бүгд анхаараасай гэж хүсэж байна. Улсын Их Хурал дээрээ, Засгийн газар дээрээ энэ асуудалд анхаараасай гэж хүсэж байна. Тэгэхгүй бол та 126 гишүүдийн ард бүх хороодод чинь, бүх дүүрэгт чинь энэ орон сууц захиалаад тохирсон иргэд чинь байгаа шүү манайхан. Тэгэхээр энэ асуудалд анхаарлаа хандуулахгүй бол хохирогчдын асуудал маш хүнд тал руугаа бүүр шилжээд байна. Бүүр туйлдаж байна.

Энэ яагаад асуудал үүссэн гэдгийг та бүхэн мэдэж байгаа шүү дээ хууль, эрх зүйн орчин муугаас, хуулийн цоорхойгоос л бид ингэж хохирчхоод байгаа байхгүй юу. Тэрнээс биш бид нар зүгээр нэг гудамжинд явж байгаа иргэнд байр захиалаад мөнгөө өгчхөөд алдчихаад байгаа юм биш. Бид өнөөдөр 3 хоногийн дараа биш, 3 долоо хоногийн дараа биш өнөөдөр 3-12 жилийн дараа бид нар ярьж байна. Жишээ нь би гэхэд 7 жил, захиалга хийгээд 7 жил хүлээгээд өнөөдөр ингээд би хохироод явж байгаа иргэн байна.

Би одоо яг бид нар 1, 1 барилга яриад байхаасаа илүү нийт барилгын хохирогчдоо төлөөлөөд нийт барилгын орон сууц захиалаад хохирсон иргэдээ

төлөөлөөд бид нар нэгдэл байгуулагдаад явж байгаа. Бид нар 1, 1 барилгаар маш олон жил тэмцлээ. Тэгээд үр дүнд хүрсэнгүй. Тийм учраас бид нар нийт орон сууц захиалаад хохирсон иргэдээ төлөөлөөд би дуугарч байна гэж та бүхэн ойлгоорой. Бид 04 сарын 13-нд жагсаал хийсэн байгаа. Энэ жагсаалаар яг албан ёс тоогоор бол 350 иргэн, албан бус тоогоор 450-500 иргэн ирж энэ жагсаалд оролцсон байгаа.

Бид нарт ирсэн мэдээллээр 60-аад төслийн 15 мянгаад захиалагч үүний ард гэр бүл бас хамт хохироод явж байдаг. Тэгэхээр 70 гаруй мянган иргэн хохирчхоод байна. Нийт орон сууц захиалаад хохирсон иргэд. Одоо би энэ 05 сарын 05-нд Барилга, хот байгуулалт, орон сууцжуулалтын яамны сайд Бат-Амгалан сайдтайгаа бид нар уулзсан байгаа. Тэгээд сайд маань ажлын хэсэг байгуулаад барилгынхан ажлын хэсэг царцсан барилгуудаар яваад бас үр дүнтэй яваасай гэж хүсэж байна. Би та бүхэн зөвхөн энэ ажлын хэсэг байгуулагдаад даргадаа үүрэг даалгавраа тайлагнахын төлөө биш, бид нарыг битгий тайлангийн шошго болгоорой. Та бүхэн үр дүнтэй ажил хийгээд цаашдаа бид нарт ямар гарц гаргалгаа, шийдэл байна вэ гэдэг дээр та бүхэн анхаарахгүй бол үнэхээр энэ нийт орон сууц захиалаад хохирсон иргэдийн асуудал бол бүүр үнэхээр хүндэрчхээд байна. Тийм учраас та бүхэн энд анхаарлаа маш сайн хандуулж өгч углуургаар нь, ул суурьтай хандаж өгөөсэй гэж хүсэж байна.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Солонгоо иргэдийн төлөөллийн зүгээс бидэнд бас маш ажил хэрэгч саналуудыг өмнөх хуралдаанууд дээр тавьсан. Тэр бүгдийг нь бид бас хууль санаачлах хүрээнд дараа дараагийн алхмын хүрээнд бас анхаарч ажиллана гэдгийг бас хэлмээр байна.

Дараагийн иргэдийн төлөөлөл “Эбо даймонд” ХХК-тай холбоотой хохирогчдын төлөөлөл Дашбат таныг 2 номерын микрофонд урьж байна.

**Б.Дашбат:** Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Би бол “Эбо даймонд” компанид хохироод 240 иргэнийг төлөөлөөд ярьж байгаа хүн байна. Нэг бүхэл бүтэн Чойр. Чойр аймаг хэдэн хүнтэй вэ яг тэрэнтэй адилхан иргэд хохирчхоод байна. Бид нар амь насаа алдах, орон байрандаа орж чадахгүй, салах энэ энгийн үзэгдэл биш шүү дээ. Энийг яагаад ийм энгийн үзэгдэл юм шиг ингэж ойлгож байгаа, ойлгогдох хэмжээнд хүрчхээд байна. Тэгэхээр энэ дээр Улсын Их Хурлын гишүүд болон Байнгын хороо анхаарал хандуулж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм.

Энэ дээр би эхлээд гол юмаа хэлчихье. Бид нарын энэ асуудлыг сонсголын хэмжээнд аваачаад сонсгол зохион байгуулж өгөөч ээ гэж хүсэлт тавьж байгаа юм. Яагаад сонсгол зохион байгуулах вэ? Яагаад гэвэл энэ барилгын компаниуд дээр аудит оруулмаар байна 1 дүгээрт нь.

2 дугаарт нь энэ урьдчилсан тэмдэглэл хийлгэмээр байна. Энэ барилгууд баригдахгүй байгаа шалтгаан болохоор ердөөсөө давхардуулж зарсан, үл хөдлөх дээр бүртгэл байхгүй, хяналт байхгүй, залилангаа нууж байгаа юм. Тэгээд аудит оруулсны дараа хэрвээ энэ сонсгол зохион байгуулаад өгвөл компаниудыг 2 ангилаад үнэхээр бас санхүүгийн эрсдэлд орчихсон компаниуд ажлаа явуулъя гэж байгаа компани байж бас болзошгүй. Залилан хийчихсэн компаниудыг нь дампууруулаад дараачийн бид нарын гарц гаргалгаа бол Цагаан хаалга л болчхоод байгаа. Цагаан хаалганы хохирогчид хэдэн жил явж байж өөрсдөө барилгаа барьж дуусгаж байна шүү дээ. Бид нар энд тэнд очиж худлаа юм яриад энэ ажил явахгүй байна. Сонсголын арга хэмжээнд аваачиж өгөөч ээ гэж хүсэж

байна. Ард иргэд байрандаа орж чадахгүй амь насаа алдах энгийн үзэгдэл биш шүү дээ. Бид нарын цаад талд нь төлөөлөөд ирж чадахгүй байгаа өчнөөн хүн байна. Гадаадаас, дотоодоос, малчид. Зөвшөөрөлд итгээд, хэн нэгний рекламд итгээд, оддын үгэнд итгээд захиалгаа өгч байгаа бид нар. Бид нарын асуудлыг шийдэж өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

**О.Номинчимэг:** Баярлалаа. “Алаг хайрхан бугат” ХХК-тай холбоотой хохирогчдын төлөөлөл Ганболд таныг урьж байна. Микрофон, 6 дугаар микрофон дээр.

**Ж.Ганболд:** Энэ өдрийн мэндийг хүргэе. “Алаг хайрхан бугат” компанийн хохирогч Ганболд гэж хүн байна. “Алаг хайрхан бугат” компани нь БЗД-ийн 2 дугаар хороонд 30 айлын орон сууц бариад 48 болгоод зарчихсан. Нийт хохирол нь 1.2 тэрбум төгрөгийн хохиролтой. 19 оноос эхлээд 7 жил явж байна одоо. Ингээд энэ дээр бол энэ прокурор, шүүх бид нар нөгөө л луйвардуулсан луйварчдадаа гомдохоо больсон. Прокурор, шүүхийнхэнд гомдож байна. Өргөдөл бичээд өгнө, авч хэлэлцдэггүй. 6 удаа юуны гэм буруугүй шүүх хурал хуралдуулж өгөөч гэж яалаа шүүх нь хуралддаггүй.

Хамгийн сүүлд нь прокурорын эсэргүүцлээр нэг шийдэгдэх маягтай. Гэхдээ энэ хурал зарлагдаагүй явж байна одоо . Ингээд 7 жил 18 айл гудамжинд байна. Энэ асуудлыг шийдэж өгөөч ээ гээд 1 дүгээрт.

2 дугаарт энэ хууль, эрх зүйн үндэслэлээ жоохон тодорхой болгож өгөөч ээ. 2025 оны 8 сард энэ хохирогчдын төлөөллийг цагдаагийн юунд, шүүхэд шилжүүлэхдээ бүх хүнээс гарын үсэг ав гээд тийм шийдвэр гарсан юм байна лээ. Үүгээр нөгөө шүүхийнхэн чинь далимдуулаад нөгөө луйварчид нь далимдуулаад ингээд хэргийг хойшлуулаад байдаг.

Энэ яагаад хойшлуулж байна гэхээр зарим нэгэн хохирогч хөөрхий амьтан бурхны оронд явчих юм, зарим нь үнэндээ үүгээр уйлаад гадаад руу явж байна, эх орондоо дээрэмдүүлчихсэн улсууд. Ингэхээр ёстой бүгд бүх хүмүүсийг **зургуулангаар** гарын үсэг зуруулна гэж юу байх вэ дээ. 1, 2 зуруулчихад болно биз дээ уг нь бол. Гэтэл **зургуулангаар** зуруул гээд ингээд хэргийг хойшлуулаад байх юм. Энэ дээр арга хэмжээ авч өгөөч өшөө л гэж хүсэж байна. Баярлалаа.

**О.Номинчимэг:** Танайх болохоор 30 айлын орон сууцыг 45 айл.

**Ж.Ганболд:** 48 айл болгоод зарчихсан.

**О.Номинчимэг:** Давхар зарчихсан.

**Ж.Ганболд:** Тийм давхардуулаад зарчихсан асуудал одоо 7 жил явж байна.

**О.Номинчимэг:** Прокурор дээр явж байгаа юм уу, шүүх дээр явж байгаа юм уу?

**Ж.Ганболд:** Шүүх дээр явж байгаа. Шүүх нь гэм буруугүйн хурал хуралддаггүй. Ерөөсөө 6 удаа хойшилж байна. Баярлалаа.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Энэ асуудлуудыг харахаар 1 байрыг олон хүнд зарчихсан ийм ноцтой залилангийн асуудлууд бас их байгаа. Тэгээд энэ хууль

зүйн хувьд ч гэсэн ноцтой залилан. Хүн ёсны хувьд ч гэсэн энэ чинь маш их ёс суртахуунгүй асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр бол хууль, шүүх, байгууллагууд бол маш сайн анхаарч ажиллах ёстой байгаад байдаг. Манай прокуророос өнөөдөр төлөөлөл ирсэн байгаа. Энэтэй холбоотой “Алаг хайрхан бугат” гэдэг энэ компанитай холбоотой явцын мэдээлэл удааширч байгаа нь яагаад юунаас болж байна? 30 айлыг 48 айлд давхар зарчихсан асуудал байгаад 18 айл өрх энд хохироод явж байна гэдэг асуудал яригдаж байна. 1 номерын микрофоныг өгье.

**Р.Батнасан:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Улсын Ерөнхий прокурорын газрын Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын ахлах прокурор Батнасан. “Алаг хайрхан бугат” компанитай холбоотой эрүүгийн хэрэг хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулаад прокуророос бол яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн. Одоо бол хамгийн сүүлд 2025 оны 11 сарын 27-ны өдөр яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.

Өмнө нь прокуророос яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлээд БЗД-ийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 3 удаа, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс 1 удаа хэргийг мөрдөн байцаалтад буцаасан. Буцаасан шүүхийн шийдвэрт заасан ажиллагааг хийж гүйцэтгээд яллах дүгнэлт үйлдээд шүүхэд шилжүүлсэн байна.

**О.Номинчимэг:** Энэ хэргүүд дээр прокурорын байгууллага ч оролцож байгаа, цагдаа ч оролцож байгаа. Гол нь иргэдийн маань тавьж байгаа асуудал бол маш их уддаг. Процесс дээрээ нааш цааш болдог, явдаггүй гэдэг асуудлыг тавьж байгаа. Тэгээд энэ бол хүний эрхийн асуудал, хүний орон сууцтай холбоотой асуудал бол анхдагч асуудал байгаа. Тэгээд ийм асуудал дээр нь хууль, цагдаагийн байгууллага төр гэж байдаг бол иргэндээ үйлчилдэг төрийн үйлчилгээг үзүүлж байгаа бол хурдан шуурхай явахгүй бол уддаг, гацдаг ийм нөхцөл байдлаас цөхрөөд одоо энэ орон сууц захиалагчаас 1 блок дээр л гэхэд 1 төсөл дээр л гэхэд 10-аад хүн нь өөд болчихсон, хүлээж тэсэлгүй өөд болчихсон асуудлуудыг бас иргэд маань ярьж байгаа. Тэгээд хүний амьдралд 1, 2-хон удаа тохиох энэ орон сууц сайхан байртай болъё гэдэг хүсэл эрмэлзлийг нь байхгүй болгоод залилангийн гэмт хэрэг гарч байхад энэ дээр нь төр нь хурдан хүчтэй, шуурхай арга хэмжээ авахгүй бол ийм л нөхцөл байдалтай байгаа гэдгийг та хэд маань ч гэсэн анхаарч үзэж энэ асуудлууд дээр та бүхэнд бол бас энэ компаниудтай холбоотой, хэргүүдтэй холбоотой мэдээлэл авах онцгой анхаарч ажиллаасай гэж харж байгаа. Бид нар хянан шалгалтын ажлын хэсэг байгуулахаар угаасаа та бүхнийг оролцуулаад явна гэдгийг хэлмээр байна.

Дараагийнх нь “Марч констракшн” ХХК-тай холбоотой Поларис төсөл гэж байгаа. Нэлээн олон хохирогчтой төсөл байгаа. Шинэбаатар, хохирогчдын төлөөлөл Шинэбаатар 2 номерын микрофон.

**Б.Шинэбаатар:** Хүрэлцэн ирсэн бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. “Марч констракшн” нийт нийслэлийн хэмжээнд 3 байрлал дээр 13 блок барилгын төсөл 2017, 2018 оноос эхлүүлээд өнөөдрийн байдлаар 5-хан блок буюу нэг нийтдээ дунджаар 500 айлын орон сууцыг ашиглалтад оруулаад айл өрхүүдээ оруулчихсан явж байна. Үлдсэн 8 блок барилгын ажил нь жил, жил, шат дараалалтайгаар зогсоод зогсоод төслүүд нь зарим нэг нь цутгалтынхаа давхруудыг аваад үлдэгдэл ажил нь хийгдэхгүй явсаар 2025 оны байдал, ноднин бол аль ч барилга дээрээ бараг л юу ч тавигдаагүй 1 жил, ноднингоос хойш

өнөөдрийг хүртэл 1 жилийн хугацаанд төсөл нь царцсан байдалтай явагдаад байна.

Энэ төслийн гүйцэтгэгч компанийн захирал нь бас өнөөдөр хүрээд ирчихсэн, энэ хуралд хүрээд ирчихсэн байна. Тэгээд энэ төслүүд яагаад хэрэгжихгүй гол шалтгаан, гарц гаргалгаа хуулийн байгууллагаас асуудал үүсэж байгаа эдгээр асуудал байна уу үгүй юу гэдгийг нь тэр төслийн гүйцэтгэгч компаниас нь бас тодруулж байгаад гарц гаргалгаа хайж өгөөч ээ 1 дүгээрт.

2 дугаарт, энэ төсөл дээр хамааралтай захиалагч нарын хэрэг шүүх, прокурор дээр бас явж байгаа. Энэ ямархуу шатдаа явж байна? Шүүх хяналтын байгууллагуудын ер нь гүйцэтгэл, уялдаа холбоо маш удаан иймэрхүү процесс ажиглагдаад байдаг. Би хүртэл өөрөө 2019 онд захиалаад 2023 онд энэ төсөл дээр миний өөрийн захиалсан орон сууц ашиглалтад орж байсан. Бас алданги авах гээд хагас жил, жил шахуу хөөцөлдөж байж нэг тодорхой хэмжээний мөнгөн дүн авч байсан түүхтэй. Тэгтэл ер нь манай хуулийн байгууллагуудын хэрэгжилт хоорондын уялдаа холбоо маш дутуу дулимаг байна уу гэж би хараад байдаг юм.

Бас нэг зүйл нь бид нарын энэ захиалагч тал буюу хохирогч бид нарын хууль, эрх зүйн орчин маш дутуу дулимаг. Энэ гэрээ контрактыг үзэхээр дийлэнх нь компанийн талд ашигтай. Манууст нэг алданги гээд мөнгөн дүнгээр л тодорхой хэмжээний хувь тогтоогоод тэр гэрээн дээр бичигдчихсэн байдаг. Энэ удаан олон жил хүлээж байгаа хүмүүс чинь зөвхөн мөнгөн дүн биш цаана нь нийгмийн харилцааны асар олон зүйлд сөрөг үр дагавар үзүүлээд явж байдаг гэдгийг бас та бүхэн ч гэсэн ойлгох хэрэгтэй. Гэр бүл салж байна, хэн нэгнээ буруутгаж байна. Энэ хугацаанд чинь 5-7 жил хүлээчихсэн энэ хүмүүс чинь нас барж байна, өөд болж байна, ам бүл нэмэгдэж байна. Гэр бүлээ чирээд. Би бол жишээ нь 8 жил 8 удаагийн нүүдэл суудал хийж байж орон сууцдаа орж байсан түүхтэй. Тэгээд иймэрхүү маш олон сөрөг үр дагавар үзүүлдэг дүр зураг ажиглагдаад байгаа. Тэгэхээр энэ тал дээр ч гэсэн хууль хяналтын байгууллага гэрээ контрактаа шинэчилсэн найруулгадаа оруулж өгөөд захиалагч талын эрх ашгийг бас давуу тусгаж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

**О.Номинчимэг:** Баярлалаа. “Марч констракшн”-аас энэ удаагийн сонсголд бол төлөөлөөд Бадралбат гэдэг хүн ирсэн байгаа юм байна тээ? Тэгээд юунаас болоод ингээд хоцроод 3 дугаар төсөл нь бол маш ийм хоцрогдолтой байгаад энэ иргэд маань бас хохироод олон жил түрээсээр явж байна, өөд болж байна, гэр бүлийн асуудал үүсэж байна, энэ чинь нийгмийн ийм асуудал болчихлоо гэдэг асуудлыг ярьж байгаа. Үнэхээр сэтгэл өвдгөм Бадралбат байна уу “Марч констракшн”-аас? 2 номерын микрофон дээр ирээд энэ төслийн удаашрал, энэ асуудал дээр яаж анхаарч ажиллаж байгаа талаар хариулах уу? 2 номер.

**Н.Бадралбат:** Сайн байна уу? Энэ өдрийн мэндийг хүргэе. Би “Марч констракшн” компанийн захирал Бадралбат гэж хүн байна. Манай компани маань 2017 оноос хойш үйл ажиллагаагаа хийж эхэлсэн. Тэрнээс хойш бол үйл ажиллагаагаа хийгээд нийтдээ 3, 4 удаагийн комиссын үйл ажиллагаа хийж нийтдээ 800 гаран айлуудыг орон сууцаар хангасан байгаа. Энэнээс сүүлийн 3 комиссын үйл ажиллагаа маань бол КОВИД-ын дараах 23 онд 3 барилгыг комиссын үйл ажиллагаа хийсэн. Тэгэхдээ бид нар КОВИД-ын үеэр нөгөө нэг үнийн өсөлт болон хил гаалийн хаалттай байдал, ажиллах хүчний зардал эд нарын өсөлтүүдийг үл хамааран тэр өмнө нь оруулсан орон сууцуудаа бол яг

анхны захиалгын үнээрээ бид нар гэрээ хийсэн үнээрээ тэр хүмүүсийг оруулсан юм.

Тэгээд энэ дараагийн блокууд маань удааширсан шалтгаан маань бол ялт ч үгүй бид нар эдийн засгийн үнийн өсөлтөд цохиулж санхүүгийн юу маань анхны төсвөөрөө эргүүлж барилгууд маань босохгүй болох тэр нөхцөлөөс болж л ингэж барилгууд маань удааширсан байгаа.

**О.Номинчимэг:** Ингээд угаасаа гишүүд бас тодруулж та бүхнээс асуух байх гэж бодож байна. Дараагийнх нь “Сэд дэвжих” ХХК-аас хохирсон иргэдийн төлөөлөл Алтанчимэг таныг нөхцөл байдал, санал, байр сууриа нээлттэй илэрхийлэхийг хүсэж байна. 6 номерын микрофон.

**Б.Алтанчимэг:** Сайн байцгаана уу та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. ХУД-ийн 16 дугаар хороонд хэрэгжиж байгаа “Смарт таун-2” энэ цогцолбор хороололд орон сууц захиалаад хохирсон иргэд нэгдээд 25 оны 12 сард “Зөв гарц, оновчтой шийдэл” гэсэн ийм ТББ-ыг байгуулаад хохирлоо барагдуулахаар ажиллаж байна.

Одоогоор бол манай энэ ТББ-д 110 гаруй хохирогч нэгдсэн. Бид нар 114 байр захиалаад 6 тэрбум төгрөгөөрөө хохирсон байгаа. Бид бол 2020-оос 22 онуудад “Сэд дэвжих” ХХК-д орон сууц захиалсан ч одоогоор орон сууц бол баригдаагүй. 2 байр нь 5-7 давхар хүртлээ каркас боссон байдалтай байж байгаа. Энэ хугацаанд бол зарим захиалагчид маань бол нас барсан, зарим нь бол ХУД-ийн цагдаад 23 онд өргөдлөө өгсөн. Зарим иргэд нь бол иргэний шүүхэд нэхэмжлэл гаргаад шүүхийн шийдвэр гүйцэтгэх гүйцэтгэлтэй шийдвэрт хохирлоо барагдуулсан ч барагдуулаагүй ингээд байж байна.

Тэгэхээр яг 1 иргэдийн ард бол 4-5, 6, 8 ингээд хүмүүс байна. Ингээд Монгол улсын иргэд бол ингэж удаа дараа хохирч байхад бол төр засгаас ямар нэгэн анхаарал хандуулахгүй байгаад бол иргэд бол маш их хохирч, харамсаж ингээд бол бид нар олон газарт хандсан. Ингээд бол бид нар Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Хүний эрхийн Комисс, мөн Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо, Хот байгуулалтын сайдад, мөн ХУД-ээс Их Хуралд дэвшсэн Алдаржавхлан, Лодойсамбуу, мөн Бат-Амгалан, Энхбаяр гээд ингээд Нийслэлийн Засаг даргад хүртэл ингэж хандаж бид нар өргөдөл, хүсэлтээ явуулсан байгаа.

Ингээд өнөөдөр бас энэ Өргөдлийн байнгын хорооноос бид нарын энэ хохирлыг ойлгож шийдвэрлэх уулзалт зохион байгуулж байгаад бол бас их талархалтай хандаж байна. Өнөөдөр бас энэ Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр заалт төрөөс хүний эрх, эрх чөлөөг зөрчигдөөд тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх иргэнийхээ үүргийн өмнө хариуцна гэсэн ийм заалт байдаг. Гэтэл төрийн байгууллагууд, мөн албан тушаалтнууд энэ орон сууц захиалга авах нэрийдлээр иргэдийг хохироож байгаа ийм удаа дараагийн асуудалд бол анхаарал хандуулах нь бол маш удаан явж ирж байна гэж үзэж байна.

Ингээд бол та бүхнийг энэ хохирсон иргэдийн хохирлыг барагдуулах чиглэлд ямар зохицуулалт, ямар ажил хийх, цаашид энэ хүмүүсийн хохирлыг нэмэгдүүлэхгүй байх тал дээр ямар нөхцөлөөр хангах энэ талаар төлөвлөж байгаа ажлуудаас бас тодруулж асуумаар байна гэж бодож байна.

Дээр нь бас энэ оросууд захиалж байгаа энэ манай хохирогчдын зүгээс бас бас хэд хэдэн энэ саналууд бас гарсан. Энэ саналыг бас хэлье гэж бодлоо. Үүнд

бол орон сууцны төслийг бол ижил төстэй компанид бол нээлттэй тендер зарлаад эсвэл төлбөртэй болон төлбөргүй шилжүүлэх, холбогдох татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг бас эдлүүлэх, 2 дугаарт нь тухайн орон сууцын төслийг хохирогч нарт хамааралтай хэсгээр нь нэгдсэн зохи.../минут дуусав./

**О.Номинчимэг** Баярлалаа. Та бүхэн, та бас саналаа бидэнд бичгээр өгчхөөрэй. Энэ саналуудыг бас бид нар тусгаж ажиллана. Өнөөдөр энэ “Сэд дэвжих” гээд энэ холбоотой “Смарт таун-2” гэдэг төсөл юм байна. Бас төлөөлөл нь ирсэн байгаа. Манай гишүүдээс бас тодруулж дараа нь асууж юун дээрээ гацаад яагаад болохгүй байгаа каркас нь босчхоод байгаа гэдэг дээр яах байх. Бүх энэ мэдээллүүд нь бас та бүхэнд очсон байгаа гээд хэлмээр байна. Дараагийнх нь “Ток таун” ХХК-аас хохирсон иргэдийн төлөөлөл Энхбаяр. 1 номер уу тээ? 1 номер.

**Д.Энхбаяр:** Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. БЗД-ийн 24 дүгээр хорооны иргэн Энхбаяр гэж хүн байна. БЗД-ийн 19 дүгээр хороонд баригдах “Танан ордос капитал” гээд компанитай холбоотой төсөл дээр хохирсон иргэдийн 90 гаруй иргэдийн төлөөлөл болоод энд хүрэлцэн ирсэн байна.

Юуны өмнө өнгөрсөн хурлын үр дүнд хариуцагч талаас төлөөлөл авчраад асуулт асуух, хариултыг нь энэ хурлын протоколд тусгах баримтжуулах боломж олгосон Байнгын хороонд талархал илэрхийлье. Нийтдээ 4 асуулт байна.

1 дүгээрт, цагдаагийн байгууллагаас 2024 онд иргэдийн гомдлын дагуу БЗД-ийн 1 дүгээр хэлтсийн мөрдөн байцаагч 2024 оны 04 сарын 24-нд “Ток таун” төсөлтэй холбоотой яг хэдэн захиалагчтай хэдэн төгрөгийн төлбөр авсан гэх мэт мэдээллийг тодруулах санхүүгийн шинжилгээний үнэлгээг хийлгэсэн байдаг. Энэ үнэлгээний дагуу нийтдээ 6.2 тэрбум төгрөгийн хохирол учирсан гэдэг үнэлгээ гарсан байдаг.

Өнөөдрийн байдлаар бол энэ барилга маань 2022 оны 05 сараас хойш, 03 сараас хойш захиалга авсан нийтдээ 116 хохирогч байгаа. Одоо бодитоор бол 90 орчим хохирогч байна. 6.2 тэрбум төгрөгийг юунд зарцуулсан бэ гэдэг үнэлгээнийх нь хариунд бол 5 тэрбум нь барилгын ажилд зарцуулагдсан байна гэдэг дүгнэлт гарсан.

Гэтэл яг бодит байдал дээр өнөөдөр 2026 оны 5 сарын нөхцөл байдал дээр хоосон хашаа 4 жилийн хугацаанд байна. Барилга барих гэж байгаа газар нь бол хоосон хэвээрээ байна. Гэтэл тэр 5 тэрбум төгрөгөө барилгын ажилд материалд зарцуулсан гэдэг тайлбарыг нь ямар барилгын ажилд зарцуулсан бэ гэдэг нь тодорхойгүй байгаа учраас цагдаагийн байгууллагаас энийг бас дахиад дүгнэлт хийлгэх боломж байдаг болов уу? Тэр дээр дахиад шалгалт хийж өгөөч ээ гэж хүсмээр байна.

2 дугаарт нь болохоороо хариуцагч “Ток таун”-ы төлөөллөөс одоо яг өнөөдрийн байдлаар яг хэдэн төгрөгийн эд хөрөнгө танай дээр байна вэ? Энэ төслийн хүрээнд яг энэ хохирлыг яаж барагдуулах талаар шийдэл гарц байна уу гэдэг дээр Мөнх-Оргил төлөөлөгчөөс асуумаар байна. Одоо яг миний зүүн гар талд сууж байна.

2 дугаарт нь болохоороо Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон цагдаагийн байгууллагаас энэ төсөлтэй холбоотой ер нь энэ 3 сараас хойш

захиалгыг авч эхэлсэн. Хохирогчид цагдаа шүүхийн байгууллагаар явдаг. Ток-ийн зүгээс 2022 оноос хойш бий болсон хөрөнгийг тооллогод оруулж өгөөч ээ гэдэг хүсэлт байна.

Тэгэхээр энийг яаж зохион байгуулдаг юм, шүүхийн шийдвэр дээр очихоор бид нар зөвхөн шүүхийн шийдвэр гарснаас хойших эд хөрөнгийг тоолно гэдэг ийм тайлбарыг өгөөд байдаг. Тэгэхээр энэ дээр бас ингээд нийт хөрөнгө оруулсан хүмүүсийн энэ хохирлыг барагдуулах чиглэл дээр бодитой нөгөө хөрөнгө оруулчихсан баримтууд нь гарч ирэхгүй байх, эсвэл нөгөө захиалга авсан төслийн хариуцагчид маань аль хэдийн энэ 4 жилийн хугацаанд өөрсдийнхөө нэр дээр байдаг эд хөрөнгүүдийг хамаатан саднууддаа тараагаад дуусчихсан ийм нөхцөл байдалтай байгаа.

Тэгэхээр энэ Барилгын яам болон газрын албаны зүгээс тодруулах асуулт бас байгаад байгаа юм. Ток-ийн зүг зүгээс бол энэ “А” даалгавар гэдгийг газрын зориулалтыг нь өөрчлүүлэх хүсэлтийг анх тавьж байсан юм байна лээ. Энэ “А” даалгавраа авч чадаагүйгээс болоод бид нар бид нарын барилгын төслийн ажил.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Баярлалаа. Энэ дээр цагдаа саяын асуулт дээр эхлээд хариулах уу? Цагдаа энэ “Ток таун”-тай холбоотой асуудлууд юу болж байна, хяналт шалгалт, аудитын асуудал? Дараа нь төсөл хэрэгжүүлэгчийг төлөөлөөд бас ирсэн байгаа юм байна. Улсын бүртгэлээс үү? Улсын бүртгэлээс энэ удаа байхгүй байна. 2, 3 удаагийнх дээр бол Үл хөдлөхийн улсын бүртгэлийнхэн бол ирсэн байдаг. Гэхдээ хууль, эрх зүйн орчин бас дутмаг байгаа болохоор яг энэ нөгөө бүртгэлтэй холбоотой асуудлуудад нь хууль, эрх зүйн орчин дээр очоод л гацаад байгаа асуудал бас байгаа. Та гэхдээ бас дараа нь гишүүд маань асууна тэн дээр бас тодруулж болно. 1 номер.

**Б.Батдэлгэр:** Саяын “Ток таун” компанитай холбоотой хэргийг БЗД-ийн Цагдаагийн газрын 1 дүгээр хэлтсийн Мөрдөн шалгах тасгаас мөрдөн шалгах ажиллагаа явуулаад 89 иргэнд хохирсон 6.4 тэрбумын хохиролтой хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж дуусгаад 2026 оны 03 сарын 23-ны өдөр шүүхэд шилжүүлэх саналтай харьяа дүүргийн прокурорын газарт шилжүүлсэн байна.

Тэгэхээр та энэ мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой бас хүсэлтээ харьяалах прокурорын байгууллагад бас дүүргийн прокурорын газарт өгчихвөл бид тэнд бас хүсэлтийг бас хуулийнх нь хүрээнд шийдвэрлээд танд бас хариугаа өгнө гэж бодож байна.

**О.Номинчимэг:** 2 номерын микрофоныг өгөөд төсөл хэрэгжүүлэгчийг төлөөлж гүйцэтгэх захирал Мөнх-Оргил ирсэн байна. Тэгэхээр энэ хөрөнгө мөнгө нь яг юундаа зарцуулсан юм уу яагаад удааширсан гэдэг асуудлыг тодорхой та хэлэх үү? 2 номер.

**Г.Мөнх-Оргил:** Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Би “Танан ордос” компанийн гүйцэтгэх захирал 2025 оны 08 сараас аваад нийт захиалагч нарын хохирлыг барагдуулахаар ажиллаж байна. Би өөрөө бол хувьцаа эзэмшигч, 40 хувь хувьцаа эзэмшигч байдаг. Тухайн үеийн байдал, нөхцөл байдал дээрээс үзэхэд яах вэ 2019 оноос миний хувьд бол барилга бариад явж байна. 2021 онд бие даасан болон бусадтай хамтрагчтай нь нийлж төсөл хэрэгжүүлж явсан. Тэрний дагуу “Ток таун” дээр төсөл хэрэгжүүлэхээр шийдэж урьдчилсан захиалга

авч, урьдчилсан захиалга авах явцад ажил эхлэгч биш хуваарилалт, бусад холбогдох бичиг баримтуудыг хөөцөлдсөн боловч газрын зориулалт нь барилгын бус, барилгын орон сууц барих зориулалтын бус байсан учраас удааширсан шалтгаантай.

Одоо бол бид нийтдээ 6 тэрбум 400 төгрөгийн хохирлын дүнтэйгээс тэрбум 500 орчим төгрөгийн дүн хохирлыг барагдуулаад ажиллаж байна. Тухайн төслийг бол хэрэгжүүлэх зорилт тавьж ажиллаж байгаа. Үргэлжлүүлж дуусгах тал дээр хамт ажиллаж байгаа. Тухайн үед одоо яг энд хэлэлцүүлэг дээр аж ахуйн нэгж дээрх зүйл яригдахад яригдахгүй байна. Хувийн хэвшлийн зүгээс төрөөс дэмжлэг үзүүлэх тал дээр бус зөвхөн нөгөө нийт захиалагчийн хохирогчдод үзүүлэх туслалцааны талаар асуудлыг хэлэлцэж байх шиг байна.

Одоо ер нь бол шүүх шатны байгууллагад, шүүх шатан дээр, цагдаагийн байгууллага дээр болохоор манай байгууллага хувьцаа эзэмшигчид яллах дүгнэлт гарчихсан байдалтай. Нийт захиалагчийн хохирлын тоо нь 6.4-өөс 4.5 орчим тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа. Тэгээд яллах дүгнэлт гарчихсан дээр бол үндэслэл нь юу байна гэхлээр амьдрах хэрэгсэл болгосон гэдэг 17.3.3 заалтаар заасан байна лээ. Бид бол өмнө нь барилга барьж байсан амьдрах хэрэгсэл болгоогүй. Тухайн үеийн нөхцөл байдал нь зөвшөөрлүүд нь гараагүй, бидний буруутай үйл ажиллагаанд зөвшөөрөл гараагүй борлуулалт эхлүүлсэн гэдэг үндэслэл байгаа боловч гэх мэтчилэнгээр бидэнд яг одоогийн нөхцөл байдал дээр захиалагч нарын хохирлыг барагдуулахын тулд ажиллаж байгаатай хамааруулаад төр засгийн байгууллага бид нартай хамтарч ажиллаасай л гэж хүсэж байна.

**О.Номинчимэг:** Энэ төсөлтэй холбоотой бас гишүүдээс маань дараа нь асууна байх гэж бодож байна. “Гээзгийн худаг” ХХК-тай холбоотой иргэд хохирсон иргэдийн төлөөлөл Найдан таныг урьж байна. 6 номер уу тээ? 6 номерын микрофон.

**Д.Найдан:** Эрхэм хуралд оролцож байгаа хүмүүстээ энэ өдрийн мэндийг хүргэе. Би “Гээзгийн худаг” түүний туслан гүйцэтгэгч “Өндөрзаяа” гэдэг компанийн хохирогчдын төлөөлөл. Энэ хохирогч 404 хүн байгаа Эднээс байрын захиалга авч байранд оруулна гэсэн ийм худлаа залилан хийж, 165 хүнээс тэрбум 800 мянган төгрөгийг тухайн үеийн ханшаар тооцож 2012 оны үйл явдал эхэлсэн ийм их удаашралтай хэрэг байгаа.

Үүнийг би туслан гүйцэтгэгч нь байгаа юм гэж тэр “Өндөрзаяа” компанийн Должинсүрэн гэдэг захирал гэдэг, гэгддэг хүн барилга буулгуулах гадаадын том төсөл хэрэгжүүлэгч орж ирэхэд нь газрыг бэлэн болгоно гэж 6 барилгыг 57 хүнд давхардуулан гэрээ хийж, 60, 60 сая төгрөгийг тус тус авч ингэж залилан ийм том гэмт хэргийн төлөөллүүд их хэмжээний залилан хийж, нийтдээ 5 сая төгрөгийн, 5 тэрбум төгрөгийн хохиролтой ингээд явж байна.

Энэ энэ нэгжүүдийн олон хохирлыг ер нь ихэвчлэн дийлэнх хөрөнгийг бол тэр “Өндөрзаяа” компанийн Должинсүрэн өөрөө завшиж авсан хэдий ч түүгээрээ 2019 онд шүүхээр шийтгэгдээд 1 ч хүний хохирол барагдуулахгүй 300 тэрбум төгрөгөөр хаа хийсэн юм тэрийг олгогддоггүй, юуг нь барагдуулдаггүй явсаар байгаа Тэр “Өндөрзаяа” компанийн захирал тэр Наранжаргал гэдэг хүн 15, 6 оны үед нас бараад ингээд хариуцах эзэнгүй болсон ийм. Нийтдээ 404 хүний 5 тэрбум төгрөгийн ийм залилангийн асуудал дээр олон хохирогчид хүлээж зарим нь ёстой хорвоогийн мөнхийг бусыг үзүүлсээр, зарим нь сэтгэл санааны өндөр хохиролтой

ийм явж байгаа. Тэгээд энэ асуудлыг бас өндөр хэмжээнд авч үзэж барагдуулах, хохирлыг барагдуулах талын арга замыг шүүгчид хайж байгаа энэ өнөөдрийн арга хэмжээнд оролцож байгаадаа их баяртай байна. Эндээс зохих хэмжээний амжилт гарна гэж хүлээгдэж байгаа ийм нөхцөлийг бид бас зохих хэмжээгээр хүлээх тийм том хүлээлт үүсэж байна. Ингээд.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Баярлалаа. “Гэээгийн худагтай” холбоотой анхны компани нь байхгүй болоод энэ захиалга өгсөн иргэд хохирсон хариуцах эзэнгүй болсон энэ асуудал байгаа та бүхэнд очсон мэдээллээр. Ингээд Эрхэт Монгол “Зиндаа констракшн” ХХК-тай холбоотой хохирогчдыг төлөөлж Эрдэнэсүх 2 номер уу? 2 номерын микрофоныг нээе.

**Я.Эрдэнэсүх:** Би энэ “Эрхэт Монгол” группийн Ерөнхийлөгч Мандахбаяр 3 төсөл хэрэгжүүлж байгаа юм. 3 газар орон сууц. Нэг дэх нь энэ Гранд маршал гэж Сэлбийн зусланд байгаа. Энэ их онцлогтой газар. Хуучин анхны манай пионерын зуслан байгуулж байсан энэ газар. Маршал Чойбалсангийн баримал хөшөө тэнд байдаг юм. Эд нар сонгосон ийм байгалийн тогтоцтой их сайхан газар. 13 га газар ийм хотхон байгуулчихсан. Бүүр иж бүрэн 500 айлын орон сууцтай 11 объектой ийм том. Үүний зөвхөн 20-хон хувь дээр нь орон сууц барьж байгаа юм 500 айлын. Бусад 80 хувь нь үлдчихсэн. Маш гоё байгалийн газартай ийм онцлогтой. Энэ газрыг 1 хүн эзэмшээд яагаад ингээд 5 жил болж байна шүү дээ. 21 онд захиалга өгсөн. Одоо хүртэл ашиглалтад ороогүй. Энэ 80 хувийн энэ том газрыг нэг бол дуудлага худалдаанд оруулаад тэр улсуудаар бариулах ийм арга хэмжээ, ийм гаргалгаа улсаас юмаар бидний шаардлагад бол тоохгүй юм байна. 3 төслийг чинь 2 дахь нь бол Хайрын хотхон гээд 2 мянган айлын орон сууц Хөшигтийн хөндийд байна бас. Энэ газраа болохоор бол энэ байрны өрөндөө бол өгч байна шүү дээ. 1 га 07-нь 45 саяар ав гээд. Тэгээд ямарт нь ингээд 07 нь олдохгүй ямар нь 45 саяыг зардаг юм? Энэ ямар утгатай юм.

3 дахь төсөл нь бол Өмнөговь аймагт 2 блок байж байгаа 200 айлын. Бүгд ашиглалтад ороогүй. Зүгээр би захаас нь ярьж байна шүү. Ийм юм байна. Ийм гаргалгаануудыг нь энэ, тэр олон тэр том газруудыг чинь хувь хүн зарж ингэж яаж байх нь улс аваад үүгээр нь барилгыг нь бариулах ийм боломж, гаргалгаа хайвал болмоор байх юм. Тэгээд цагдаад өгөхөөр, шүүх, цагдаад өгөхөөр иргэний хэрэг гэсэн нэг хуулиар халхавчлаад тэгээд энэ хуулийн цоорхойг ашиглаад иргэний хэрэг гээд эрүүгийн цагдаад ердөөсөө тоохгүй, авч хэлэлцэхгүй иргэний хэрэг гээд шилжүүлчихээр манай олон улсад өргөдөл өгсөн. Шүүх болохоор 30-аад түмэн шийдвэр гарсан, мөнгө байхгүй гээд л сууж байдаг. Тэгээд энд нь хөөцөлдөхгүй. Өөрөө бол объектууд бол байдаг. Зөндөө объектууд бий. Би тэрийг нэрлээд байгаа. Ийм юм байна. Энэ дээр нь хуульч нь битүүмжлээд тэр энэ тэрийг нь энэ улсуудын өргөдлийг баруулж болохгүй юм уу гэсэн ийм л юм хэлэх гээд байна. Боломж бол байна ердөөсөө. Төр иргэнээ огт хамгаалахгүй байна. Энэ татвар төлөгчдийн мөнгөөр амьдарч байранд суучхаад ердөөсөө огт хамгаалж өгөхгүй байна шүү дээ. Ийм л юм байна. Би энэ 3 төслийг хамгаалж хэлж байна шүү. Мандахбаяр гэхээр бүгдээрээ мэдэж байгаа байх “Эрхэт Монгол” группийн гээд. Ийм л юм байна.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Энэ дээр Барилгын яам бас анхаарч энийг тэмдэглэж авч байгаа гэж найдаж байна. Тэгээд өнөөдөр бол ирсэн иргэдийнхээ төлөөлөл маань өөрсдийнхөө нөхцөл байдал, мэдээллийг өглөө.

Одоо энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Тэгээд гишүүд маань иргэдээсээ асууж болно. Тодруулж асуулгах, яриулах, учир байдлын тодруулах юмыг асууж болно, төрийн байгууллагаас асууж болно. Компаниудаасаа асууж болно. Дараа нь бас үг байгаа. Тэгэхээр энэ дээр энэ гол нь нөгөө энэ олон асуудал байгаа бид нар, олон ч санал гарч байгаа. Энийг бид нар аль аль түвшиндээ бүгдээрээ нэгдмэл ойлголттой болоод цаашдаа энийг шийдэхийн төлөө ямар арга хэмжээ явуулах вэ гэдэг л бидний гол зорилго байгаа учраас та бүхнийг тэр чиглэл рүү анхаараасай гэж хүсэж байна.

Ингээд нийт Пунсалмаа гишүүнээр нийт 6 гишүүнээр тасаллаа. Ирцийн дарааллаар Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууя.

**Ж.Галбадрах:** Энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд маш олон иргэд маань хохироод ингээд энэ асуудал ийм Их Хурлын хэмжээнд, Байнгын хорооны хэмжээнд ингээд яригдаж байгаа нь бол үнэхээр харамсалтай.

Гэхдээ энэ бол ингээд нүдэн дээр ил байдаг, бүх хүн мэдэж байдаг, тэгээд яригддаг. Тэгээд саяын мэдээллээс сонсоход бол жилээс жилд энэ хэргийн тоо буурахгүй ингээд ихсээд ингээд яваад байгаа нь үнэхээр бид бас ялангуяа Цагдаагийн ерөнхий газраас эхлээд хууль хүчнийхэн маань бас хангалтгүй ажиллаж байна уу гээд. Иргэд ч гэсэн хэлж байна бид нар цагдаагийн байгууллагадаа итгэхгүй байна. Үнэхээр итгэл алдардаг гээд.

Тэгэхээр би Цагдаагийн ерөнхий газраас ер нь энэ шийдвэрлэлт дээр ингээд маш тодорхой хувь бичсэн л байна л даа ямар ямар асуудлууд яаж шийдэгддэг гээд энэ дээр гол шийдвэрлэгдэхгүй ингээд удаад, цаг алдаад ингээд явдгийн гол шалтгаан нь юундаа байдаг юм бэ? Иргэд маань хуулийн цоорхойнууд маш их байна гэж ингэж ярьж байна. Мэдээж өөрсдөө хууль, цагдаагийн байгууллага дээр очоод явахад гарч ирж байгаа. Тэгэхээр энэ ямар ямар хуулийн цоорхойнууд байна? Энэ Засгийн газраас энэ асуудлуудыг бүүр ингээд тодорхой авч үзээд ямар хуулийн төслүүд санаачилж байна? Манай Их Хурлын гишүүдээс ч гэсэн энэтэй холбоотой хуулийн төсөл санаачилсан, ямар шатдаа явж байгаа талаарх хуулийн талаар нэг тодруулга авъя гэж бодож байна.

Тэгээд Засгийн газар маань боловсрол, эрүүл мэнд, орон сууцын төслүүд дээр бол гол анхаарч байгаа. Бид нар бол олон зорилтууд тавиад явж байгаа. Тэгээд энэ орон сууцжуулах энэ хөдөлгөөн бол маш далайцтай явж байгаа. Бид нар энэ газар чөлөөлөлтөөс эхлээд. Тэгээд энэ нь ингээд цаанаа ингээд маш их олон асуудал дагуулдаг юм байна. Энэ асуудлуудыг бид нар энэ бүртгэл тооцоотой энэ хар жагсаалт гаргаад явдаг, хар жагсаалтад орсон байгууллага энэ тэрийг дахиж орохгүй байлгах талаар ямар арга хэмжээнүүд авдаг вэ гэдэг талаар бас бас асууя.

Тэгээд ер нь бол бид нар маш шуурхай ажиллах хэрэгтэй байна. Одоо бид нарын Байнгын хорооноос маань ажлын хэсэг байгуулагдана. Тэгэхээр энэ ажлын хэсэг дотор бол бид олон энэ хууль саяын миний асуусан хуультай холбоотой асуудлуудыг, журамтай холбоотой асуудлуудыг нэлээн сайн цэгцлэх хэрэгтэй юм байна.

Дараагийн нэг бас асуудал энэ Барилга хөгжлийн яамнаас энэ төрийн байгууллагын буруутай үйлдлээс барилгын компани нь яг ном журмынхаа дагуу

ингээд бариад ажлаа эхлээд явж байсан, иргэд гэрээнийхээ дагуу төлбөр тооцоогоо хийгээд явж байсан. Энэний гэвч техникийн нөхцөлийг олгогдоогүй ч гэдэг юм уу, уг нь техникийн нөхцөлөө авч байгаад л барилга эхлэх ёстой л доо. Тэгээд энд тэрнээс болоод зогсох ч гэдэг юм уу, мөн газар чөлөөлөлт нь дутуу байсан ч гэдэг юм уу, тэгээд бусад зөвшөөрлүүд байдаг шүү дээ. Энэнээс цуцлагдсанаас.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Цагдаагаас, цагдаа, прокуророос болон Барилгын яамнаас хариулъя. Төрийн энэ үйлчилгээ чинь яагаад удаад байна 1 дүгээр асуулт. Энэ гэмт хэрэгтэй тэмцэх, энийг бууруулах тал дээр гэдэг асуулт эхний асуулт байна. 1 номер уу Батдэлгэр хурандаа? 1 номер.

**Б.Батдэлгэр:** Галбадрах гишүүний асуултад хариулъя. Цагдаагийн байгууллагын Мөрдөн шалгах албанаас гэмт хэрэгтэй тэмцэх мөрдөн шалгах чиг үүргийг бол тасралтгүй хэрэгжүүлж ажиллаж байгаа. Гэсэн хэдий ч зөвхөн энэ орон сууцтай холбоотой залилан биш мөрдөн шалгах ажиллагаа явуулахад тухайлбал би бас ганц нэг жишээ дурдъя. Мөрдөгчийн дуудах хуудсаар дуудаад ирэхгүй тохиолдолд албадлага хэрэглэх үндэслэл болдоггүй. Мөн цаашлаад мөрдөн шалгах ажиллагаанд, хэрэг бүртгэх мөрдөн байцаалтын ажиллагаанд саад учруулсан тохиолдолд хуучин өмнөх хуулиар бол гэмт хэрэгт тооцдог байсан энэ зүйл, анги байхгүй болсон.

Мөн мөрдөн шалгах ажиллагаанаас оргосон тохиолдолд гэмт хэрэг болдог байсан. Энэ зүйл, анги бас байхгүй болсон. Хуучин Эрүүгийн хуулийн 261. Ингээд үндсэндээ мөрдөгч прокурорын дуудах хуудсаар дууддаг, албадлагыг прокурорт саналаа уламжилж, шүүхээр шийдвэрлүүлдэг, мөн дээрээс нь энэ байгууллагуудаас лавлагаа, мэдээлэл авахад прокурорын байгууллагаас зөвшөөрөл авдаг гээд энэ мөрдөн шалгах ажиллагаа иргэд бас тэр болгон анзаардаггүй ч гэсэн цаана нь бас энэ мөрдөн шалгах ажиллагааны хурд бол бас энэ хууль, эрх зүйн орчинтой холбогдуулаад бас нэлээн хангалтгүй байгаа. Ийм эрх зүйн орчинд бас бид нар аль болох бас богино хугацаанд түргэн шуурхай ажиллах бодлогыг л баримталж ажиллаж байгаа.

Тэгэхээр бид бол энэ зовлон яриад суух биш өмнөх ажлаа бас шуурхай хийвэл бол ажлын хэсгээ байгуулаад мөрдөх ажиллагаануудыг бол богино хугацаанд шалгаад явж байгаа. Саяын энэ дурдагдсан хэргүүд ихэнх нь эрүүгийн хэрэг үүсгээд, яллагдагчаар татагдчихсан, шүүхэд шилжчихсэн ийм хэргүүд бас сая бас иргэд маань бас санал, хүсэлтээ илэрхийлж байна. Үлдсэн бусад хэргүүд ажиллагаанд байгаа хэргүүдийг бол бид нар бас богино хугацаанд шалгаж шийдвэрлэхдээ ажлын хэсэг гараад удахгүй дуусгахаар ингээд ажиллаж байна. Танилцуулж дууслаа.

**О.Номинчимэг:** 4 номер. Ер нь иргэдээс маш тийм бүтээлч саналууд ирж байгаа. Тэгээд гол асуудал энд Өргөдлийн байнгын хороо бид нар олон энэ өргөдөлтэй танилцаад, иргэдтэй уулзаад явахад ерөөсөө энэ төрийн хууль чинь иргэдээ хамгаалсан, иргэдийнхээ эрх ашгийг хамгаалсан зүйл байхгүй байна шүү дээ. Энд чинь хохироод байна шүү дээ л гэдэг юм хэлээд байгаа юм. Тэгээд энийг сайжруулах тал дээр та хэд юу хийж байна л гэдэг асуулт байна. Хууль зүйн яамны Төрийн нарийн нэг дуудаач. Хууль зүйн яам энд оролцох ёстой. Энэ асуудал дэгдэж 3 сард бид нар энэ 2 яам руу, Засгийн газрын Хэрэг эрхлэх рүү бүх асуудлуудыг нь ингээд хамтарсан байдлаар энийг хараадхаач ээ гэдэг саналууд

явуулсан. Одоо ямар явцтай байна? Энэ хяналт тавих асуудал, хууль, эрх зүйн орчныг сайжруулах дээр юу хийж байна? 4 номер.

**М.Баяраа:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Баяраа. Галбадрах гишүүний асуултад хариулъя. Эхний асуулттай холбоотойгоор хууль, эрх зүйн орчин бол одоогийн яг энэ нөхцөл байдалтай холбоотойгоор бол энэ асуудлууд маань Иргэний хууль болон Эрүүгийн хууль руу орчихсон нөгөө хуулийн зохицуулалтуудаар ингээд яваад гэмт хэргийн шинжтэй бол тэр авагдах арга хэмжээнүүд нь авагдаад ингээд яваад байгаа.

Бид нар энэ хуулиудынхаа өөрсдийнх нь салбарын хуулиудад бас тодорхой өөрчлөлтүүдийг оруулъя гээд ингээд ажиллаж байна. Ямар хуулиуд байгаа вэ гэхээр Барилгын ерөнхий хууль маань 2016 онд хамгийн сүүлд батлагдаад тэрнээс хойш 10 гаруй жил ямар ч өөрчлөлт ороогүй ингээд явж байгаа хууль байгаа. Энийг энэ Их Хурлын хаврын чуулганаар өргөн барина гээд явж байна. Засгийн газарт бол ирэх 7 хоног бол танилцуулагдана.

Дараагийн хууль болохоор Орон сууцжуулалтын тухай хуулиар бас энэ харилцааг тодорхой заалтуудаар зохицуулъя гэдэг ийм байдлаар орж байна. Мөн Хот байгуулалтын тухай хууль өөрчлөлт орж байгаа. Хот байгуулалтын тухай хууль бас.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Галбадрах гишүүний 1 дахиад асуулт байна. Тэр техникийн нөхцөл эд нар өгөхгүй удаад Төрийн байгууллагын үйлдлээс болоод барилгын компаниуд үйл ажиллагаа нь удааширдаг, эцэст нь иргэд хохирдог энэ асуудал байгаад байна. Энэ дээрээ та бүхэн яг энэ нөгөө барилга зөвшөөрөл, техникийн нөхцөл өгөх асуудал дээр яаж хяналтаа тавьж, яаж зөв системтэй болох тал дээр юу хийж байгаа юм бэ гэдэг асуулт байна техникийн нөхцөлтэй холбоотой. 4 номер.

**М.Баяраа:** Маш товчхон хариулахгүй бол энэ хугацаанд яагаад байгаа юм байна. Ер нь үндсэндээ бол 5 нөхцөл авдаг. Архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг, техникийн нөхцөл, магадлалын дүгнэлт, барилгын ажлын эхлэх зөвшөөрөл, үргэлжлүүлэх зөвшөөрөл гээд. Энэнтэй холбоотойгоор үүнээс "А" зөвшөөрөл, загвар зураг, магадлалын дүгнэлт, магадлалын, барилгын үргэлжлэх зөвшөөрлийг бол нийслэл, орон нутаг олгож байгаа. Техникийн нөхцөлийг бол харьяа газрууд нь олгож байгаа. Дулаан Улаанбаатар цахилгаан түгээх ч байдаг юм уу. Магадлалын дүгнэлтийг бол Барилга, хөгжлийн төвөөр ингээд олгоод явдаг.

Манай дээр гарсан энэ нэг ажлын хэсэг байгаа. 52 төсөл дээр хэрэгжүүлж байгаагаас 25 дээр нь явж байгаа гэсэн. Энэ дээр бүх энэ зөвшөөрлүүдийг бол бид нар магадлаад явж байгаа. Энэ ажлын хэсгийн гол бидний ажиллаж байгаа зарчим болохоор энэ удаашралтай байгаа бичиг баримтуудыг нь хамтраад урагшлуулах хурд.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууя.

**О.Саранчулуун:** Баярлалаа. Би энэ. Цагдаагийн, хууль зүйн биш ээ уучлаарай. Орон сууцтай холбоотой залилах гэмт хэргийн нөхцөл байдлын талаар Цагдаагийн ерөнхий газраас ирсэн тайлангаас лавлаж байгаа шүү. Энэ дээр юу асуух гээд байгаа вэ гэхээр санхүүгийн чадамжгүй хуулийн этгээдүүд орон сууцын

төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, иргэдтэй гэрээ байгуулж, мөнгө татан төвлөрүүлж байна гэх юм. Тэгээд эд нарт хэн зөвшөөрөл өгдөг юм, зөвшөөрөл нь яг ямар зөвшөөрлийг хаанаас өгдөг вэ гэдгээ хэдүүлээ нэг бүрчлэн хөөгөөд үзэхээр энэний чинь цаана авлигал байна уу, ямар асуудал байна гээд нь гараад ирэх байх гэж нэг бодоод байх юм.

2 дугаарт нь энэ залилан үйлдээд байгаа гэж нэрлэгдээд байгаа компаниудын цаана давхар өмчлөгч нар бас байна. Жишээлбэл, 1 эзэнтэй тэгээд 2, 3 компани байгуулаад тэгээд ингээд зүсээ хувиргаад дахиад өөр компани байгуулаад залилан хийчихсэн хүмүүс байгаад байгаа байхгүй юу. Тэр бас надад ч гэсэн ингээд мэдээллүүд ирсэн байна л даа. Тэгэхээр тэд нарын асуудлыг болохлоор энэ цагдаагийн газраас ирсэн мэдээлэл дээр тус тусад нь хэрэг үйлдсэн бол тус бүрд нь эрүүгийн хэрэг үүсгэдэг учраас ингээд процесс нь их тэгж удааширч байна, хавтаст хэрэг бүрдүүлэх гэж хүндэрч байна гэдэг асуудал гарч байна. Энийг тэгээд шийдэл нь яг юу юм бэ та бүхэн өөрсдөө юу гэж харж байгаа юм гэдгийг тодруулмаар байгаа юм.

3 дахь асуултыг тодруулъя. Ер нь хэн залилагдаад байгаа вэ? Ахмадуудыг залилуулаад байна уу? Санхүүгийн хэрэглэгч талаасаа мэдлэг чадвар, тааруу хүмүүс залилагдаад байгаа юм уу? Яг хэнийг хохироогоод байгаа гэдэг тэр хохирогчдын талаарх мэдээлэл ер нь байгаа юу? Эд нар чинь нөгөө нэг аргаа олчихсон ингээд удаа дараа олон жил залилан аваад сурчихсан хүмүүс бас байгаад байдаг юм шиг ийм мэдээлэл өрнөөд байна л даа.

Нөгөө талд засгийн, ер нь энэ барилгын энэ компаниуд барилга барихтай холбоотой даатгал байдаг юм уу? Даатгалын процесс ер нь яригддаг уу манайд? 1 дарга нь наад ажлаа эхэл, газраа одоо ухаж болно гээд зөвшөөрч байдаг. Нөгөө хүн нь болохоороо болно, болохгүй гэдэг дараалал нь ер нь ямаршуу процесстой байдаг юм? Энэ дээр барилгын яам жоохон ойлгомжтой тайлбар өгчих. Тэгвэл нөгөө шинэ компани ч юм уу, нэг үйл ажиллагаа явуулж байгаа хүн нь энэ нь дарга нь зөвшөөрсөн юм чинь болох юм байна, энэ нь бол болохгүй гэдэг дундын хооронд явсаар байгаад янз бүрийн асуудал бас гардаг байж магадгүй юм даа гэж бас харагдаж л байна л даа аж ахуйн нэгж талаас нь харах юм бол. Тэгэхээр ийм 3 мэдээллийг лавлаж аваад лавлая, хариулт авъя.

**Ж.Галбадрах:** Цагдаагийн ерөнхий газраас хариулах уу? 1 номерыг өгөөрэй.

**Б.Батдэлгэр:** Гишүүний асуултад хариулъя. Энэ бэлдсэн мэдээлэлтэй холбоод бас тодруулга өгье. Бид нар мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоогдсон нөхцөл байдлууд, кэйсүүд дээр түшиглээд энэ бас мэдээллийг бас бэлдсэн. Тухайлбал, ямар тохиолдлууд байдаг вэ гэхээр 1 иргэний газар дээр төлбөрийг нь орон сууц барьсан тохиолдолд бартераар төлөхөөр, мөн орон сууц барихад шаардах шаардлагатай төмөр бетон арматур зэрэг бүтээгдэхүүнүүдийг мөн адил компаниудтай урьдчилсан байдлаар гэрээ хийж, бартераар бас орон сууц барьсан тохиолдолд төлбөрийг төлөхөөр нөхцөлтэйгөөр бас гэрээ хийдэг. Энэ мэтчилэн компаниудыг бол санхүүгийн чадамжгүй компаниуд гэж харж байгаа. Ийм ч үүднээс барилгаа гүйцээж барих ямар нэгэн чадамжгүй учраас иргэд хохироод тухайн хэргүүд нь бол шүүхээр шийдвэрлэгдсэн кэйсүүд байгаа. Энэ талаар бид нар бол тухай бүр бас мэдээллүүдээ хийж, зарим асуудлуудаар нь, бас холбогдох байгууллагуудад нь бас мэдээллийг уламжилж байсан, уламжилдаг.

Дараагийн дугаарт нь энэ тус бүрд нь хэрэг нээж шалгадаг гээд. Энэ нөгөө хэрвээ 500 иргэн хохирсон бол тус тусдаа хэрэг бүртгэлтийн хэрэг нээгээд, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаад, тухайн аж ахуйн нэгж болон иргэнд холбогдох хэрэг рүүгээ нэгтгэж шалгадаг. Тэгэхээр энэ маань бас мөрдөн шалгах ажиллагаанд бас удааширч байгаа бас нэг асуудлуудын нэг маань энэ болдог. Техник ажиллагаанууд энэ хүрээнд явагддаг.

Хэн залгигдаад байна вэ гэхээр ер нь бол бид нарын ирж байгаа энэ иргэдийн маань мэдээллийг ингээд бид нар судлаад, хараад үзэхээр энэ дээр ямар нэгэн тийм нас ,хүйсийн бол хязгаар алга байна. Ихэвчлэн энэ орон сууцтай болох гэсэн зорилго бүхий иргэд маань л энэ залилангийн хэргийн хохирогч болж орон сууцтай холбоотой хэргийн дээр бол хохирч байгаа. Танилцуулж дууслаа.

**О.Номинчимэг:** Барилгын яам 4 номер.

**М.Баяраа:** Одоогийн эрх зүйн орчинд бол даатгалын асуудал бол байхгүй байгаа. Барилгын ерөнхий хуулийг өргөн барих гэж байгаа түрүүн танилцуулж байсан шинэ хуулиар бол эрсдэлийн даатгал гэдгийг би бий болгож байгаа. Эрсдэлийн даатгалд хамрагдаагүй тохиолдолд иргэдээс хөрөнгө татахыг бол хориглож байгаа. Мөн Орон сууцжуулалтын тухай хуулиар болохоор батлан даалт гаргах боломжийг эрх зүйн орчинд бол бас нээж өгч байгаа.

**О.Номинчимэг:** Отгоны Саранчулуун гишүүн тодруулъя.

**О.Саранчулуун:** Тодруулаадахъя. Хар жагсаалт байлгах гэдэг ийм шийдэл харагдаж байна л даа. Тэгэхээр нэрээ, барилгын компанийнхаа нэрийг хувиргаад жишээлбэл юу гэдэг юм “Эко даймонд” гэснээ “Эбо даймонд” болгоод дахиад хүмүүс луйвардчихсан кэйсүүд байна шүү дээ. Тэгэхээр үүний чинь цаана 1 эцсийн өмчлөгч байгаад, 1 үүсгэн байгуулагч байгаа нөхцөлд Цагдаагийн газарт энэ Барилгын яам 2-ын хоорондын холбоос нь энэ дээр яаж зохицуулагдах юм бэ гэдэг асуудал байгаа байхгүй юу 1. Тэгэхээр хар жагсаалт бол эхний хэрэг үүсгэсэн компани дээр хар жагсаалт үүсээд 2 дахь нь бол жагсаалт үүсэхээс өмнө дахиад хэрэг үүсгэж амжих гэж байгаа юм шиг ийм дундын зай үүсэх гээд байгаа юм шиг харагдаад байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ямар шийдэл байна? Тэрийг сонсьё.

**О.Номинчимэг:** 4 номер.

**М.Баяраа:** Манай хувьд болохоор барилгын тусгай зөвшөөрөл өөрөө license.mn-ээр бүх материалаа аваад энийг Барилгын хөгжлийн ассоциаци бол, Барилгын ассоциаци бол энийг чеклэх, шалгах ажлуудыг хийж явдаг. Үүнтэй холбоотойгоор манай яаманд бол Барилгын ассоциациас 1 эзэмшигчтэй олон барилгууд дээр хяналт хийх, мөн цуцлах, цуцлах хүсэлтийг ирүүлэх, мөн барилгын компани байгуулчхаад түүнийгээ зарж байгаа ийм тохиолдлууд илэрсэн тохиолдолд тусгай зөвшөөрлүүд дээр бол цуцлах ажил хийдэг. Яг энэ залилантай холбоотой хохирол үүсчихсэн асуудал дээр бол яг манайх нөгөө хууль, эрх зүйн орчин нь байхгүй болохоор яг энэ дээр бол тусгайлсан арга хэмжээ бол авахгүй байгаа.

**О.Номинчимэг:** Саранчулуун гишүүн дахин тодруулъя.

**О.Саранчулуун:** Би нөгөө хариултаа бүтэн авах гээд л тодруулах гээд байгаа шүү. Захиалагчдаас мөнгө татаж, гэрээ авах зөвшөөрлийг ямар газар өгдөг вэ? Энэ дээр чинь нөгөө санхүүгийн чадамжгүй гээд тэр сая Цагдаагийн газраас бол тайлбар өгч байна шүү дээ. Ийм ийм хүмүүс гэрээ хийгээд хүмүүсээс мөнгө татаад байна гээд байгаа. Тэгэхээр тэр гэрээ хийх зөвшөөрлийг нь яг хэн өгдөг юм? Тэрийг нь тодруулчихъя.

**О.Номинчимэг:** Энэ дээр манайхнаас бүгдээрээ толгойгоо ингээд хариулахгүй байх шиг байна. Одоогоор ямар ч тийм зохицуулалт байхгүй байгаад байгаа юм. Ер нь бол энэ бол зүгээр Иргэний хуулиараа явна, гэрээ хийнэ ээ гээд хаячихсан. Тэгтэл нөхцөл байдал дээр юу байна гэхээр зүгээр ийм макет үзүүлээд, зураг зурчхаад, макет үзүүлээд энэ дээр тэр хүний амьдралдаа 1 юм уу, 2 удаа л хийх захиалгын мөнгийг өчнөөн олон жил хөдөлмөрлөж олсон, зарим нь бол Бүгд Найрамдах Солонгос Улсад ажиллангаа Монгол улсдаа нэг байртай, гэр бүлтэйгээ байртай оччих юм сан гэж бодсон хүмүүсийн итгэл, найдвар, хүсэл дээр тоглож, макет үзүүлээд шууд мөнгийг нь авчаж байгаа юм. Тэгээд энэ чинь юу гэсэн юм зүгээр ингээд цаас үзүүлээд мөнгө авна гэдэг чинь өөрөө агаар зүгээр ингээд зарж байгаатай адилхан ийм нөхцөл байдалтай байгаад байгаа байхгүй юу. Тэгтэл энэ чинь хүний эрхийн асуудал, хүний анхдагч хэрэгцээний асуудал дээр бид одоог хүртэл ямар ч хууль, эрх зүйн зохицуулалт байхгүйгээс үүдээд иргэдийнхээ эрх ашгийг хамгаалсан юм байхгүй ийм нөхцөл байдалд гарчихсан байна гэдэг л асуудал байгаад байгаа юм. Тэгээд энийг бид нар цаашид тэр хууль, эрх зүйн орчныг нь засах ёстой.

Энэ дээр би Саранчулуун гишүүний асуултыг илүү жоохон нарийвчлаад хов хоосон газар дээр зураг үзүүлээд зөвшөөрөл ч байхгүй шүү дээ ингээд захиалга аваад байгаа байхгүй юу. Тэгэхээр танай Барилгын хууль дээр энэ юу гэдэг юм тодорхой хэмжээний фундаментаа тавьчихсан, тодорхой хэмжээний барилгын ажил хийсний дараагаас орон сууцын захиалгын гэрээгээ хийж болно гэдэг ийм хязгаарлалтууд орж ирж байна уу? Энэ бас яригддаг асуудал байгаа тийм үү? Тэгэхгүй бол хов хоосон газар дээр мөнгө авчхаад тэрийгээ тэрэнд барилгадаа зарцуулж байна уу гэдэг ямар ч хяналт байхгүй. Тэрийгээ нэг нь аваад л нөгөөдхөдөө өгөөд л ингээд л явчихдаг залилангийн ийм талбар болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд энийг зөндөө олон жил харсаар байж, мэдсээр байж бид нар төр нь арга хэмжээ аваагүй, хууль, эрх зүйн орчныг нь сайжруулаагүй ийм л явж ирсний гай, гор болчихоод байгаа. Энэ дээр тэгвэл та бүхний хууль дээр ямар нэгэн хязгаарлалт, зохицуулалт байна уу гэдэг дээр 4 номер Баяраа дарга.

**М.Баяраа:** Барилгын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга дээр орж байгаа заалт бол даацын бүтээцийн угсралтын ажил 50-аас доошгүй хувь хийгдээгүй тохиолдолд иргэдээс мөнгө төвлөрүүлэхийг бол хориглож байгаа. Тийм одоо 30 хувь байгаа.

**О.Номинчимэг:** Тэр хяналтыг хэн хийх вэ? Яаж тэр хяналтын механизм нь хэрэгждэг болох вэ? Та бүхэн тэр барилгын компани 50 хувь дээрээ болсон уу үгүй юу, энэ компани тэгвэл иргэддээ мөнгө босгох гэж гэрээ хийж байна уу үгүй юу гэдгийг яаж хянах механизм оруулж байгаа юм? Гол нь тэр байгаад байна шүү дээ. Тэгэхгүй бол ямар ч хяналтын механизм байхгүйгээс үүдээд тэнд хэн дуртай нь, хэзээ дуртай нь мөнгө, цаас үзүүлж байгаад мөнгө босгоод яваад байгаа. Тэгээд зохицуулалт оруулж ирж болно. Тэр чинь яаж хэрэгжих юм бэ гэдэг аягүй чухал байгаад байгаа шүү. Тэрийгээ анхааръя гэдгийг хэлмээр байна. Мөнхтуяа гишүүн асуулт асууя.

**Ц.Мөнхтуяа:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өмнөх хурлаар би бас хэлж байсан энд өмнө нь сууж байсан хүмүүс байна тээ? Утас хулгай хийгээд ял аваад явчихдаг. 10 жилийн ял, бараг 5 жилийн ял. Гэтэл өнөөдөр хэчнээн тэрбумаар нь энэ ард иргэдийг залилаад, луйвардаад ял авахгүй ингээд суугаад байж байдаг нь ямар учир байна л гэж асуугаад байгаа шүү дээ. Бүх юмаа аягүй тодорхой болгомоор байна. Төр нь төр шиг баймаар байна. Хууль нь хууль шиг, хуультай улс шиг баймаар байна. Зүгээр л нэг аргацаасан өнөө маргаашаа ингээд өнгөрөөсөн нэг ийм зангууны үлгэр шиг юм яриад сууцгааж байгаа байхгүй юу яг үнэндээ. Яаж шийдэх гээд байгаа юм? Хууль хүчнийхэн өнөөдөр 20 оноос хойш 6 жил луйвар хийгээд багш нарыг залилаад луйвар хийгээд байж байгаа “Ногоон хөгжил” гээд компани өнөөдөр ингээд нөгөө дээлээ солино гэдэг шиг нэрээ өөрчилчихсэн энд ингээд сууж байна. Багш нь багшаа луйвардчихсан.

Тэгээд нөгөө ичсэн хүн хүн ална гэгчээр хүн гүтгэдэг, хүний нэр барьдаг. Хүрэлсүх Ерөнхийлөгч тэгсэн, Энх-Амгалан сайд тэгсэн, Мөнхтуяа манай төслийг зогсоосон. Болиоч ээ ийм муухай балиар явуургүй ийм ёс зүйгүй байхаа боль. Өчнөөн олон мянган багш нар гомдол гаргаад, шийдлээ хүлээгээд сууж байна шүү дээ. Уйлж унжаад зарим нь эцэг, эхийгээ алдчихаад ийм хэцүү байдалтай байгаагаа та нар ер нь юу гэж тайлбарлах юм айн? Энд хүртэл энд Отгонбат гээд залуу аавыгаа алдчихаад сууж байна. Энэ Ногоон хөгжлийн энэ луйвраас болж.Одоо би энэ Санчирмаа, Отгонбат, Наранцэцэг багш ярих хэрэгтэй, яримаар байна та нар. Тэгээд энэ 3 хүн юмаа ярихгүй тэгээд нөгөө Ногоон хөгжлийн луйвар хийсэн хүмүүс нь яах гэж байгаа юм, тайлбар хийх гэж байгаа юм уу? Монголын бараг 2, 3 мянган багшийг луйвардчихсан, эрүүл мэндийн салбарынхныг луйвардчихсан, соёл урлагийн салбарынхныг луйвардчихсан ийм хүмүүс энд орж ирээд ичихгүй сууж байна. Одоо энд. Эд нар тайлбараа хий. Би ч гэсэн шүүхэд хандана. Миний нэр хүндээр зөндөө тоглолоо та нар 20 оноос хойш. Би наанаас чинь 1 ч төгрөг аваагүй, 1 ч юманд чинь оролцоогүй. Харин ч би урьдчилан сэргийлж багш нарыг та нар энэ луйвард өртөөд байна шүү гэж би тэр луйвардуулсан багш нараас гомдол ирсний дараа би удаа дараа би бас бичиж, хэлж байсан. Сануулж байсан. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ өөрийнхөө түвшинд би авч байсан.

Тэгэнгүүт намайг миний манай энэ гоё луйвар, залиланг зогсоолоо Мөнхтуяа гээд багш нарын өмнө миний нэр хүндийг унагаагаад явж байхад сая ичдэггүй юм уу айн? Би хэнээс ч юу ч луйвардаагүй. Тийм учраас би ийм бардам том дуугарч байгаа юм. Хулгай хийсэн хүн хүний урдаас яаж дуугарах юм? Өнөөдөр хулгай хийчхээд нөгөө хүн алсан хүн юу гэдэг билээ, ичсэн хүн хүн ална гэгчээр миний нэрийг ингэж луйвардаа битгий ашигла. Хүрэлсүх Ерөнхийлөгчийг, Энх-Амгалан.../минут дуусав./

**О.Номинчимэг:** 1 юм уу, 2 номерын микрофон дээр Санчирмаа суучих. Танд хариулах 3 минут байгаа билүү? Дараа нь нөгөө төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын төлөөлөл ирсэн байгаа “Ногоон хөгжил”. 2 номер дээр. 2 номер дээр очоод байж байгаарай асуудлуудаа ярих нь байна. 2 номерын микрофон нэрээ хэлээд гишүүний асуулт.

**И.Наранцэцэг:** Тэр багшийн 2023 оны 11 сард надад хүсэлт тавиад би энэ асуудлыг судалсан юм. Тэгэхээр ер нь иргэдийнхээ нэн хэрэгцээтэй асуудлыг итгэлийг нь ашиглаж хуулийн үндэслэлгүй гэрээ хийж, олон зуун багш, эмч нарыг, бизнесийнхнийг мэхлэн компанигүй, газаргүйгээ гэрээ хийж, олон сая төгрөгийг

хувьдаа ашигласан байх магадлалтай. Оффист нь орохоор зэрэг ерөөсөө бараг Архивын ерөнхий газар, тагнуулын байгууллага ч бараг тийм нууцлалтай байдаггүй байх гэмээр тийм нууцлалтай оффистой. Энэ бол зөвхөн багш эмч нарын асуудал биш. Энэний цаана хуульч, малчин, урлаг, тээврийнхэн, цэргийнхэн, худалдаа, бизнесийнхэн зөвхөн нэг бизнесмен гэхэд бараг 400-гаад сая төгрөгөө нэг хүнд алдсан. Тэр хүн нь Дубайд аялаад явж байгаа. Ийм юм байна.

Жишээлбэл, сая хэллээ 150 гаруй багшийг байранд оруулсан гэж байна. Тэгэхээр энэ байранд орно гэдэг бол гэрчилгээгээ гардаж авсан цагт байранд орсон л гэж үзнэ. Түүнээс энэ хүмүүс гэрчилгээнийхээ хуулбарыг авчхаад байранд орсон гэж үзэхгүй. Энийг бол хууль, хяналтынхан шалгах хэрэгтэй.

Анх гэрээ байгуулахдаа ерөөсөө банкны дансгүй, банкны дансгүй, газаргүй, компанигүй, хувийн дансандаа мөнгөө, мөнгө авсан тухай мэдээллүүд багш нараас надад маш их олон ирдэг. Энэ асуудлыг ингээд хаячихъя гэхээр багш нар надад өөрсдөө нөгөө утасны дугаараар маш их мэдээлэл ирдэг. Тэгэхээр 2020 онд бол “Ногоон хөгжил” үндэсний нэгдэл гэж байсан. Харин 2023 оны 2 сард тэр 3 жилийн дараа “Өргөө ногоон хөгжил” байгуулагдсан юм. Тэгэхээр энэ 3 жилийн хугацаанд хэчнээн хүнийг ингэж луйвардсан байна.

Жишээлбэл байрандаа та оч гээд батламж өгдөг. Одоо очоод гал тогооныхоо шийдлийг хий энэ тэр гээд. Очихоор байхгүй. Ямар ч компани байхгүй. Бид нар тийм юм мэдэхгүй гэж хариулдаг. Ийм бол олон кэйс байна.

Жаргалсайхан даргатай 2023 оны 12 сарын 19-нд бид нар 10-аад багш нарыг төлөөлөөд хамт уулзсан. Тэгэхэд бол би асуусан хэдэн хүн өргөдлөө цуцлаад байна вэ, гэрээгээ цуцлаад байна вэ гэхэд надад 847 гэж хариу хэлж байсан. Надад тэмдэглэл нь байгаа. Тэгэхээр төр, төрийн байгууллага, багш, эмч, иргэн нь, компани нь эрх зүйн орчноо ингэж бүрдүүлээд багш нараа орон гэртэй болгомоор байна. Уг нь манай улс чинь 1 сая хүрэхгүй өрхтэй юм байна лээ шүү дээ. Тэгээд өөрсдийн хамаарал бүхий нөхдөөр тэр гэрээнийхээ дугаараар, жишээлбэл гэрээнийхээ 2.3-таа заачихсан байж байгаа юм. Гэрээнийхээ дугаараар байранд чинь оруулна гэсэн. Тэгээгүй. Гол нь эндээс энэ асуудал үүссэн юм. Ингээд 12 багш надад хандаад тэр жагсаалтад нийт хэчнээн төгрөг байна вэ? Энд бол ерөөсөө орон нутгаас Говь-Алтай, Өмнөговь, Дундговь.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Тэгье. Ногоон хөгжлөөс байна уу? Төсөл хэрэгжүүлэгч? Урагшаагаа суучих микрофонтой газар. 1 номерын. 2 номер дээр үү? 2 номерын микрофон.

**Д.Санжаа:** Сайн байцгаана уу? Юуны өмнө энэ нөгөө хэлэлцүүлгийг зохион байгуулж байгаа та бүхэнд баярлалаа. Намайг Санжаа гэдэг. “Ногоон хөгжил, үндэсний нэгдэл” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал. 2022 оны 01 сарын 01-нээс энэ компанийн гүйцэтгэх захирлыг ажлыг аваад компанид хэрэгжүүлж байгаа хувьцаат орон сууц хөтөлбөр, Их нүүдэл хөтөлбөр, Бизнес ... гэсэн 3 хөтөлбөр хэрэгжүүлээд явж байгаа. Энэ 1 минутын хугацаа өгчихсөн болохоор би гялс тоон үзүүлэлтүүдээ ярьчихъя гэж бодож байна.

Компани бол, компанийн хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр бол зүгээр нэг байшин барьдаг төсөл болохлоор биш юм. Манайх хувьцаат орон сууц гэдэг

нэртэй үл хөдлөхийн өртгийг үнэт цаас руу шингээгээд иргэдэд хүүгүйгээр орлогод нийцсэн байдлаар нь орон сууцад оруулдаг ийм төсөл, хөтөлбөр юм байгаа юм. Энэ нь өөрөө 3 үе шаттай явагддаг юм. Эхний үе шат нь бол бэлтгэл үе шат хийгдэнэ гэсэн үг. Иргэд маань нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй иргэд маань манайд хамрагдах боломжтой юм. Банк буюу санхүүгийн байгууллага иргэдийг төлбөрийн баталгааг нь харахын тулд нийгмийн даатгалын шимтгэл хардаг бол манайх 36 сарын хугацаанд тухайн иргэний санхүүгийн сахилга батыг нь хардаг гэсэн үг 1 дүгээр үе шат нь.

2 дугаар үе шат нь бол манайх хэрэгжих үе шат явдаг. Түлхүүрээ гардаж авдаг гэсэн үг. Одоогийн байдлаар хэрэгжээд явж байгаа 100 гаруй хүмүүс явж байгаа юм манай тэр төсөл дээр хэрэгжээд явж байгаа. Би минут бага учраас тоон мэдээлэл рүү шууд орчихъё. Манайх 2020 оноос 2024 оны хооронд нийтдээ бол компани өөрийн хөрөнгө 3 орчим тэрбум, татан төвлөрүүлсэн нөгөө 19 тэрбумаа татаад 21.8 тэрбум төгрөгийн орлого олсон юм.

Үүнээс төслийн зардалд 15 тэрбум, мөн дээрээс нь гэрээ цуцалсан. Гэрээгээ биелүүлж чадахгүй сахилга батаа хангаж чадахгүй учраас гэрээгээ цуцлаад буцаагдсан дүн байгаа. Мөн дээрээс нь ингээд хохирлын хэмжээ ярихаар манай компанийн дотоод асуудал буюу компанийг өмнөх гүйцэтгэх захиралтай холбоотой зүйл болоод явчихдаг. Авлига, албан тушаалын хэрэгтэй холбоотой бид нар үүнийг өөрсдөө ЧД-ийн цагдаа дээр шалгуулж байгаа ийм байдал байгаад байгаа юм.

Хүсэлт бас байгаа манай компанийн зүгээс. Одоо манайх бол энэ хохирсон гээд байгаа иргэдийн маань буцаалтыг өгөх бүрэн боломж.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Танайх Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөлтэй юм уу? 2 номер Ногоон хөгжил. 2 номерын микрофон.

**Д.Санжаа:** Манайх хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй, нээлттэй хувьцаат компани. 3 дугаар ангилалд байгаа. Бид нар “Өргөө ногоон хөгжил” гэдэг охин компаниа байгуулсан. Гэхдээ бид нар байгуулахдаа гэмт хэрэг үйлдэхгүй гэдэг байдлаар нэр хүндтэй хуулийн компанид бид нар хүсэлт тавиад Компанийн тухай хуулийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр тусгаарлаад дараагийн шатынхаа компаниа байгуулаад явсан.

**О.Номинчимэг:** Дараа нь Мөнхтуяа гишүүний юу байгаа. Санхүүгийн зохицуулах хороо бэлдэж байгаарай. Энэ орон сууц, үл хөдлөхөөр яасан хувьцаа гаргана гэж байгаа. Энэ танай үйл ажиллагаа дээр хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гэдэгтээ орох юм уу, тусгай зөвшөөрөл шаардагдах юм уу? Ингээд үл хөдлөх хөрөнгийн төслийг хувьцаа хэлбэрээр гаргаж, хөрөнгө татах энэ явц чинь ер нь тусгай зөвшөөрөлгүйгээр хийх, болдог үйл ажиллагаа юм уу? Тэр дээр хариултаа бэлдэж байгаарай. Мөнхтуяа гишүүн тодруулъя.

**Ц.Мөнхтуяа:** Анх бол эд нар хувьцаа гэж яриагүй шүү дээ та нар. Би бол анхны гэрээг нь харж байсан. Тэгэхээр энэ хувьцаа гэдэг нэрээ луйвар, залилан хийсэн байх магадлал маш өндөр учраас энэ Санхүүгийн зохицуулах хороонохон эднийх яг танайхтай тийм гэрээ хийсэн юм байна уу гэдгийг 1-д сая Номинчимэг гишүүн асууж байна. Энийг тодруулъя.

**О.Номинчимэг:** Санхүүгийн зохицуулах хороо микрофон дээр очъё. Хаана суух вэ. Дахиад 1 тодруулга байж болно. 2 тодруулгатай юу. Энэ асуудлыг бас судлаарай гээд урьдчилж бас хэлсэн байгаа Санхүүгийн зохицуулах хороо, ажлын албаны дарга 6 номер.

**С.Цогтгэрэл:** Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны дарга Цогтгэрэл асуултад хариулъя. Энэ яригдаж байгаа энэ төслийн хувьд бол манай дээр олон иргэдээс бас өргөдөл, гомдол ирсэн. Энэ “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” хувьцаат компани, “Өргөө ногоон хөгжил” хязгаарлагдмал хувьцаат компанитай холбоотой асуудлууд ирсэн. Тухайн компани нь бол 2022 оноос авхуулаад манай Санхүүгийн зохицуулах хороон дээр хаалттай хувьцаат компаниар бүртгүүлэх, хувьцаа нэмж гаргах хүсэлтүүдээ гаргасан байдаг. Тухай бүрд нь бол холбогдох шаардлагуудыг хууль болон журмаар тавигдсан шаардлагуудыг хангахгүй байгаа учраас хувьцаа гаргахыг нь бол татгалзаж, Санхүүгийн зохицуулах хорооноос шийдвэрлэсэн байдаг.

Мөн тухайн компанитай холбоотой 8 иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг бол цагдаагийн байгууллага руу шилжүүлсэн байгаа. Үл хөдлөх хөрөнгийг барина гээд барилгын компаниуд.../минут дуусав./

**О.Номинчимэг:** 6 номер гүйцээж хариулъя. Тодорхой хариулаарай.

**С.Цогтгэрэл:** Барилгын компаниуд бол захиалга авах энэ үйл явдал, үйл явц бол Санхүүгийн зохицуулах хорооноос ямар нэгэн тусгай зөвшөөрөл авахгүй Санхүүгийн зохицуулах хорооны эрхлэх асуудлын хүрээнд бол хамаарахгүй ийм асуудал байгаа.

Номинчимэг гишүүний асууснаар үл хөдлөх хөрөнгийг барьцаалаад хувьцаа гаргах асуудал дээр бол хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад бол Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авна. Одоогоор бол ямар нэгэн зөвшөөрөл авсан асуудал бол байхгүй байгаа.

**О.Номинчимэг:** Мөнхтуяа гишүүн тодруулъя.

**Ц.Мөнхтуяа:** Санчирмаа маш тодорхой асуудал ярих ёстой учраас би Санчирмаагаас тодруулга авъя.

**О.Номинчимэг:** 1 номерын микрофон иргэдийн төлөөлөл.

**Г.Санчирмаа:** Би шууд асуултаа л асуучихъя гэж бодож байна минут бага байгаа учраас. Санхүүгийн зохицуулах хорооноос асуумаар байна. “Өргөө ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХХК нь 23 оноос хойш танайх дээр хувьцаа гаргах хүсэлтийг 2 удаа өгсөн. Ямар үндэслэлээр татгалзсан бэ гэдгийг? Цагдаагийн ерөнхий газраас прокурорын тушаалаар энэ компани хэчнээн байр битүүмжлэгдсэн бэ? 2026 оны 4 сард 100 гаруй байр битүүмжлэгдсэн. Нийтдээ 16-аас 17 тэрбумын эд хөрөнгө битүүмжлэгдсэн. Бид нар хохирлоо 100 хувь барагдуулж болно гэдэг тайлбарыг тавьсан байгаа.

Би компанийн зүгээс нэг асуултыг асуумаар байна 2026 оны 4 сард БНХАУ-ын Шинжаан хотын “Бай...” компанийн хөрөнгө оруулалттай гэрээ хийчихлээ. Бид нар манай данс хаачихсан учраас дараагийн шатаар өөр аргаар бид нар хөрөнгө оруулалт хийж хохирогчдын мөнгийг буцааж өгнө гэж хэлсэн. Тэгэхлээр энийг бол

би хардах эрхийнхээ хүрээнд 3, 3-н жилийн дараалалтайгаар энэ компани өмнөх гэрээнийхээ үүргийг биелүүлэхгүйн тулд зайлсхийх.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Одоо бол асуулт асуух биш хариулт, эсвэл тайлбар хийх ийм дэгтэй байгаа таны хувьд. Гэхдээ бас энэ иргэдийн төлөөлөл болоод асуудал дэвшүүлж байгаа учраас миний зүгээс энийг нь тодруулаад холбогдох байгууллагуудаас асуучихъя гэж бодож байна. Цагдаагийн байгууллага энэ холбоотой нь бас саяын иргэний мэдээлэл дээр үндэслэсэн асуудлууд нь юу болж байна аа хохирлыг барагдуулах гэдэг тал дээр хариултаа бэлдье.

2 дугаарт юу юм байна 2 номер дээр байгаа төсөл хэрэгжүүлэгч. Гэхдээ та бол сая төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс бид нарт энэ Байнгын хороон дээр тайлбар өгөхдөө хувьцаа, орон сууц захиалаад орон сууцтай болох хувьцаа маягаар гаргаж байгаа гээд хэлээд байна шүү дээ тийм үү? Тэгээд тэрийг нь болохоор Санхүүгийн зохицуулах хороо болохоор орон, юу гэсэн үг юм байдаг юм наадах чинь? Би ерөөсөө ойлгохгүй байгаа байхгүй юу. Орон сууцтай болно та энэ хувьцааг манайхаас ингэж мөнгө өгөөд авах юм бол би танд орон сууцтай болно гээд баталгаажуулаад өгөөд байна шүү дээ. Баригдаагүй орон сууц дээрээ бараг баталгаа өгөөд, үл хөдлөх хөрөнгийн баталгаа өгөөд май манайхаас энэ хувьцаа ав гээд мөнгийг нь татаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр нэг агаарын юм яриад байх юм Санхүү зохицуулах хороо. Бодит байдал чинь ийм байна шүү дээ. Энэ дээр та нар хяналт хийж байгаа юм уу? Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас юу байдгийг бид нар бүгдээрээ мэднэ. ТЗК-ууд байгуулаад ингээд хөрөнгөжүүлдэг. Гэхдээ бараг тэрний хэлбэрийг аваад тусгай зөвшөөрөлгүйгээр орон сууцыг чинь өгнө шүү. Май, үл хөдлөх май баталгаатай баталгаажсан гээд хувьцаа зарж байгаа чинь та нарын хяналт хийх ёстой газар биш юм уу, болдог юм уу? Тэгвэл өөр ийм төсөл хэрэгжүүлж байгаа хэдэн компани байна? Наана чинь та бол харж байгаа байх тийм үү? Ийм л аюултай иргэдийн хохирлын асуудал болоод байна шүү дээ. Тэгээд Санхүү зохицуулах хороо санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тал дээр ажиллах ёстой. Зөндөө л урьд нь тэгээд л койн гээд бүх юм гарч байсан. Дандаа хойноос нь та бүхэн ийм юм гарчихлаа гээд хойноос нь явдаг. Урьдчилж хараад энэ чинь ийм байж болох уу үгүй юү гэдэг дээр яагаад дүгнэлт хийхгүй байгаа юм бэ гэдэг дээр дахиад хариулт бэлдэж байгаарай. 1 номер цагдаа.

**Б.Батдэлгэр:** “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” компанитай холбогдох хэрэгт мөрдөн шалгах албан дээр ажлын хэсэг байгуулаад мөрдөн шалгах ажиллагааг явуулж байгаа. 2025 оны 10 сарын 27-ны өдөр тус компанийн нэр бүхий 5 албан тушаалтныг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Одоо 155 иргэн хохирогчоор тогтоогдоод байна. Мөн цаашдаа хэдэн хохирогч хэрхэн нэмэгдэх нь бол энэ шалгалтын явцаас бас тогтоогдох байх. Мөрдөн шалгах ажиллагааны явцад бол иргэний асуултад хариулахад мөрдөн шалгах ажиллагаанууд тодорхой ажиллагаануудад хийгдчихсэн байгаа. Гэхдээ өнөөдөр бид нар нээлттэй байдлаар энэ мөрдөн шалгах ажиллагааны явц, төлөвлөлтийн талаар бол танилцуулах боломжгүй танд. Тухайлаад хүсэлтийн дагуу бид нар бас холбогдох мэдээллийг өгч ажиллая.

**О.Номинчимэг:** 6 номер.

**С.Цогтгэрэл:** Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны дарга Цогтгэрэл. Санхүүгийн зохицуулах хорооноос түрүүн би хэлсэн энэ “Ногоон хөгжил

үндэсний нэгдэл” гэдэг компани бол давуу эрхийн хувьцаа хаалттай хүрээнд бүртгүүлэхээр нэмж гаргахаар хүсэлт өгсөн. Гэхдээ тэр хүсэлтийг бол 2022 онд бол хороо холбогдох шаардлагыг хангахгүй байна гээд зөвшөөрөл өгөөгүй. Энэ компани бол хувьцаа нэмж гаргаад тэр хувьцааг эзэмшүүлэх замаар иргэдээс хөрөнгө татан төвлөрүүлээд төсөл хэрэгжүүлнэ ээ гэдэг ийм асуудал үйл ажиллагаа явуулсан. Энэ дээр бол Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох зөвшөөрлийг өгөөгүй. Тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулах нь бол хориотой. Энэ асуудлыг бол хуулийн дагуу эрхлэх асуудлын хүрээнд цагдаагийн байгууллагад шилжүүлсэн байгаа.

**О.Номинчимэг:** Баярбаатар гишүүн асуулт асууя.

**Б.Баярбаатар:** Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Иргэдийнхээ бас гомдол, саналыг сонслоо. Цагдаагийн байгууллагын мэдээллийг сонслоо. Статистик тоо баримтуудыг харлаа. Харамсалтай байна. Тэгээд ер нь энэ хууль үйлчилдэггүй салбар бол энэ барилгын салбар болчихоод байгаа шүү дээ. Ямар нэгэн норм стандарт байхгүй. Хамгийн наад захын жишээ энэ авлигал хороолол гээд. Эсэргүүцээд байдаг, эсэргүүцээд байдаг, босохоо хүрвэл босчихдог юм байна. Хууль бус байсан ч гэсэн. Хэдэн ядарсан иргэдээ зальдсан барилгууд нь тэгээд ухсан нүх хэвээрээ байгаад байдаг. Тэгээд өнөөдөр энэ иргэддээ хандаж хэлэхэд Монгол Улсын Их Хурал 2025 оноос энэ Өргөдлийн байнгын хороог сэргээн байгуулж, өнөөдөр иргэдэд учирсан хохирол, гомдлын дагуу бас энэ 126 гишүүнтэй парламент энэ асуудлыг бас хэлэлцэж шийдвэрлэх ийм гарц гаргалгааг хайдаг, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгодог ийм зам нээгдсэн. Тийм учраас өнөөдөр бид энэ ширээ тойрч суугаад бас гол асуудлаа ярьж байгаа гэж хэлж болно.

Цагдаагийн байгууллагын хүч, хүн хүч, хүрэлцээ жоохон муу байдаг юм юм. Төсөв, санхүү бас тааруу байдаг юм. Хохирогчид бас энэ дээр бас илүү шахаж ажиллахынхаас илүүтэйгээр бас дэмжлэг үзүүлж ажиллах нь бас аль аль талдаа бас хэрэгтэй байдаг юм шүү гэдгийг би бас та бүхэндээ зөвлөө.

Ер нь энэ манай иргэд энэ хуулийн мэдлэг дутууг энэ аж ахуйн нэгжүүд их сайн ашиглах юм. Ухсан нүх, хэвлэсэн зургаар иргэдийг залилах асуудал ихсэж байна. Энэ иргэдийн итгэл, сэтгэл зүй дээр нь их тоглож байна. Энэ байртай болчихъё гэсэн итгэл үнэмшлийг нь маш их ашиглаж байна. Та сая тэр ямар ТББ ямар ногоон хөгжил гэнэ вэ? Өөрийгөө өмөөрөөд байх шаардлага байхгүй шүү дээ танд. Хохироочихсон юм бол тэгээд хохирлоо барагдуулах дээр яах вэ гэхээс гэдэг арга хэмжээ авч болдоггүй юм уу? Дээр нь наад хохирогчид чинь өнөөдөр бусад тэр зөвхөн мөнгөн хохирлоос гадна хохирлыг бол яриулбал бас л олон юм гарна шүү дээ. Хүний амь нас, байрны түрээс, айлд амьдарч байгаа гээд. Тэгэхээр эдгээр зүйлүүд дээр анхаарах хэрэгтэй байна гэдгийг бас би дахиж хэлье.

Ер нь бол зүгээр энэ ухсан нүх, хэвлэсэн зурагт бичихэд итгэл дээр залилж нэг хэсэг залилан хийсэн нөхдүүд байна. Үнэхээр бас буруу тооцоолол хийгээд бас нэг үйл ажиллагаагаа бас зогсоочихсон бас аж ахуйн нэгжүүд байна. Тэгэхээр энийг бас жоохон ялгаж салгах ёстой юм байна гэж харж байна. Би ажлын хэсэг байгуулж ажиллах ёстой юм байна. Үнэхээр 50-аас дээш хувийн гүйцэтгэлтэй явж байгаад ажил нь зогсчихсон хэдэн төсөл, арга хэмжээ байгаа юм? Үнэхээр ажлаа эхлээгүй иргэдээс баахан мөнгө аваад алга болчихсон хэдэн арга хэмжээ байгаа юм? Тэгээд энэ дээр тэр хууль хяналтын байгууллагууд дээрээ бас парламентад дэмжлэг үзүүлж ажиллах ёстой юм байна.

Зарим аж ахуйн нэгжийн захирлууд бас иргэдийн мөнгийг аваад мөрийтэй тоглоомд алдчихсан гэсэн мэдээллийг хүртэл би авсан байгаа. Ингэж бас болдог юм болов уу гэж. Би 1 минутаа нэмээд авчихъя.

**О.Номинчимэг:** Баярбаатар гишүүнд 1 минут нэмж өгье.

**Б.Баярбаатар:** Тэгэхээр миний асуух гээд байгаа гол агуулга юу вэ гэхээр манай иргэдээс одоо бараг байхгүй байх. Байр захиалахдаа даатгалд хамрагдсан иргэн байна уу? Аж ахуйн нэгжүүд энэ барилгын ажил эхлүүлэхээсээ өмнө төсөл, арга хэмжээгээ даатгуулсан аж ахуйн нэгж байна уу? Энэ талаар би асуулт асуумаар байна. Энэ дээр иргэдийн төлөөлөл үнэхээр даатгуулсан хүн байвал гараа өргөөд хариулчих. Даатгуулсан аж ахуйн нэгж байвал гараа өргөөд хариулчих.

Дахиад 1 минутаа нэмээд авчихъя. Ер нь бол даатгал гэдэг зүйл чинь өөрөө энэ юм байгаа юм иргэд ээ. Өнөөдөр төсөл хэрэгжүүлэх гэж байгаа аж ахуйн нэгж, барилга байшин захиалж байр авах гэж байгаа иргэн өнөөдөр даатгалд хамрагдах ёстой байдаг юм. Даатгал таны өмнөөс хяналт хэрэгжүүлдэг байхгүй юу. Яагаад гэвэл. 1 минутаа нэмээд авчихъя.

**О.Номинчимэг:** Баярбаатар гишүүн 1 минут.

**Б.Баярбаатар:** Яагаад гэвэл өнөөдөр янз бүрийн хохирол учрахад өмнөөс чинь тэр даатгал хохирол төлөх ёстой болчихож байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр даатгалын компани чинь аль болох хохирол төлөхгүйн тулд яах вэ гэдэг асуудал дээр хяналтаа сайжруулчихдаг байхгүй юу. Одоо энэ дээр ингээд хууль, эрх зүйн орчныг сайжруулах дээр манай төрийн захиргааны байгууллагууд анхаараарай. Хууль санаачлагчид энэ дээр бас бид нар ажиллах ёстой.

Өнөөдөр энэ даатгалд хамрагдаагүй барилга байгууламжид эхлэх гэж байгаа зөвшөөрлийг нь бол олгохгүй байх ёстой. Ямар нэгэн явцад тэр барилга дундаа зогслоо гэж үзэхэд даатгалын компани бүүр стандартуудаар нь, ямар цементээр тэр цутгалтаа хийж байна гэдэг хүртэл энэ хянадаг ийм системийг өнөөдөр даатгалын компани хэрэгжүүлж, хохирол гарвал өөрсдөө төлөх учраас иргэдийн өмнөөс тэр хяналтыг хэрэгжүүлдэг байгууллага нь өөрөө даатгал байх ёстой. Авлигад өртөхгүй тэд нар. Төрийн захиргааны байгууллагыг бодвол. Өөрсдөө нөхөн төлбөр олгохгүйн тулд асуудалдаа хандана. Тэгэхээр миний асуултад бол хариулах хүн байхгүй байх шиг байна. Зүгээр энэ дэвшил, санаачилгыг бас иргэдтэйгээ хамтраад

**О.Номинчимэг:** Баярбаатар гишүүн санал хэллээ. Даатгалын механизмыг оруулж ирэхгүй бол энэ хаа хаанаа энэ эрсдэл хуваарилах асуудал муу байгаа учраас энэ дээр хуулийн төсөл дээр анхаараарай. Даатгалын ялангуяа төсөл хэрэгжүүлж байгаа энэ барилгын компаниуд заавал даатгалтай байхгүй бол дандаа санхүүгийн чадавхгүй компаниуд орж ирж байж төсөл нь фэйлддэг, байхгүй болдог. Эцэс дүнд нь яах юм иргэд л хохирч байгаа асуудал байгаа учраас энэ асуудлыг анхаараарай гэдэг саналыг хэлж байна. Манай Барилгын яамныхан байна. Хууль зүйн яам байна уу? Хууль зүйн яамыг хааччихав аа? Төрийн нарийн уу? Орж ир гэж хэлээч. Пунсалмаа гишүүн асуулт асууя.

**Б.Пунсалмаа:** Сайн байцаана уу? Иргэд бол орон сууц захиалгынхаа явцад бас хохирох асуудал байна. Орон сууцдаа орж чадахгүй удах, бүр цаашлаад бүрэн хохирох ийм асуудлууд үүсээд байна. Ер нь бол энэ асуудал бол гол ер нь хохирч байгаа иргэд бол гадаадад байгаа иргэд, малчид, залуучууд эд нар бол ер нь их хохирч байна тиймээ. Тэгэхлээр ер нь энэ хохирлууд хаанаасаа эхлээд үүсээд байна гэхлээр гэрээний түвшнээс л эхэлж байгаа юм. Ерөөсөө иргэд өөрсдөө очоод барилгын компаниудтайгаа очоод гэрээгээ хийж байдаг.

Гэтэл үл хөдлөх хөрөнгө гэдэг бол энэ асар өндөр үнийн дүнтэй ийм гэрээ байж байдаг. Тэгэхлээр тэр барилгын компаниас ямар эрсдэл үүсэхийг, тэр том компаниас чинь ирж болох эрсдэлийг хувь хүн, иргэд бол бүрэн тооцоолох боломжгүй байхгүй юу. Тэгэхлээр ийм асуудал цаашдаа ч гэсэн үүсээд байх эрсдэл бол байна. Тэгэхлээр энийг олон улсын түвшинд ер нь яаж шийддэг юм бэ? Сайн туршлага юу байна? Энэ дээр манайх судалчихсан юмнууд байна уу? Захиалагч болон гүйцэтгэгч талуудыг хамгаалах хоёр талд, хоёуланд нь эрсдэл байгаа шүү дээ. Гүйцэтгэгч талуудад эрсдэл үүсэж болно. Захиалагч талд эрсдэл үүсэж болно. Энэ эрсдэлийг хаах үл хөдлөхийн дундын ийм хуулийн байгууллага, сая тэр даатгал гээд ярьж байна. Ийм механизмуудыг бид нар авч хэрэглэх хэрэгтэй байна.

Тэгэхлээр шинээр орж ирж байгаа энэ хуульд чинь ийм зүйл, заалтууд ийм хамгаалалтын ийм механизмууд сууж өгсөн үү гэдэг асуултыг асууя.

**О.Номинчимэг:** Бадамдорж Пунсалмаа гишүүний асуултад 4 номер Барилга, хот байгуулалтын яам.

**М.Баяраа:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Баяраа. Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Түрүүн дурдсан Барилгын ерөнхий хууль, Орон сууцжуулалтын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль гээд 3 хуулийг өргөн бариад одоо Засгийн газарт ирэх 7 хоног бол Орон сууцжуулалтын тухай хууль ингээд танилцуулагдаад явна. Олон улсын туршлагаас гэх юм бол Орон сууцжуулалтын тухай хууль дээр Солонгосын батлан даалтын сан гэж байдаг барилгын. Тухайн эхлэх гэж байгаа төслүүд дээр барилгын компани дээр батлан даалтыг гаргадаг. Энэ нь ганцхан санхүүгийн батлан даалт биш инженер, техник, технологийн бүх талынх нь судалгааг хийгээд, урьдчилгаа төлбөрийг батлан даалтын сан өөр дээрээ төвлөрүүлж аваад, барилгын ажлыг захиалагчтай хамтарч хэрэгжүүлдэг.

Тэгэхээр энэ мэтчилэн туршлагаудыг бол яг энэ хуульдаа бол бас тусгаж өгөөд батлан даалт гэдэг зохицуулалтыг бол оруулж өгсөн байгаа. Мөн түрүүн дурдсанчлан эрсдэлийн даатгалд хамрагдаагүй тохиолдолд иргэдээс хөрөнгө татахыг бол хориглосон заалтыг бол Барилгын ерөнхий хуульд оруулсан ийм заалтууд бол байгаа.

**О.Номинчимэг:** Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

**С.Ганбаатар:** Манай хариуцаж байгаа төрийн албаны дарга нар бол сэтгэл бага гаргажээ. Нарийн ярих юм бол тэдэн мянган хүмүүс хохирсон гэдэг статистик тооны ард уйлаан майлаан, салалт, тэгээд л хүний амь нас гээд зовлон ярьж байна шүү дээ. Миний хамаатнууд ч байгаа. Бид бүгдээрээ л энэ зовлонг мэднэ.

Үнэхээр сэтгэлгүй байна. Тэгээд яах вэ миний хувьд ч гэсэн дээ ний нуугүй хэлэхэд тэнгэрийн том том хулгайч нартай үзэлцээд л 20 гаран жил болчхож нэг мэдсэн. Оюу толгой, уран, газрын тос гээд нэг том супер луйвар цаана чинь явж байна. Ингээд том хулгайч нартай үзээд ерөөсөө үнэхээр бас яг энэ асуудал руу орж амжаагүй шүү. Эхэнд нь хэлье.

Тэгээд сэтгэл өвддөг өө. Зөндөө л энэ гадаа жагссан шүү дээ. Тэгээд би гарц гаргалгаа ярья. Хараад л, бие биеэ хараад л уйлаад байлтай нь биш одоо эндээс ч гарц, гаргалгаа гаргая л даа хэдүүлээ. Нэг иймэрхүү уулзалтууд чинь тэгээд л хоёр талаасаа уйлсаар байгаад л стрессээ тайлаад л гараад алга болж өгдөг. Гарц, гаргалгаа ярья.

1 дүгээрт, Үндсэн хуулийн 5.4-д ийм үг байдаг юм байна. Хувь, хувьсгал бүх эдийн засгийн энэ үйл ажиллагааг төрөөс зохион байгуулна. Төрийн зохицуулалттай гэж заасан байгаа. Бид төрийн зохицуулалттай эдийн засагт амьдарч байгаа. Тал дээр бэлчиж байгаа нэг хэдэн мал байгаад тэгээд хэдэн хоттой хонинд орсон чоно шиг хэдэн луйварчид нь ингээд идэж уудаг юм биш. Төр байгаа. Тэгэхлээр төр хариуцлага үүрнэ ээ гэсэн үг. Өнөөдөр энэ төрийн хариуцлагыг асууж байна шүү дээ.

Тэгэхлээр Барилгын яамнаас нэг юм асуугаадахъя даа. Бусад орнуудад би бас энэ талын туршлагууд бас байна. Тэгэхэд чинь энэ энэ 25, 100 юм уу, эсвэл 50 барилгын компаниас захиалга авч болно. Төрөөс энэний арын баталгааг нь даана, даатгалтай. Ямар нэгэн бэрхшээл гарвал эд нар мөнгөө дансанд хийчихсэн гэж ийм лист гаргадаг. Манайд тийм юм байна уу? Мэдээж байхгүй учраас ингэж ийм олон уйлаан майлаан болж байгаа. Яагаад энэ талаар та нар нэг ч санал гаргаагүй юм бэ? Тэр барилгын яамны нөхдүүдээсээ асууя даа. Энэ цагдаагийнхан болон бүр эрх зүйн орчин байхгүй ээ л гэж ганцхан хариулаад байна шүү дээ. Та нар энэ эрх зүйн орчны талаар сайжруулах талаар санал хэдэн удаа гаргасан бэ? Энэ 10 гаран жил эд нар ингээд уйлаан майлаантай явж байхад та нар маань зүгээр нэг ийм ажлаа хийгээд л цалингаа аваад л явж байгаа. Хэдэн удаа гаргасан бэ? Яагаад энэ бол өнөөдөр хүртэл хэлэлцэхгүй явсан юм бэ? Хариулаарай надад.

2 дугаар гарц, гаргалгаа. Би цаг, минут бага байна. Надад нэмэх боломж байгаа юу? 2 гаргалгаа байна. 1 дүгээрт яаралтай Номинчимэг даргаа Улсын Их Хурлын даргад хандаад, энэ хүмүүстэйгээ яг уулзаад энэ зүрхээрээ мэдрэх ёстой байхгүй юу. Гишүүд.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Ганбаатар гишүүнд нэмэлт 1 минут.

**С.Ганбаатар:** Тэгэхлээр. Би Бямбацогт дарга дээр яаралтай орж байгаа нь энэ яриад хэдэн сарын дараа хуулиа оруулчихсан шүү дээ гээд арьсаа хамгаалаад байгаа улсуудад өнөө маргаашгүй энэ 7 хоногт, энэ сардаа энэ хуулиудыг нь гараас гаргах ёстой гэдэг байдлаар ярья л гэж байгаа юм шүү. Энэ саналыг нь оруулъя. Энэ гарц.

2 дугаарт, одоо судлах шаардлага байхгүй шүү дээ. Энэ олон хүний нулимсаар хангалттай судаллаа шүү дээ бид нар. Судалгаа бэлэн. Энэ хэдэн мянган хүн байна. Тэгэхлээр хуулиа яаралтай гаргана. Уг нь бол одоо Цагдаагийн хууль хэдэн удаа та нар хандсан бэ? Ерөөсөө л удаагаад л залхаагаад л байдаг.

Шүүх, прокурор адилхан. Энэ дээр ямар нэгэн шийдэл хурдан яаралтай гаргая. Их Хурлын дарга дээр уулзалт хийе.

2 дугаар зүйл гэвэл иргэдтэй хамтарч яг энэ дээр.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Барилгын яамнаас хариулах уу? Хууль, эрх зүйн орчныг сайжруулах гэж өмнө ньб Одоогийн байгаа хүмүүс бол ер нь дандаа сүүлд очсон Барилгын яаман дээр очоод жил болоогүй хүмүүс байгаа. Хууль дээр ажиллаж байгаа хүмүүс байна. Гэхдээ Барилгын яамны хувьд энэ асуудал дээр хэрхэн анхаарч өмнөх жилүүдэд ажиллаж байсан гэдэг тоон мэдээлэл байвал хэлээдэх үү. 5 номер.

**Б.Найрамдал:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Ганбаатар гишүүний асуултад. Мэдээж хэрэг эрх зүйн зохицуулалт өнөөдөр тодорхойлсон зохицуулалт байхгүй болохоор энэ асуудлууд бол өнөөдөр ингээд үүсээд явсан. Үүнтэй холбоотойгоор өмнө бол яг энэнтэй холбоотойгоор хуульд нарийвчилсан бол заалтууд орж байсан. Саналууд бол яг албан ёсоор бол орж байгаагүй болохоор энэ асуудлууд ингээд явж байсан. Тэгээд энэ жилээс бид нар яг Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, шинээр орж ирж байгаа энэ Орон сууцжуулалт, орон сууцжуулах санхүүжилтийн банкны тухай хуулийн төсөл дээрээ яг энэ заалтуудыг нарийвчлан оруулъя гээд ингээд явж байгаа.

Барилгын тухай хууль бол өөрөө ер нь техникийн зохицуулалтыг тодорхой илүү заасан ийм органик манай Барилгын тухай хууль байгаа. Тэгээд түрүүн яг Номинчимэг гишүүний асуусантай холбоотойгоор одоо бид нар үнэхээр энэ бүтээцийн 50 хувьд хүрсэн тохиолдолд хөрөнгийг татан төвлөрүүлнэ ээ гээд ингээд оруулчихвал эргээгээд энэ дээр нь яг хэн нь хяналтаа тавих вэ гэхээр эргээгээд нөгөө Барилгын тухай хуулиараа салбарын хяналт тавья гэхээр энэ техникийн зохицуулалтыг хяналт тавих болчхоод байгаа учраас салбар хуулиуддаа зайлшгүй оруулах нь зүйтэй юм байна гэдгээрээ яваад дахиад салбар хуулиуддаа оруулаад саналуудаа бид нар аваад ингээд явж байгаа.

**О.Номинчимэг:** Ганбаатар гишүүний санал бол хууль, эрх зүйн орчин. Бид нар энэ асуудлаа ер нь 2 хувааж харж байгаа.

1 дүгээрт хууль, эрх зүйн орчин буюу дахиж ийм зүйл гаргахгүй байх тал дээр Барилгын яам, Хууль зүйн яам, Сайнзориг гишүүн гээд ингээд хууль боловсруулаад оруулах гэж байгаа хууль санаачлагч нар байгаа. Энэ дээр бид нар бүгд дээр нь саналаа өгч байгаа. Тэгээд энэ ташрамд хэлэхэд хууль санаачлагчдаа хэлэхэд хөлс усаа гарган байж олсон мөнгөөрөө барилга, орон сууц захиалаад хохирч байгаа иргэдийнхээ асуудлыг яаж шийдэх вэ гэдэг дээр энэ хуулийн зорилт нь хэрэгждэг байх, тэднийгээ хамгаалдаг байх дээр энэ зохицуулалт нь орох ёстой шүү. Манай органик хууль, тэрний салбар хууль тэгээд тэгээд гэдэг энэ манай яамны асуудал, тэр манай яамны асуудал биш гэдэг байдлаар хандахгүйгээр яг ингэж хандаарай гэдгийг хэлмээр байна.

Дараагийн нэг нь таны хэлээд байгаа одоо яг энэ иргэдийнхээ асуудал дээр бид төр яаж оролцох ёстой юм бэ гэдэг асуудал байгаа. Тэгээд энэ дээр бид энэ эхний асуудлын дараа дараагийн асуудал ажлын хэсэг байгуулна. Ажлын хэсэг дээрээ яг энд ирчихсэн, өргөдөл гаргачихсан иргэдийнхээ асуудлууд дээр бид нар хуваагдаж ажиллаад энэ дээр шүүх цагдаад нь байна уу, эсвэл тэр компанитай холбоотой асуудал байна уу тэгэх юм бол энэ компанитай бас холбоотой асуудал

дээр ч гэсэн бид нар медиатор маягийн энэ нөгөө үүргийг үнэхээр гүйцэтгэхээс аргагүй юм байна лээ. Бид өмнө нь уулзалт хийсэн. Энэ талд нь иргэд бид нар хохирлоо төлүүлмээр байна, хурдан хиймээр байна гэдэг.

Нөгөө талд нь барилгын компаниуд нь нэг өмгөөлөгчөө дагуулаад ирчихсэн тэгснээ бид хариуцлага хүлээхгүй ээ энийгээ өгчхөөд эндээс гараад явна гэдэг ийм байдлаар гэрээ зуруулах гээд явж байгаа байхгүй юу. Тэгээд хууль, эрх зүйн орчин байгаа хуулиа бид нар хэрэгжүүлж чадахгүй байгаад байгаа юм. Тэгээд байгаа хуулиа хэрэгжилтийг нь бид нар хангахын тулд яг энд нь тэр компаниуд иргэдийн дунд нь үнэхээр хууль, эрх зүйн орчин иргэдийгээ хамгаалсан энэ механизм тохиролцоо нь барьж байна уу гэдгийг авахгүй бол тэгээд л цаашаагаа ингээд л хэрэг мэрэг яваад өгөх юм бол одоогийн нөгөө цагдаа, шүүх юу нь уддаг, шүүхийн шийдвэр гүйцэтгэлд очоод гацдаг байгаад байгаа юм. Тэгэхээр энэ асуудлуудаа бид нар яг ангилаад эрэмбэ дараалаад Улсын Их Хурал, Өргөдлийн байнгын хороо гишүүд нь ажиллана гэдгийг бас тодруулаад хэлчихье.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн нэмэлт 1 минут. Тодруулга 1 минут.

**С.Ганбаатар:** Миний хүсэж байсан хариулт бол миний хэлснийг надад өөрөө буцаагаад хэлээдэх ээ гэж хэлээгүй шүү дээ. Эрх зүйн орчин муу байгаа гэдгийг бүгд мэдэж байгаа. Цалин аваад, хариуцлага үүрээд тэн дээр тэр оффист татварын мөнгөөр цалинжуулаад, санхүүжээд байж байгаа хүмүүс энэ асуудал болохгүй байна гэдгээр 3 удаа 3 жилийн дараалалтайгаар энэ Их Хуралд асуудал тавьсан ерөөсөө шийдэхгүй байна гэж саналаа оруулах нь та нарын үүрэг байдаг. Тэр талаар ямар ч юм хийгээгүй юм байна гэж би ойлголоо.

2 дугаарт тэр ажлын хэсэг байгуулахад тэрний гол үндсэн эрх зүйн тайлбар нь бол Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурал хууль, эрх зүйгээ зүгээр батлаад хаядаг биш хуулийн хэрэгжилтэд хяналт тавьдаг үндсэн үүрэг нь бас бидэнд байдаг. Энэ үүргийнхээ дагуу энэ хууль чинь хэрэгжихгүй. Цоорхой байгаад олон хүнийг зовоогоод байхад бид өнөөдөр ингээд ангайгаад 30 жил, 20 жил явчихсан байна гэдгээр ажлын хэсэг байгуулагдаж байгаа юм. Би тэгж ойлгож байна. Тэгээд хурд хэрэгтэй. 1 сар байна уу тодорхой хугацаа тавихгүй бол.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Баярлалаа. Санал нэг байгаа. Цөмөөрөө тогтоол гаргах дээрээ энийгээ тусгаад явна. Сайнзориг гишүүнийг асуулт асуух гишүүнд нэмье. Энэ хооронд би бас энд ирсэн зарим төрийн албан хаагчдаас асуулт асуух зүйл байна. Ялангуяа нийслэлийнхэн байгаа тээ? Нийслэлийнхэн маань тэр микрофонууд руу очиж байгаарай. Дахин төлөвлөлттэй холбоотой асуудал байна. Дахин төлөвлөлт гэр хорооллыг орон сууцжуулах асуудал бол агаар, хөрсний бохирдлыг бууруулах маш бас үр дүнтэй бодлогын нэг. Даанч энэ 2013, 2014 онд хийгдсэн дахин төлөвлөлтийн буруу схемээс болоод энэ төсөл нь явахгүй иргэд нь хохирсон асуудал маш их байгаа. Тэгээд өнөөдөр яг тэрний 1 жишээ болох энэ 2 жишээ манай энэ Өргөдлийн байнгын хороон дээр яригдлаа.

Ялангуяа тэр “Грийн ресурс” буюу “Хөх сувд” гэдэг БГД дээр хэрэгжиж байгаа төсөл байна. 12, 13 оноос хойш явж байгаа. Одоо хүртэл газраа өгчихсөн 12, 13 жил хүлээж байгаа 80 гарсан энэ иргэний асуудлыг шийдэхгүй болоогүй ээ гээд хэлээд байж байгаа нь үнэхээр хүний ёсонд нийцэхгүй байгаад байгаа юм. Би энэ Дэмбэрэл гуай яах вэ өнөөдөр төлөөлж үг хэлсэнгүй. Гэхдээ энийг бас бусад энд олон нийтэд нээлттэй энэ хэлэлцүүлэг, хурал явж байгаа анхаараасай гэж

бодож байгаа. Хүний өмч хөрөнгө болсон газрыг чөлөөлж авчхаад ээлж чинь болоогүй гээд 12, 3 жил өөр газруудаар амьдруулаад ингээд явж байгаа бол үнэхээр болохгүй байгаад байгаа юм.

Тэгээд энэний асуудлыг хараад үзэхээр тэгээд л төрийн л ерөнхийдөө алдаа болно шүү дээ энэ чинь. 12, 13 онд бид нар тэр дахин төлөвлөлтийг хийхдээ яг дэд бүтцээ энэ хурдтай газар чөлөөлөлттэйгөө зэрэгцүүлээд хийж болох юм уу? Дээр нь энэ дахин төлөвлөлтөөр орж ирж байгаа барилгын компаниуддаа хяналт тавьж чадсан уу, хяналтын механизм нь байсан уу? Жишээ нь энэ компани дээр бол ерөөсөө өөрөө аваад дахиад 1 гүйцэтгэгч гээд 2 компани оруулаад ирж байгаа. Гүйцэтгэгч ч юм уу хамтрагч ч юм уу хамтран ажиллах гэрээ гэдэгтэй.

Тэгээд өөрөө нэг хэдэн барилгынх нь орон сууцаас тоо, квотыг нь аваад бусдыг нь нөгөө компанидаа өгчихдөг. Энэ дээр нь давхар давхар захиалга яваад 1 байрыг 2, 3 хүнд давхар зарчихсан ийм асуудал болоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ нийслэл дээрээс болон Хот байгуулалтын яам бас оролцох байх. Энэ давхар дахин төлөвлөлтийн асуудал дээр ер нь захиалагчийн хяналтыг хийдэг юм уу? Захиалагч нь энэ гэрээний төр энийг чинь дахин төлөвлөлтөө хий гэдэг хууль гаргаад явж байгаа. Энэ дээр хийж байгаа ажил байна уу, хийдэг юм байна уу, хууль, эрх зүйн зохицуулалт нь юу байна? Дахин энэ нөгөө компаниуд чинь цүнхний баахан барилгын компаниудад өгөөд ингээд жижиглээд явчихдаг гэдэг асуудал байдаг. Энэ дээр нь хяналт хийдэг юм байгаа юм уу? Эрсдэл бууруулах талаар одоо хар лист гаргах тал дээр энэ дээр дахин төлөвлөлт дээр авч байгаа арга хэмжээнүүд юу байна? Энэ асуудлаас болоод өнөөдөр энд ирж байгаа 2 төсөл байна л даа. Нэг нь СБД-ийн. Нөгөөх нь БГД дээрх ийм олон иргэдийн асуудал яваад байна. Нийслэл энэ дээр нэг хариу өгөөдхөөч.

2 дугаарт, Барилгын яамны асуудал бол байгаад байгаа. Гэхдээ энэ дээр сүүлд үг хэлэх дээр би хэлье. Дараа нь бас Сайнзориг гишүүн асуулт асуух учраас нийслэлээс барилгын компаниуд дээрээ хяналт тавих, дахин төлөвлөлт дээр энэ чинь дахин төлөвлөлт чинь нийслэл барилгын компани иргэд 3-ын хооронд гуравласан гэрээ хийдэг гэрээний харилцаа үүсэж байгаа. Энэ дээрээ хяналт тавьдаг механизм, хууль, эрх зүйн орчин нь юу байна? Та хэд гүйцэтгэл дээрээ юун дээр анхаарч ажиллаж байна, эсвэл бүр анхаарахгүй орхичхов уу ингээд ийм үр дагавар гарчхав уу гэдэг дээр хариулт өгье. 2 номер уу? 2 номер.

**Ж.Болортуяа:** Нийслэлийн орон сууцын бодлогын газраас хариулт өгье. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгч болох “Грийн ресурс” компанийн үйл ажиллагаатай холбогдуулан хохирсон иргэдийн асуудал энд яригдаж байна. Өмнөх хуралдаан дээр бас энэ талаар товчхон мэдээлэл өгсөн байгаа. Давтаад товчхон өгчихье. “Грийн ресурс” компани нь Нийслэлийн Засаг даргын 2014 оны А343 дугаар захирамжаар БГД-ийн 10 дугаар хороо, бичил 7 дугаар орон сууцын хороолол орчинд дахин төлөвлөлтөөр төсөл хэрэгжүүлэгчээр батламжлагдаж өнөөдрийг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна. “Грийн ресурс” компани төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулаад “Азийн барилга” ХХК, “Эйч И Дрим Хаус” ХХК гэдэг 2 компанитай туслан гүйцэтгэх гэрээ байгуулдаг. Энэ гэрээ байгуулсан 2 компанитай орон сууц захиалгын гэрээ хийсэн. Давхардсан тоогоор 60 орчим иргэд манай Нийслэлийн орон сууцын бодлогын газарт орон сууцын давхар захиалга хийсэн гэдэг гомдол ирүүлдэг. Энэ гомдол 2023 оноос хойш манай байгууллагад ирүүлсний ирүүлдэг. 23 оноос хойш манайх төсөл хэрэгжүүлэгч “Грийн ресурс” компанид 10 гаран албан бичиг өгдөг. Энэ асуудлыг шийд гэж. Дээрээс нь харьяаллын дагуу БГД-ийн

Цагдаагийн хэлтэст энэ гомдлыг шалгаж хууль хяналт, хуулийн дагуу шийдвэрлэхийг хүсдэг.

Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль маань энэ гэр хорооллын дахин төлөвлөлтийн асуудлын харилцааг зохицуулдаг. Барилга, хот байгуулалтын яамны сайдын баталсан 46 дугаар тушаал гэж байдаг. Энэ маань гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны бас журам гэж байдаг. Үүгээр бас нарийвчлан зохицуулдаг. Энэ хууль, журмаар энэ дахин төлөвлөлтийн эрх авсан энэ барилга компаниуд үйл ажиллагааг тус хуулийн 26 дугаар зүйлд хяналтын хороо гэж байдаг. Энэ хяналтын хороо энэ төслийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавьдаг. Энэ хууль, эрх зүйн ийм зохицуулалттай байдаг.

Манай байгууллагаас энэ “Грийн ресурс” гэдэг компанийн төслийн үйл ажиллагаатай холбогдуулж иргэдээс гарсан гомдлыг 2025 онд Хяналтын хороогоор хэлэлцүүлдэг. 25 онд 2 удаагийн Хяналтын хороогоор хэлэлцүүлээд 25 оны 5 сард, 25 оны 9 сард Хяналтын хорооноос “Грийн ресурс” компанид хугацаатай үүрэг даалгавар өгсөн байдаг.

Харамсалтай нь өнөөдөр хүртэл “Грийн ресурс” компани Хяналтын хорооноос өгсөн үүрэг, даалгаврыг 100 хувь бүрэн биелүүлээгүй нөхцөл байдал байгаад байна. Яагаад гэхээр иргэдийн гомдол бүрэн барагдаж дуусаагүй. Энэ давхар захиалга авсан иргэдийн асуудал бол бүрэн шийдвэрлэгдээгүй ийм нөхцөл байдал байгаад байна.

Хуулийн хүрээнд бол манай байгууллагаас бол энэ иргэдийн асуудлыг шийдээч ээ гэдэг байдлаар төсөл хэрэгжүүлэгчдээ удаа дараагаар албан бичгээр болон Хяналтын хороогоор дамжуулж үүрэг.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

**П.Сайнзориг:** Өнөөдөр ч бас хүнд сэдвийн л талаар цаашид яах вэ гэдэг зүйл ярьж байна. Би зүгээр яах вэ 1 дүгээр санал бол яг энэ орон сууц захиалгын гэрээний дагуу залилсан залилан гэдэг юм уу, эргээд цаг хугацаандаа энэ гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байгаа энэ асуудлуудыг уг нь нэг яриад, гэр хорооллыг дахин төлөвлөлтийн асуудлуудыг уг нь нэг тусад нь ярих нь зүйтэй юм болов уу гэж зүгээр хувьдаа бодож байгаа. Бас ингээд холилдоход бас их хэцүү.

Тэгээд түрүүчээсээ энэ гэр хорооллыг дахин төлөвлөлтийн асуудлууд чинь 10 хэдэн жил үргэлжилж байгаа шүү дээ. Би ч бас Нийслэлийн Засаг даргын орлогч байж байхдаа энэ асуудлуудыг хохирогчийн төлөөлөл болгоныг авч уулзаад түрүүчээс нь гарц, шийдэл гаргаад явсан. Ихэнх компаниуд нь бол төлбөрийн чадваргүй дампууралд ороод явчихсан. Тэгэхээр бид хэд нөгөө эрсдэлийг томруулаад, томруулахаас нь өмнө төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа буюу тэр үйл ажиллагаа дээр шүүхийн оролцоотойгоор тэр гүйцэтгэх захирал, хувьцаа эзэмшигчдийг нь хязгаарлалт тавьж байгаад асуудлыг шийддэг энэ хууль, эрх зүйн орчин манайд байхгүйтэй л холбоотой. Бүх зүйл ингээд ужгирч байгаа юм. Тэгээд 2 өөр чихнээс өөргүй болчихсон зүйлүүд л үлдэж байгаа байхгүй юу.

Харамсалтай байдаг юм. Тэгээд энэ гэр хорооллыг дахин төлөвлөлтийн асуудлууд чинь тухайн үеийн нийслэлийн удирдлагуудын хамаарал бүхий болоод

ямар ч санхүүгийн чадавхгүй баахан компаниуд л өгчихсөн асуудал байдаг юм шүү дээ. Тэгээд ийм зүйлүүд байгаа.

Тэгэхдээ би их цаашдаа бас асуудлуудыг ингээд өнгөрсөнтэйгөө зууралдах биш яах вэ гэдэг нэг шийдэл байгаа юм. Тэгэхээр уг нь бол энэ салбарын бас хяналт гэж байдаг. Салбарын дотоод бизнесийн соёлын хяналт гэж байдаг, соёлын индикатор гэж байдаг. Хэр хариуцлагатай бизнес эрхлэгч вэ гэдэг. Тэгэхээр энийг уг нь бол сая Худалдаа аж үйлдвэрийн танхимын хуулиар л бид нар хийх гэх байсан юм л даа. Барилга барьдаг компаниудын танхим гараад танхимын тодорхой шаардлага, үйл ажиллагаа, иргэдийн гэрээний хэрэгжилтийг хэрхэн яаж хангаж байгаа асуудлаа төр засаг хууль хяналтын байгууллагаар шаардуулахаасаа илүүтэй яг энэ танхимын гишүүд өөрсдөө бие биедээ тавих нь дэлхийн бизнесийн соёлын том зарчим байхгүй юу. Тэндээсээ хэр найдвартай гэрээний үүргээ биелүүлдэг компани бэ гэдгийг ерөнхийдөө зарладаг. Тэгээд ямар энэ хариуцлагатай юу үгүй юу гэдгээ зарладаг.

Дээрээс нь хэрэглэгчийн эрх ашиг хамгаалах байгууллага хэрэглэгчид таатай нөхцөлтэй гэрээ байгуулдаг уу үгүй юу гэдэг асуудал дээр бас дүгнэлт хийж зарладаг. Жишээ нь Солонгос ийм байна. Монголын иргэд ч ер нь нэг хэрэглэгчийн гэрээ гэж ярьдаг юм л даа. Онолын түвшиндээ. 5 төрлийн гэрээнээс их орж байгаа. Зуучлалын гэрээ, боловсролын байгууллага, эрүүл мэнд. Энэ орон сууц худалдан авах захиалгын гэрээн дээр хохирч байгаа. Дээрээс нь ингээд бусад 3 төрлийн юм байгаа. Хамгийн их хохиролтой нь эд нар байхгүй юу. Тэгээд энийг бол бусад улс орнууд шиг яг ийм төрлийн гэрээг байгуулахдаа гэрээний үүргээ хэрхэн хангасан бэ гэдэг дээр дүгнэлт өгөөд хэрэглэгчдэд гэрээний таатай нөхцөл санал болгодоггүй. Гэрээний үүрэгжилттэй хангалттай байдаг уу гэдэг. Жишээ нь Хэрэглэгчийн төлөө газар ч гэсэн энийг зарладаг. Ингэж байж л бид нар шийддэг ёстой байсан. Тэгэхээр үнэхээр юу ч хийсэнгүй. Тэгээд би энэ Улсын бүртгэлийн хууль болон эд хөрөнгийн.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Сайнзориг гишүүнд 1 минут.

**П.Сайнзориг:** Тодорхой мэдээллүүдийг ил тод болгоод гэрээ бий болгож байгаа хүмүүс эрсдэлээ ингэж дүгнэдэг байдлаар шийдчихье гэсэн чинь Засгийн газар маань харин дэмжихгүй гэнэ. Уг нь яамнууд дэмжсэн юм байна. Тэгээд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга гэж нөхөр ингээд дуртай үедээ яамнууд ирсэн саналыг үл ойшоож байгаад. Яагаад гэхээр Сайнзориг байгаа учраас энэ хуулийг нь дэмжихгүй гэдэг санал өгч байна. Энэ олон мэдээллүүдийг ил болгоод нууцаас нь гаргаад өгье гэхээр дэмжихгүй гэж байна. Энэ сайн дурын шинжтэй буюу дуусаагүй барилгыг сайн дурын шинжтэй бүртгүүлж байгаад захиалга авах энэ асуудлыг нэг талд нь гаргаад, орон сууцын барилгуудыг заавал эхлээд бүртгүүлж байж дараа нь захиалга ав энэ дээрээ тэмдэглэгээгээ хий гэдэг Иргэний хуулийн зөв шийдлийг нь олъё гэсэн чинь дэмжихгүй гэж байна. Тэгээд ийм байдлаар асуудалд хувь хүний өнцгөөс ханддаг байхаар чинь яг яах юм бэ? Энд сууж байгаа иргэдийн өмнөөс юу гэж хэлэх юм. Энийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Энхбаярт би хэлж байгаа юм. Ингэж болдог юм уу? Яамнууд нь дэмжээд байхад та дэмжихгүй болохоор энэ хуулийн төслүүдийг дэмжихгүй гэдэг саналыг Засгийн газар өгчихдөг юм уу?

**О.Номинчимэг:** Тодруулга 1 минут Сайнзориг гишүүн.

**П.Сайнзориг:** Яг иргэдийн дунд нэг судалгаа хийж үзмээр байна. Яг одоо барилгын захиалгын гэрээ хийж байхдаа танд яг энэ барилга захиалгын техникийн нөхцөлүүд гарсан уу? Халуун, дулаан бусад нөхцөлүүд хангагдсан байсан уу, газрын эрх нь ямар байсан юм, дээрээс нь энэ дээр урьдчилсан захиалга хийгдсэн байсан уу, таны яг захиалах гэж байгаа тоот дээр ямар нэгэн банк болон ББСБ дээр барьцаанд байсан уу гэдэг зүйлүүдийг мэдэх тийм бололцоо байсан уу, мэдэж байсан уу? Тэгэхээр энэ зүйлүүдийг бид нар бас яах вэ дээ төлөөлөөд бас Барилгын яам маань судалгаа хиймээр байна. Юман дээрээ дүгнэлт өгмөөр байна.

Түүнээс биш ингээд хар даа нотариатаар дамжуулж юмаа шалга энэ тэр гээд иргэдэд дахиад нэг шат дамжлага битгий үүсгээч ээ Засгийн газар. Юмнуудыг нь ил тод ингээд болгоод өгье гэхээр дэмжихгүй гээд байх юм. Барилгын яам энэ асуудал дээр анхаарлаа хандуул. Тэгэхээр би энэ юунаас асуумаар байна? Цагдаагаас ийм нөхцөл байдлуудыг иргэд ер нь энэ гэрээ байгуулахдаа энэ төрлийн мэдээллүүдийг хөөрхий мэдсэн байж байна уу?

**О.Номинчимэг:** Сайнзориг гишүүний асуултад хариулъя 1 номер.

**Б.Батдэлгэр:** Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Иргэд тухайн эрх зүйн орчны талаар бол 1 дүгээрт бас мэдээлэл бас хомс байна.

2 дугаарт бол та түрүүн бас хэллээ энэ 2 ялгамжтай харж үзье гээд. Энэ залилах гэмт хэрэг яг үйлдэж байгаа этгээдүүд маань бол аль болох зохиомол байдлыг зориудаар бий болгож иргэдийг төөрөгдөлд оруулах болон хуурах аргаар бас энэ үйлдлүүдийг хийж байгаа. Энэ тохиолдолд бол иргэдэд мэдээжийн хэрэг байхгүй зүйлийг байгаа мэтээр, болохгүй зүйлийг болох мэтээр дандаа ойлгуулж, хуурч мэхэлж байгаа. Бусад тохиолдолд бол иргэд гэрээтэй холбоотой асуудлуудыг бол чухалчлах асуудал дээр үнийн дүнгийн санал, хямд орон сууцад хамруулах, барих, захиалга өгөх энэ асуудал дээр л нэлээн бас гол анхааралгүйгээр бас хандах асуудал л байгаад байгаа юм. Хариулт дууслаа.

**О.Номинчимэг:** Энэ Сайнзориг гишүүний хэлж байгаа асуудал их чухал байгаад байгаа юм. Тэгээд бид нар хууль, эрх зүйн орчноо нэн яаралтай сайжруулах ёстой. Тэгээд би өмнөх 7 хоногийн уулзалт дээр ч гэсэн хэлсэн. Энэ асуудлыг бид нар 4 сарын эхээр хамтарсан Барилгын яам, Хууль зүйн яам, цагдаа, шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэл шүүх биш эд нар хамтраад ингээд яг энэ асуудлууд дээр та бүхэн ажиллаач ээ гээд Өргөдлийн байнгын хорооноос хандсан Засгийн газрын Хэрэг эрхлэхэд. Өдийг хүртэл тэр хамтарсан ажлын хэсэг байгуулагдаагүй. Барилгын яам бол өөрийнхөө хүрээнд өөрийнхөө чиг үүргийн хүрээнд энэ асуудлыг бас шийдье гээд ингээд явж байгаа.

Төрийн байгууллага яг энэ гүйцэтгэх засаглал нь анхаарч байх ёстой зүйл дээр анхаарахгүй миний асуудал, чиний асуудал биш гэдэг байдлаар хандаад байхаар иргэдийн маань энэ хохирч байгаа асуудал ийм олон жил өнгөрөөд байгаа юм. Тэгээд юмыг бүх юмыг улс төр гэж харахаа болиод тулгамдаж байгаа иргэдийнхээ асуудал дээр өөрийнхөө чиг үүргийн дагуу ажлаа хийх ёстой байгаад байгаа байхгүй юу. Энэ ажлаа хийхгүй байгаа байдал чинь иргэдийн энэ бухимдал, ингээд хохирч байгаа бухимдал хүргээд байна гэдгийг бид нар хаа хаанаа ярьж байгаа, хэлж байгаа, гүйцэтгэх засаглалаасаа шаардана. Тэгээд энийг гүйцэтгэх засгийг хүлээхгүйгээр Улсын Их Хурал энэ дээр Өргөдлийн байнгын хороо энэ дээрээ өөрөө бас идэвхтэй ажиллаж шахалтыг үзүүлье ээ гэсэн

ийм байр суурьтай өнөөдөр бас зорилготойгоор та бүхэнтэйгээ санал солилцох энэ ажлыг хийж байгаа гэдгийг хэлмээр байна.

Иргэдээс маань маш их олон энэ ажил хэрэгч саналуудыг тавьж байгаа. Юун түрүүн энэ хохирч байгаа байдал бол хууль, эрх зүйн орчин чинь иргэдээ хамгаалсан биш цоорхойтой байгаа учраас бид өнөөгийн нөхцөл байдалд хүрчхээд байна гээд хэлж байгаа юм. Энэ зөв.

Бидний хувьд энэ хууль санаачилж оруулж ирэх гэж байгаа бас санаачлагчид маань байна. Юун түрүүнд өдий хүртэл явж ирсэн барилгын компаниуд зүв зүгээр цаас үзүүлээд агаар зарж мөнгө олдог байдлыг нэн тэргүүнд таслан зогсоох ёстой. Өмнө нь ч гэсэн олон ажил хэрэгч саналуудыг бид бас хэлсэн. Иргэдээс мөнгө татан төвлөрүүлж байгаа бол тэнд нь хяналтын механизм заавал байх ёстой. Энэ мөнгө нь үнэхээр тэр орон сууц барих барилгадаа орж байна уу гэдэг хяналтын дундын тэр санхүүгийн хяналт нь заавал байх ёстой. Хов хоосон цаасан дээр хүний мөнгийг насаараа хөдөлмөрлөж олсон хүний мөнгийг авчхаад кармалаад алга болдог энэ схемийг одоо зогсоохгүй бол бид түрүүн хэллээ шүү дээ. Маш олон мянган иргэдийн асуудал энд хөндөгдөж байна гээд.

Тэгээд нүдэн балай чихэн дүлий гэдэг шиг ингээд дүлий төр байгаад байж боломгүй байна. Энэ асуудлыгаа бид нар хууль, эрх зүйн орчиндоо оруулъя. Барилгын хяналт дээрээ та бүхэн бас анхаараач ээ. Энэ зөвшөөрөл бүх юм нь цэгцрээд явсан юман дээрээ барилгын зөвшөөрөл нь явдаг, тэн дээрээ захиалга авдаг нөхцөл байдлыг нь оруулаач ээ. Энийгээ, үүргээ хийж чаддаггүй нөхдүүдийг нь тэр хар листэд нь байдаг юм уу дахиж оруулдаггүй байдаг юм уу, Саранчулуун гишүүний хэлж байгаа тэр эцсийн өмчлөгчөөр нь хайж олдог энэ механизмыг бүрдүүлээч ээ. Хаана зөвшөөрөлтэй яг ном ёсоороо явж байгаа барилгын ажил байна гэдэг тэр мэдээллийг нь ил тод байлгаач ээ. Мэдээлэл ил тод байж байж л иргэд маань л иргэд маань мэдээлэлтэй байна илүү итгэлтэйгээр орон сууцаа авдаг болно.

Давхар юу гэдэг юм байрыг 2, 3 хүнд зардаг байдлыг энэ Улсын бүртгэлийн хуулиар засах ёстой. Энэ дээр бол энэ Сайнзориг гишүүний хууль дээр ч байгаа, бусад хуулиуд дээр ч гэсэн энэ саналууд уг нь явж байгаа. Гэхдээ энэ хуулийг хурдан оруулж ирж бид нар баталж, дараа дараа ийм асуудал гарахгүй байх дээр хурдан арга хэмжээ авмаар байна. Тэр дээр бас энэ дээр байгаа би төрийн байгууллагынхандаа хэлмээр байна. Ялангуяа энэ иргэдийнхээ эрх ашгийг хамгаалсан тал дээр энэ хуулиуд чинь байх ёстой шүү гэдгийг хэлмээр байна.

Ингээд өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд сая асуулт асууж дууслаа. Үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байвал нэрээ өгье.

3 гишүүнээр тасаллаа. 4 гишүүнээр тасаллаа. Дүгэрийн Рэгдэл гишүүн үг хэлье.

**Д.Рэгдэл:** 2 уулзалтаас нэлээн сайн мэдээлэл авлаа. Ер нь өнөөдрийн уулзалтаас хамгийн анхаарал татаж байгаа зүйл юу байна вэ гэх дээр зэрэг энэ орон сууцтай холбоотой шууд хохирогчийн тоо 15 мянга байгаа гэж хэллээ. Энэ бол ер нь асар их тоо шүү дээ тийм ээ. Тэгээд энэ 15 мянган хохирогчийн бодит хохирлын хэмжээг бол хэзээ ч гаргаж чадахгүй. Энэ чинь олон жил дамначихсан мөнгөний инфляц энэ тэртэй холбогдоод ийм л юмны үзүүр дээр л цөмөөрөө байгаад байна.

Тэгэхээр ер нь төрөөс яаралтай арга хэмжээ авах нь зүйтэй. Өнөөдөр энэ ажлын хэсэг байгуулагдаад, ажлын хэсэг яриад, нээлттэй сонсгол зохион байгуулах асуудал тавивал энийг дэмжээд оролцоод явахад бэлэн байна.

Ер нь мэдээж хэрэг энэ эрх зүйн зохицуулалттай холбоотой цоорхойнууд байна. Барилга, орон сууцжуулалтын яам 2, 3 хуулийн төсөл ирэх 7 хоногт өргөн барих юм байна. Тэгэхдээ бид нар аль ч тал ялгаагүй нэг юмыг ойлгох ёстой. Яагаад гэвэл энэ хууль ямар ч сайн хууль гараад батлагдсан ялгаа байхгүй энэ батлагдсан өдрөөсөө л хойших харьцааг зохицуулна.

Өөрөөр хэлбэл, тэр хууль батлагдсанаас хойш ингэж хохирох иргэдийн тоог цөөлөх тал дээр үйлчлэхээс биш эргэж бол үйлчлэхгүй ээ. Хохирсон улсуудын асуудал байдгаараа л байна. Тэгэхээр юуны өмнө манай энэ эрх, хүчний байгууллага, цэрэг цагдаагийн байгууллагууд, хууль цагдаагийн байгууллагууд энэ хохирогчийн асуудлыг давын өмнө 2 ангилчихмаар байгаа юм. Санаатай залилангийн асуудал гэж аваад.

Хоёрдугаарх нь төрийн буруу үйлдэл ч байдаг юм уу, эсвэл бас давагдашгүй хүчин зүйлийн улмаас ингээд иргэдийг хохироогоод байгаа асуудал гэж 2 ангилаад. Davын өмнө энэ санаатай залилангийнх дээрээ төвлөрөөд ажилламаар байгаа юм. Санаатай залилан. Энэ санаатай залилан бол энэ Монголд байгаад байгаа биш. Энэ дэлхийн олон оронд орон сууцын залилан бол одоо хүртэл явдаг. Энэ төгс боловсорсон схем. Манайд улам төгс болоод л явж байгаа. Тийм учраас санаатай залилан дээрээ хүчээ тавьж эхлээд ажилла, хийвэл яасан юм бэ гэсэн нэг ийм санал байгаа юм.

Тэгээд энэ санаатай залилангийн асуудал дээрээ энэ хууль, хүчний байгууллагад нь ажиллаад, нөгөө төрийн оролцоотой болон давагдашгүй хүчин зүйлтэй хэсэг дээрээ төр засгийн байгууллагууд нь ингээд ажиллавал бас ажил арай хурдан явах болов уу гэж ингэж бодож байна. Хохирогч нар асуудал тавьдаг одоо бид нар нөгөө мөнгөө авмааргүй байна. Энэ бол яах аргагүй КОВИД-ын өмнө 3 өрөө байрны мөнгө өгчихсэн хүн одоо мөнгөө авна гэвэл 1 өрөө байр ч авч чадахгүй. Мөнгөө авмааргүй байна гэж байгаа энэ тохиолдолд яах ёстой юм бэ? Энэ байрын үнийн өсөлтийг төрийн оролцоотой үнэ өсөөд байна гэдэг дээр би бол санал нэг байдаг шүү. Төр оролцож байна энд. Одоо ипотекийн зээл нэмэгдэх тусам байрны үнэ өсдөг. Ингэснээс болоод хохирогчдын мөнгө цаас болж хувирдаг.

Бүр хамгийн сүүлчийн жишээ гэхэд ноднингоос эхлээд байрны үнэ огцом нэмэгдээд энэ оны эцсээр бүр нэмэгдэнэ гэсэн тийм юм яриад байгаа шүү дээ. Яагаад вэ гэвэл Сэлбэ дэд төв дээр метр квадратыг нь 4 сая 800-гаар зарна гээд зарлаад хаячихсан. Тэгээд энэ чинь Сэлбэ дэд төвөөс нааших хотын энэ хавиар барьж байгаа баримтын үнийг үнэхээр хүчтэй нэмэгдүүлнэ. Энэ бол төр орон сууцын үнэ нэмэгдүүлээд та нарын хохирсон мөнгөний тоо цаас болоод байгаа юм. Тэгэхээр энэ төрийн оролцоог яаж бууруулах вэ гэдэг дээр энэ ажлын хэсэг байгуулагдвал маш анхаарч ажиллах хэрэгтэй байгаа юм.

Дараагийн нэг асуудал бол барилгын зөвшөөрөл авахаасаа өмнө мөнгөө цуглуулаад эхэлдэг. Энэ бол ерөнхий түгээмэл. Энэ бол хамгийн осолтой.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Отгоны Саранчулуун гишүүн үг хэлье.

**О.Саранчулуун:** Баярлалаа. Байр худалдан авч байгаа хүмүүс захиалагч, байрыг барьж байгаа орон сууц болон ер нь хаус ч юм уу барьж байгаа гүйцэтгэгч 2-ын дунд өрнөж байгаа ийм харилцаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр жишээлбэл би ингээд судлаад үзэхлээр дунд нь бартерын компаниуд, зуучлагч нар, зарим тохиолдолд СӨХ энэ тэр гээд ийм оролцогч талууд бий болж ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр захиалагч яагаад залилуулж байна гэхлээр энэ дээр аль аль талд нь захиалагч талдаа ч, гүйцэтгэгч талдаа ч даатгал гэдэг юм өнөөдөр манайд алга. Тэгэхээр энийгээ одоо Барилгын яам өргөн барих гэж байгаа Барилгын тухай хууль болон Орон сууцжуулалтын тухай хуульдаа бодитой тусгах талаар анхаарах хэрэгтэй байх гэж бодож байна.

Нөгөө талдаа энэ зарууд явж байгаа шүү дээ. Хувь лизинг байна, зээл ипотекийн зээл гаргана гээд ийм зарууд байна тээ. Бартераар, бартераар байр зарж байгаа энэ 3 чинь хамгийн их иргэдийг итгэл үнэмшлийг авч бас төөрөгдүүлж байгаа ийм магадлалтай байна гэдэг мэдээлэл байгаа байхгүй юу.

Ер нь цаашдаа хэрвээ төрийн оролцоог багасгая гэдэг зүйлийг бид нар ярьж л байгаа бол бид нар агентуудын асуудлыг ярилцахаас өөр аргагүй, СӨХ-өө ярихаас өөр аргагүй. Тэгэхээр энэ үл хөдлөх хөрөнгийн дээвэр холбоо гэж байгууллага байдаг юм уу тэр нь энэ Санхүүгийн зохицуулах хороо энэ тэр энэ агентын тухай хууль дээр ямар бодолтой байгаа юм юу өргөн барих юм гэдэг асуудлыг би өнөөдөр бол цаг бага учраас ярьж асууж тодруулж чадсангүй.

Энэ агентуудаар жишээлбэл борлуулагдсан байр залиланд өртөөгүй, илүү луйварт өртөөгүй гэсэн ийм тоо байгаа юм уу, байхгүй юм уу? Уг нь бол хүн санхүүгийн үйлчилгээ авахдаа бас мэргэжлийн хүний туслалцаатайгаар авдаг ийм соёл санхүүгийн салбарт байж байгаа шүү дээ. Тэгэхээр хэдийгээр үл хөдлөх хөрөнгө худалдаж авч байгаа ч гэсэн тэр чинь санхүүгийн мөнгөө зарцуулаад авч байгаа болохоор хэрэглэгч байгаа. Тэгэхээр энэ дунд хэрэглэгчдийг хэн бэ гэдэг судалгааг би асуугаад байсан нь тэр байхгүй юу. Иргэн буюу худалдан авагч, хэрэглэгч мэдээллийг олон талаас нь нягталж авах эрх нь байхгүй байгаад байгаа. Ялангуяа захиалагч байр зарж байгаа зуучлагч болон гүйцэтгэгч 2-ын дундын гэрээг захиалагч харах боломж байхгүй. 2 өөр царайтай 2 өөр хүн хүрч ирээд ийм байр байна гээд зарчхаад байдаг. Гэтэл гүйцэтгэгч дахиж гарч ирээд энэ чинь манай байр юм гээд дахиад зарлаад байдаг ийм л асуудал үүсээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр манай энэ Барилгын яам болон энэ холбогдох байгууллагууд энэ бүх харилцаа оролцогч талуудын оролцоог хангасан хуулийн зохицуулалтыг оруулж ирээч ээ гэдэг ийм саналыг хэлмээр байна.

Дараа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал яригдаж байгаа. Би өмнө нь Барилгын яаман дээр очиж байсан. Орон сууц орон, сууцыг борлуулж байгаа, орон сууцыг хүмүүст таниулж байгаа дээр бид нар ямрыг нь ер нь лакшири, тансаг хэрэглээ гээд байдгийг бас ойлгохгүй л байгаад байгаа. Яах вэ орц материалдаа байдаг байх л даа.

Гэхдээ хүн халтирч унадаггүй ямар ч хүн амьдрах нөхцөл хангагдсан тийм зүйлүүд чинь бас хүртээмжийн агуулгаараа уул нь тансаг зөв гэдэг байх ёстой байхад шинээр ашиглалтад орж байгаа бүх гоё, гоё гялгар байрууд чинь хүн халтирч унах хаалгатай, гялтгар плитатай, хаалга нь бүрэн онгойдоггүй, заримаас

нь зэвтэй ус гоождог ийм хотхонууд олноороо орж ирж байгаа байхгүй юу. Энэ мэтийн мэдээллүүд бол өнөөдрийн энэ дээр бол бараг бүүр 100 дугаар асуудал юм шиг байна. Орж ирээгүй байгаа.

Тэгэхээр энэ дээр бас ер нь цаашдаа ямар хууль эрх зүйн зохицуулалт хийх вэ гэдгийг бас ажиллах хэрэгтэй байгаа. Ер нь энэ дээр бол. Тэгэхээр ийм зүйлүүд дээр анхаарахгүй бол энэ 10 хэдэн мянган хүн чинь ахиад дараа жил болоход бараг 20 мянга, 30 мянга болоод нэмэгдэхээр юм шиг харагдаж байна шүү дээ. Ингээд тоон дүнгээрээ.

**О.Номинчимэг:** Сайнхүүгийн Ганбаатар гишүүн үг хэлье.

**С.Ганбаатар:** Манай Үндсэн хуульд нэг чухал үг байдаг л даа. Төрийн үндсэн үүрэг юу юм бэ гэвэл иргэдийн аюулгүй байдлыг хангах гэж байгаа юм шүү дээ. Иргэдийн эдийн засгийн аюулгүй байдлыг хангана гэсэн үг. Иргэд төрөөс өгсөн лицензтэй, төрөөс ипотект хамруулаад, төрийн бодлогоор төрийн хяналт доор үйл ажиллагаа явуулаад маш аюултай байдалд ороод гудамд гарчихсан байна л гэсэн үг 15 мянган иргэн.

Тэгэхлээр энэ дээр тэгээд л бид ингэж зовж зүдрээд гудамд луйвардуулчихлаа гээд хэлээд байхад өөдөөс нь эрх зүйн орчин байхгүй ээ гээд хэлээд сууна гэдэг бол гайхамшигтай бүх зүрх шүү. Үнэхээр энийг анхаарах ёстой л доо. Тэгээд гарц бол би түрүүн хэлсэн социализмын үед хяналт байсан юм шүү. Барилга захиалагчийн товчоо гэдэг бол ёстой ажиллаж байсан. Одоо нөгөө капитализм гээд даган дуурайгаад байгаа Америкт чинь хүртэл хувийн барилга баригдаж байхад төрөөс хүн очиж энэ зуурмагт нь элс нь их байна ирээдүйд энэ 20 жилийн дараа нурна шүү гэдгийг дандаа хэлж нураалгадаг. Ийм энгийн эрх зүйн орчин байхгүй олон жил явсан.

Тэгээд яах вэ яах вэ буруутай хайх гээгүй гарц хайж байгаа нь байна шүү дээ. Одоо хэдүүлээ тэр энэ талх дэлгүүрээс худалдаж авч байгаатай адилхан зүйл биш шүү дээ. Талхыг бол бид мэднэ. Хөгцөрчихсөн байна, үнэр орчихсон байна гээд. Энэ барилга гэдэг чинь бол хөндлөнгийн төрийн хяналт байдаг зүйл ээ. Эрүүл мэндийн даатгал гэдэгтэй бас адилхан. Би мөнгөө төлөөд ирээдүйд эрүүл мэндээ авна. Тэгэхэд хөндлөнгийн даатгалын байгууллага хянадаг.

Ингээд эрх зүйн орчин дээр нэг л зүйл хэлье дээ миний минут ч хурдан явдгийг хэлэх үү. Намайг ярихлаар л хурдан явуулаад байгаа юм шиг санагддаг юм шүү дээ сүүлдээ.

Найзууд минь ээ олон жил зарга хийж хүмүүс өмөөрсний хувьд хэлэхэд амь амиа бодож нэг нэгээрээ няц гишгүүлэв ээ. Хурдтай, яаралтай зохион байгуулалтад орох хэрэгтэй шүү. Хамгийн түрүүнд буруутай хүмүүс би ямар нэгэн барилгын компани гэж яриад яах вэ хөөрхий бас олон туслан гүйцэтгэгч нар хохирсон байгаа шүү бас. Энэ дээр бол хэн нэгэн буруутанг хайхаас илүү хамгийн түрүүнд буруутай хүмүүс чинь та нарыг задалж хуваахыг л боддог. Яаралтай зохион байгуулалтад орж, миний гол гарц гаргалгаа бол Барилгын холбоо гэж байгууллага байна. Тэр байгууллагыг Монголын төр дандаа үгүйсгэдэг. Түрүүн сая хэлсэн тэр манай гишүүд хэлж байна. Барилгын холбоогоор барилгын компаниудыг нэгтгэж зохион байгуулалтад орж тэр лиценз, зээлийн эрхүүдээ төр өгдөг болохоос биш гэрийнх нь гадаа авлигал өгөх гээд жагсаад зогсож байгаа тэр

хэдэн хүмүүст л баахан давуу тал өгснөөрөө л өнөөдөр энэ уйлаан майлаан болж байгаа юм шүү дээ. Бүүр цаад нарийн утга нь бол.

Тэгэхлээр Барилгын холбоо, тэр холбоо тэр төлөөллийн байгууллага, энэ барилга худалдаж авч байгаа улсуудын төлөөллийн байгууллага, энэ төр засаг, хууль, эрх зүйн холбоотой байгууллагууд нь нийлж 3 талт хэлэлцээр гэдгийг баруунд байнга улс болгон хийдэг юм. Салбарын хэлэлцээр гэж энийгээ нэрлэдэг. Энэ хэлэлцээрээ хууль гэж үздэг. Хууль батална гээд л 10 жил хүмүүсийг дуншуулаад зовоож байгаа бол жил, жил, 2, 2 жил батлаад байдаг хурдтай хууль гэдэг нь энэ салбарын хэлэлцээрийг хэлдэг. Салбарын хэлэлцээрийг хууль гэж үзнэ ээ гэдэг.

Тэгэхлээр нөгөө зовлон үзсэн чавганц гэдэг шиг нөгөө олон хүнтэй ингээд ингээд олон жил хүмүүсийг төлөөлөөд явахлаар энэ зохион байгуулалттай шууд яриад эхэлчихлээ шүү. Ерөөсөө л салбарын хэлэлцээр рүү яаралтай оролцъё, хохирогчдыг зохион байгуулалтад орж энэ дээр хууль, эрх зүйн хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт гаргуулах ёстой. Энэ бол бидний эн тэргүүнд хийх ёстой ажил гэж.

**О.Номинчимэг:** Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэлье.

**П.Сайнзориг:** Би ямар ч байсан Улсын бүртгэлийн хуульд нэмэлт оруулах энэ хуулийг санаачлаад өргөн барина. Засгаас саналаа авсан. Харамсалтай нь яамнууд дэмжээд байгаа мөртөө хэрэг эрхлэх газар дэмжихгүй гэдэг саналыг бичье.

Энэ хуулиар юу шийдэх гэж байгаа вэ гэхээр дуусаагүй барилга дээр үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гаргадаг сайн дурын шинжтэй, орон сууц дээр заавал үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гаргуулж авч байгаад бусдаас захиалга ав гэдэг ерөнхий суурь зарчим тогтоож өгнө.

Энэ ямар ямар мэдээллүүдийг ил тод болгох гээд байна гэхээр бусдаас орон сууц захиалга авсан юм уу, дээрээс нь барилгын ажлыг эхлэх зөвшөөрөл чинь байгаа юм уу, барилга баригдах газрын эрхийн бүртгэлийн мэдээлэл, кадастрын код, барилгын батлагдсан загвар зураг, батлагдсан зураг төсөв, техникийн нөхцөл чинь баталгаажсан шийдвэр чинь байгаа юм уу? Тэдгээрийн өөрчлөлтийн мэдээллүүдийг ил тод болгоё л гэж байгаа юм.

Энийг тэсэн Засгийн газар буюу Энхбаяр гэдэг хүн юу хэлсэн бэ гэхээр асар их олон мэдээллийг ил тод болгож байгаа нь хүний хувийн мэдээллийг халдах юм болж байна гэж байгаа байхгүй юу. Энд асар их иргэд хохироод өмч хөрөнгөөрөө ингээд хохироод байж байхад ийм сонин хариулт өгнө гэж байхгүй шүү дээ. Хүмүүс нэг карма өрөөнд амьдраад үзэх хэрэгтэй. Яг үнэндээ ерөнхийдөө орон сууцын захиалга өгөөд, орон сууцаа зараад, эсвэл гадаад ч юм уу олж ирээд ажиллаад тэр цуглуулсан хэдэн төгрөгөө өгчхөөд гэр бүлээрээ хүний карма өрөөнд амьдарч байгаа хүмүүс ямар сэтгэл зүйтэй байгаа бол, хүүхдүүд нь яаж байгаа бол? Ийм орчинд л өнөөдөр бид нар энэ асуудлуудыг оруулчхаад байна шүү дээ.

Тэгээд би энэ дээр бас цааш цаашдаа маш ажлын сайн дүгнэлт гаргаж байгаад хууль хяналтын байгууллагад эхний зөв жишиг тогтоож ядвал уг нь бол энэ класс акшин талдаа шийдэх ёстой юм. Класс акшин буюу тодорхой нэг хэрэг маргааныг шийдсэн энэ жишгийн дагуу дараа дараагийнх нь ийм хуулийн хүнд

процесс болохгүйгээр жишиглээд шууд онцлог онцлог кэйс ба кэйс дээр нь гарч байгаа тэр хохирлын хэмжээг нь тооцоод ч юм уу ингээд шууд дор дор нь асуудлуудыг нь шийддэг ийм жишиг рүү Монголын шүүхийн практик ч гэсэн орох ёстой. Тэгээд энэ бүх зүйлүүдийг уг нь маш олон жил ярьж явсан тэгээд ажил болохгүй.

Харамсалтай нь Засгийн газрын ялангуяа тэр дундаа хууль зүйн салбарыг удирдаж явж байгаа хүмүүс бид хэд бас анхаарах ёстой л байсан. Энэ ингээд хувилбарууд нь бэлэн байсан боловч ерөөсөө сүүлийн 2, 3 жил өргөн барьсангүй л дээ. Тэгээд ийм харамсалтай нөхцөл байдлууд үүсэж байна. Энэний цаана уг нь бас бизнесийн ёс зүй талаасаа бизнес эрхлэгчид маань бие биедээ шаардлага тавих тэр зүйл рүүгээ ормоор байгаа юм. Заавал хууль хяналтын байгууллагуудаар нэг хана нь шахагдаж байж биш. Тэгэхээр энэ бизнесийн салбар өөрөө энэ салбарыг бас нэг ёс зүйтэй байлгах, нэр хүндтэй байлгах, зүгээр бизнес эрхлэгчид нь бас дуугарах хэрэгтэй. Ийм ийм этгээдүүдээс ер нь цаашдаа бизнес явал хохирно шүү гэдэг. Энэ дээр бас тэр уг нь Барилгын холбоо гээд би бас ашгийн төлөө компаниуд холбоо явуулахын би эсрэг байдаг. Танхим байгуулах ёстой.

Тэр Худалдаа аж үйлдвэрийн танхимынхаа хуулийн дагуу барилга энэ барьдаг хүмүүс өөрсдөө танхимаа байгуулаад ийм ийм ёс зүйгүй этгээдүүд барилгын салбар дээр барилга барьж байгаа нэрээр иргэдийг залилаад байна шүү гэдгээ зарлах ёстой байхгүй юу. Ингэж байж энэ зах зээлийг өөрсдөө бизнес эрхлэгчид хамгаалах ёстой байхгүй юу. Тэгээд хийдэггүй. Бүгд нягтарч нийлэхээсээ айдаг. Монголчууд чинь ер нь тэгээд их арчаагүй юм аа. Өөрөө л болж байвал бусдууд нь хамаагүй ийм нийгэм болчихоод байгаа учраас бид хэд үнэндээ хэлэхэд бие биедээ зарчмын хувьд, хүн чанарын хувьд, хууль зүйн хувьд туслахаа больсон байна. Хамт нэг завин дээр байгаа гэдгээ ерөөсөө энэ Монгол улсын нийт иргэд ойлгохоо больсон байна. Би л өнөөдөртөө болж байвал бусдууд нь хамаагүй, би л нэр хүндтэй болж байвал бусад нь хамаагүй. Би л өнөөдөр нэг өмчөө салгаад авчихвал би нэг хэдэн метр квадрат илүү тэр барилга барих гэж байгаа нөхдүүдээсээ авчихвал хамаагүй гээд дахин төлөвлөлт дээр тэгж л хандаж байна шүү дээ. Тэгээд юманд нэг зарчим, юманд нэг шударга өмчийг эзэн болох.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Орон сууц захиалах, худалдан авахтай холбоотой захиалгын гэрээ байгуулсан, хохирсон иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын хүрээнд иргэдийнхээ төлөөллийн санал, хүсэлт, холбогдох байгууллагын тайлбар, мэдээллийг хэлэлцүүлж дууслаа. Энэний мөрөөр сая гишүүд маань бүгд бас идэвхтэй саналаа илэрхийллээ. Идэвхтэй бас энэ ажил дараа нь үр дүн гарах чиглэл рүү хамтарч бас ажиллана гэдэгт итгэж байна.

Өнөөдрийн энэ асуудалд оролцсон, цагаа гаргаж ирсэн иргэддээ юун түрүүнд маш их баярлалаа гэж хэлмээр байна. Мөн өөрсдийнхөө бас нөхцөл байдлыг хэлэхээр ирсэн аж ахуйн нэгжүүддээ баярлалаа. Та бүхэн маань иргэдийнхээ бас энэ асуудлыг харж, хамтарч шийдэх тал дээр санаачилгатай ажиллаасай гэж хүсэж байна. Мөн төрийн байгууллагууд, хууль хяналтын байгууллагуудаас ч гэсэн биднээс энэ өгсөн мэдээллүүд дээр маш анхааралтай ажиллаж, үр дүн гаргах дээр анхаарч ажиллаасай гэж хүсэж байна. Хянан шалгах ажлын хэсэг байгуулагдана. Та бүхэнтэй ялангуяа төрийн байгууллагуудтай шахаж ажиллах ийм хуваарьтай байгаа шүү гэдгийг бас хэлье ээ. Ингээд өнөөдрийн 1

дүгээр асуудал хэлэлцүүлж дууслаа. Ирсэн бүх, оролцсон хүмүүстээ баярлалаа. Дараагийн асуудалдаа оръё.

2 дугаар асуудал. Ажлын хэсэг. Одоо ажлын хэсэг.

13.22 цаг

### **Хэлэлцэх асуудлын 2 буюу “Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.**

Яг сая хэлэлцсэн эхний асуудлаар бид Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хуралдаанд хийх төлөвлөгөөт хянан шалгалтын цаглаварт туссан орон сууц захиалах, худалдан авах харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн биелэлтийн талаар мэдээлэл сонсох арга хэмжээний хүрээнд Байнгын хорооны 2026 оны 03 дугаар сарын 17-ны болон 05 дугаар сарын 20-ны хурлаар хэлэлцсэн.

Үүнтэй холбогдуулан орон сууц захиалж хохирсон иргэдээс ирүүлсэн өргөдөл, холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг шалган судалж, санал дүгнэлт гаргах шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулахаар түүний үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар батлахаар Байнгын хорооны тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төслийг та бүхэнд танилцуулсан байгаа. Гэхдээ энэ гишүүд дээр та бүхэн бас саналаа хэлээрэй. Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай буюу Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.4, 22.3.10, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хянан шалгалтын цаглаварт тусгагдсан орон сууц захиалах, худалдан авах харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээллийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан орон сууц захиалж хохирсон иргэдээс өгсөн өргөдөл, холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг шалган судалж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл буюу Улсын Их Хурлын тогтоолын төсөл гэж бид харж байгаа.

Шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчаар Одсүрэнгийн Номинчимэг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга, гишүүд дээр та бүхнээсээ бас би санал авъя гэж бодож байна. Жаргалсайханы Золжаргал гишүүн бол оръё гэсэн байгаа. Мөнхтуяа гишүүн маань бас оръё гэсэн байгаа. Бусад гишүүдээс бол ерөнхийдөө бас оруулчихсан байгаа боловч өнөөдөр бидний юу яаж байгаагаар Пунсалмаа гишүүн маань оръё гэсэн байна. Баярбаатар гишүүн бас оръё гэсэн. Дахиад өөр хүсэлтэй гишүүн байна уу? Тэгвэл Ганзоригийн Лувсанжамц гишүүнийг, Сарнай гишүүн орох уу? Сарнай гишүүн оръё. Тэгээд Ганзоригийн Лувсанжамц гишүүнийг оруулъя. Ийм бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсгийн байгууллагаар тогтоолын төсөлд орууллаа.

Гишүүдээр Золжаргал гишүүн, Лувсанжамц гишүүн, Мөнхтуяа гишүүн, Пунсалмаа гишүүн, Баярбаатар гишүүн, Сарнай гишүүн.

2 ажлын хэсгийн удирдамжийг хавсралтаар баталсугай. Та бүхэнд хавсралтаар тараасан байгаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахаар байна. Тэгээд хяналт шалгалт хийж байгаа учраас Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газраас орно. Мөн төрийн байгууллага, цагдаа, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, саяын холбогдох энэ бүх төрийн байгууллагуудаас бас татан оролцуулахаар байгаа.

3 дугаарт, Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтныг татан оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй.

4 дүгээрт, ажлын хэсгийн санал, дүгнэлт, холбогдох шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6, 9.8 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэн хэлэлцүүлэх тогтоолын биелэлтийг Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулган буюу энэ чуулганаар гэсэн үг, одоо бидэнд бол 1 сар гарангын л хугацаа байна. Хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хорооны хуралдаан танилцуулгыг ажлын хэсэгт даалгасугай гэсэн ийм Байнгын хорооны тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү.

Алга байна. Ойлгомжтой гэж үзэж байх шиг байна. Бид ялт ч үгүй энэ иргэдийнхээ өргөдөл, гомдлыг яаралтай бид нар шийдвэрлэж, цаашдын алхмыг бас тодорхойлох хэрэгтэй байгаа. Санал хэлэх, асуулт асуух гишүүд байхгүй байна.

Ингэхээр тогтоолын төсөл батлахаар гишүүд санал хураалтдаа бэлдье. Ганбаатар гишүүн орчихлоо. 6, өшөө хэн байна? Галаа гишүүн санал хураалтад бэлдье. Та ороогүй байх шиг байна тийм. Орчхов уу?

Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Нийт 12 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 66.7 хувиар энэ санал дэмжигдлээ.

“Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 3. Ажлын хэсгийн ахлагчийг дуудаарай Рэгдэл гишүүнийг.

13.29 цаг

**Ахмад настнуудаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлж, цалингийн итгэлцүүрээр тэтгэврийг шинэчлэн тогтооход ахмадуудын тэтгэврийн хэмжээ багассан асуудлаар ирүүлсэн иргэдийн өргөдлийг судлан, санал,**

**дүгнэлт болон шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.**

Энэ ажлын хэсэг Рэгдэл гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг гарсан. Рэгдэл гишүүн гадаад уулзалттай юу тээ. Саранчулуун гишүүн маань танилцуулахаар байна. Түүнээс өмнө хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолтой ажлын хэсгийн, албан тушаалтнуудыг танхимд оруулъя. Төрийн байгууллагууд, Гэр бүл хөгжлийн яам, Гэр бүлийн сайдыг бас дуудаарай. Ажлын хэсгийнхэн хурдан байрандаа сууцгаая. Ажлын хэсгийн микрофонтой газруудаар суугаарай.

Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Отгоны Саранчулуун гишүүн таныг санал, дүгнэлтээ танилцуулахыг урьж байна. Отгоны Саранчулуун гишүүний микрофоныг өгье.

**О.Саранчулуун:** Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлж, цалингийн итгэлцүүрээр тэтгэврийг шинэчлэн тогтоох талаарх иргэдээс ирүүлсэн өргөдлийг судлан, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны гишүүд ээ,

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд хандан ахмад настан М.Магсар, М.Оюунчимэг, М.Баатар, Д.Энхсайхан, Ц.Авирмэд, Д.Цэдэв, СХД-ийн Ахмадын хорооноос Г.Эрдэнэбазар нарын 12 иргэн, Д.Батбаяр, Д.Наранцэцэг, С.Жавзандулам, С.Сосорбарам, Х.Хишигсүрэн, Б.Жаргалсүрэн, Ж.Баттулга, Б.Гантуяа, Л.Отгончимэг, О.Зандраа, Г.Цэнд-Аюуш, Д.Хишигдорж, Б.Цэрэнчимэд нарын иргэд болон Монголын ахмадын холбоогоор уламжлуулан Өмнөговь, Завхан, Сэлэнгэ, Ховд, Төв аймгийн ахмадуудаас төрөөс амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодоход баримтлах цалингийн итгэлцүүрийг 2014 оноос 2023 он хүртэл 9 жилийн хугацаанд тухай бүр шинэчлэн батлаагүйгээс ахмадуудын тэтгэврийн зөрүү үүссэн бөгөөд Засгийн газар 2023 онд 238 дугаар тогтоолоор итгэлцүүр шинэчлэн тогтоохдоо даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн хугацаанаас хамаарч ялгаатай байхаар тогтоосноос олон жил улс орны чухал салбаруудад хөдөлмөрлөж, харьцангуй өндөр цалин хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэлээ тасралтгүй төлж, 2013 оноос өмнө тэтгэвэрт гарсан ахмадууд анх тэтгэвэр тогтоолгохдоо бодит цалингаа хязгаарлуулсан бөгөөд итгэлцүүр шинэчлэн тогтооход тэтгэврийн хэмжээ нэмэгдээгүй, зарим иргэдийн тэтгэвэр буурсан тул уг хязгаарлалтыг тавихгүй байх, эсхүл нэмэгдүүлж тэтгэврийг шударгаар дахин бодуулах зэрэг асуудлаар өргөдөл ирүүлсний дагуу Өргөдлийн байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор ажлын хэсэг байгуулан ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл ахалж, гишүүдээр С.Замира, Л.Мөнхбаясгалан, Б.Пунсалмаа, О.Саранчулуун, С.Эрдэнэбат нар ажиллалаа.

Ажлын хэсэг байгуулагдан ажилласнаас хойших хугацаанд Өргөдлийн байнгын хороо болон ажлын хэсгийн ахлагчид хандан С.Ариунтуяа, С.Хүрэлбаатар, Б.Энхсүвд, Ц.Амаргэрэл нарын зэрэг өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн, тэтгэвэр тогтоолгохоор хүлээгдэж байгаа иргэдээс Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу Засгийн газрын баталсан итгэлцүүр нь өнөөгийн мөнгөний үнэ цэнд хүрэхгүй байгаа бөгөөд холбогдох төрийн байгууллагууд дээрх хуульд заасны дагуу математик үйлдэл, тооцооллыг

улсын дундаж цалин, хэрэглээний үнийн өсөлттэй уялдуулаагүй байгааг нягтлан үзэж холбогдох байгууллагуудад үүрэг, чиглэл өгөх талаар өргөдлүүд нэмж ирүүлсээр байна.

Ажлын хэсэг энэ хугацаанд 3 удаа хуралдаж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар Үндэсний статистикийн хорооны холбогдох албан тушаалтнууд Монголын ахмадын хороо болон ахмадын зарим хороодын төлөөллийг хүлээн авч уулзан шаардлагатай тайлбар, мэдээллийг авч гаргасан судалгаатай танилцлаа.

Мөн Өргөдлийн байнгын хороонд ирүүлсэн өргөдлүүдийг ажлын хэсгийн гишүүдэд хуваарилан өгч, гишүүд, өргөдөл гаргагчтай, иргэдтэй биечлэн болон утсаар холбогдож, тодруулга тайлбарыг авч, хариуцсан байгууллагатай холбон зөвлөгөө өгөх зэргээр бүх талын оролцоог хангахад анхааран ажиллалаа.

Улсын Их Хурлын гишүүн ажлын хэсгийн ахлагч Д.Рэгдэлээс Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Нийгмийн даатгалын ерөнхий газарт хуулийн хүрээнд тэтгэвэр тогтоох сарын хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын хэмжээг 2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл сая 404 мянган төгрөгөөр байгааг нэмэгдүүлэх боломжийн талаар хувилбарт санал бэлтгэн ирүүлэх талаар албан бичиг хүргүүлэн хариу аваад байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчлэн найруулгаар даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход хэрэглэх итгэлцүүрийг Засгийн газраас жил бүр тогтоохоор зохицуулсан боловч Засгийн газрын итгэлцүүр шинэчлэн тогтоох тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2023 оны 238 дугаар тогтоолоор даатгуулагчид Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж тогтоох, цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтоох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 9 жилийн дараа шинэчлэн баталсан байна.

Мөн дээрх хуулийн хүрээнд даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход хэрэглэх итгэлцүүрийг Засгийн газар 2023 оны 238 дугаар, 2024 оны 231 дүгээр, 2025 оны 65 дугаар тогтоолуудаар тус тус баталжээ.

Харин эдгээр итгэлцүүрээр тэтгэвэр тогтоох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээнд Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолтой адил буюу тэтгэвэр тогтоох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээнд өөрчлөлт оруулаагүй байна.

Засгийн газрын тэтгэврийн шинэчлэлийн бодлого хэрэгжүүлж, тэтгэврийн зөрүүг арилгах асуудалд анхаарал хандуулж, итгэлцүүр шинэчлэн тогтоох тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоол баталж, ахмадын тэтгэврийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч байгаа боловч тэтгэвэр тогтоох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг тэтгэвэр тогтоолгосон хугацаанаас хамааруулан зохицуулалт хийснээс болж зарим нэмэгдэхгүй нөхцөл бүрдсэн байна гэж үзэж тэтгэвэр бодох цалин хөлс түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийн өсөлттэй уялдуулан шинэчлэн тогтоох нь зайлшгүй шаардлагатай гэж үзлээ.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны тооцоогоор тэтгэвэр тогтоох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ 2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө тэтгэвэр тогтоолгогчдын хувьд сая 404 мянган төгрөг байгааг сая 920 мянган төгрөг болгоход 119.3 мянган ахмадын тэтгэвэр дунджаар 135.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, 194505, уучлаарай 1 тэрбум 940 сая аравны 5-н тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэр 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 2 сая 400 мянган төгрөг болгоход 141 мянган ахмадын тэтгэвэр дунджаар 192 мянган төгрөгөөр нэмэгдэж, 325.4 тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэр, мөн хэмжээг 3 сая 200 мянга төгрөг болгоход 153 мянган ахмадын тэтгэвэр дунджаар 256 мянган төгрөгөөр нэмэгдэж, 472 тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэр тус тус шаардахаар байгаа юм.

Гэр бүл, нийгмийн хамгааллын сайдын 26 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 1426 дугаартай албан бичгийг бас бид хавсаргасан болно.

Ажлын хэсгээс өнөөгийн мөрдөгдөж буй хууль, эрх зүйн орчны хүрээнд төстэй ажил мэргэжлээр ойролцоо хугацаанд ажиллаж, шимтгэл төлсөн иргэдийн тэтгэврийн хэмжээ нь тэтгэвэр тогтоолгосон оноосоо хамаарч их ялгаатай байгааг ойртуулах зорилгоор дараах арга хэмжээг авах нь зүйтэй талаар санал, дүгнэлтийг Байнгын хороонд танилцуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1.Тэтгэвэр бодох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 2 сая 400 мянган төгрөгөөр тогтооход шаардагдах 325.4 тэрбум төгрөгийг Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсөвт тусгах.

2.Засгийн газраас 2026 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн мэдүүлсэн тохиолдолд энэхүү тулгамдсан асуудлын тодорхой хэсгийг шийдвэрлэх боломжийг судалж оруулах.

3.Тэтгэврийн зөрүүг багасгах хүрээнд эхний ээлжид бага тэтгэвэр тогтоолгосон ахмадын тэтгэврийн индексжүүлээгүй цаг хугацааны алдагдлыг нөхөж олгох асуудлыг судлах, нийгмийн даатгалын шимтгэлээ хамгийн бага хувиар төлж, тэтгэвэр тогтоолгох сүүлийн 5-н жилийг огцом өсгөж, өндөр тэтгэврээ тогтоолгож байгаа хуулийн хийдлийг арилгах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

4.Үндэсний статистикийн хорооноос ахмадын хэрэглэдэг гол нэрийн барааны сагсыг судлан шинжлэхийн зэрэгцээ холбогдох төрийн байгууллагууд итгэлцүүр тооцож байгаа аргачлалаа нарийвчлан боловсруулж хэд хэдэн хувилбараар тооцоолол хийж аргачлалаа яаралтай албажуулж, олон нийтэд сурталчлан таниулах.

5.Тэтгэвэр тогтоолгох эрх эрх үүссэн, тэтгэвэр тогтоолгохоор хүлээгдэж байгаа болон ирээдүйд тэтгэвэр тогтоолгох иргэдэд тэтгэвэрт гарахад бэлдэх анхаарах асуудлыг энэ талаар тодорхой, ойлгомжтой мэдээллийг насны бүлгээр гарган хүртээмжтэй олон сувгаар хүргэх ажлыг зохион байгуулж иргэдийг соён гэгээрүүлэхэд анхаарах.

6.Нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн тэтгэврээс гадна хуримтлалын буюу хувийн, сайн дурын нэмэлт тэтгэврийг олон давхаргат тогтолцоог хөгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бий болгоход анхаарах.

7.Цаашид даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж тогтоох, цэргийн албан хаагчийн тэтгэвэр тогтоох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг тэтгэвэр тогтоолгосон хугацаанаас хамааруулан олон хувилбараар тооцож хэрэгжүүлж буй өнөөгийн тогтолцоо нь тэтгэврийн зөрүүг арилгах ажлыг жил ирэх тусам хүндрүүлэх магадлалтай байгаа учраас үүнийг эргэн авч үзэж, шинэчлэх боломжийг ойрын үед тодорхойлох зэрэгт анхааран ажиллах шаардлагатай байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн ажлын хэсгийн ахлагч Д.Рэгдэл.

**О.Номинчимэг:** Саранчулуун гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг танилцуулсанд.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Төрийн нарийны орлон байгаа юм уу? Байхгүй байгаа юм уу? Энэ хэн эд нар нь. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга Рэнцэнханд ирсэн байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Батжаргал ирсэн байна. Өөр хэн хэн ирсэн бэ? Энэ чинь юу алга байна шүү дээ. Сангийн яам эд нар бүгдээрээ байхгүй байна шүү дээ. Надад ийм нэрс өгчхөөд. Сайд нь байгаа юм уу? Сайд, Төрийн нарийн нь байгаа юм уу? Хэн хэн ирсэн юм? Аубакир сайд яг засгийн хурал дуусаад хэвлэлийн хурал хийж байна уу?

Энэ асуудал итгэлцүүрийн тооцооллын асуудал бол ажлын хэсэг дээр яригдаад Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан бас ахмадуудтай холбоотой том ажлын хэсэг байгаа. Тодорхой арга хэмжээг ч гэсэн Гэр бүл, нийгмийн хамгааллын яам бас судлаад боловсруулаад явж байгаа гэж ойлгож байгаа байх. Энэ гадаа олон хоног жагсаж байгаа ахмадуудынхаа дуу хоолойг сонсож энэ төрийн бодлогодоо бас тусгах нь бидний үүрэг гэж харж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ганцэцэг ирсэн байна. Үндэсний статистикийн хорооны Нийгмийн статистикийн газрын дарга Ариунболд ирсэн байна. Үндэсний статистикийн хорооны Эдийн засгийн статистикийн газрын дарга Оюунжаргал ирсэн байна. Үндэсний статистикийн хорооны Үнийн статистикийн хэлтсийн дарга Мөнх-Оргил ирсэн байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын шинжээч Цэрэнбат ирсэн байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын шинжээч Баянжаргал ирсэн байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Пунцагцэрэн, Үндэсний статистикийн хорооны Нийгмийн статистикийн хэлтсээс Урангоо нар ирсэн байна. Ерөнхийдөө Нийгмийн даатгалын ерөнхий газар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикаас ирсэн ажлын хэсэг байна.

Ингээд өнөөдрийн ажлын хэсгийн, танилцуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан асуух асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүн асуулт асууя.

**С.Ганбаатар:** Хамгийн чухал, бас л чухал асуудлууд орж ирж байна даа. Энэ бол бүүр нийтлэг чухал. Тэгээд миний асуух асуулт бол энэ хүмүүс их сайн хөдөлмөрлөж, бас сайн юм хийжээ. Тэгээд барьцтай ямар ч тодорхой юм алга л даа. Нийгмийн даатгалын сангийн ингээд өргөн мэдүүлсэн тохиолдолд энэхүү тулгамдсан асуудлын тодорхой хэсгийг шийдвэрлэх боломжийг судалж оруулах 2 дээр байгаа, хийдлийг арилгах эрх зүйн орчныг бүрдүүлэх 3 дээр байгаа, 4 дүгээр юман дээр нь бол энэ итгэлцүүр тооцож байгаа аргачлалаа нарийвчлан боловсруулж хэд хэдэн хувилбараар тооцоолж аргачлалаа яаралтай албажуулах, яаралтай албажуулж олон нийтэд сурталчлах гэж байгаа юм. Соён гэгээрүүлэх, хөгжүүлэхэд хууль, эрх зүйн орчныг бий болгоход анхаарах, тодорхой ингээд анхаарах 7 дугаар зүйл нь тодорхойлох зэрэгт анхааран ажиллах шаардлагатай байна гэсэн ийм л 7 зүйлийг бичсэн байна. Дандаа анхаарах, нарийвчлах шаардлагатай байна, чухал байна.

Өнөөдөр хүртэл энийг хариуцаж байгаа улсууд нь энэ Хөдөлмөрийн яам, энэ Нийгэм хамгааллын яам, энэ асуудал дээр тодорхой хувилбарууд гаргасан уу? Мэргэжлийн байгууллагууд нь тэр янз бүрийн тооцоо, судалгааны энэ чинь мэргэжлийн ажил шүү дээ. Энэ чинь сонирхогчдын ажил биш. Тооцоо, судалгаа хийсэн үү? Хийгээд өнөөдрийн энэ манай Рэгдэл даргаар ахлуулаад энэ та 5 хүн дээр дүгнэгдээд ийм хувилбар Их Хурлаар оруулж батлуулмаар байна гэдэг ажлын хэсгийн санал байх ёстой гэж би ойлгож байна л даа. Тийм юмыг та нар мэргэжлийн түвшинд гаргаж өгсөн үү? Эндээс би юу ч харсангүй. Би шүүмжлээгүй шүү. Ингэж хийнэ гэдэг том ажил, ийм шаардлагатай байна, энэ чухал байна, хойшид анхааръя гэдэг бол чухал ажил. Барьцтай ямар нэгэн юм хийсэн үү? Одоо чинь зах зээлд ороод 30 жил болчихлоо.

Хоёрт нь нэг юм асууя даа хөөш та нар арай мэргэжлийн улсууд байна. Бид солидарити системээр яваад байгаа юм уу, контрибьютори системээр яваад байгаа юм уу, яг алинаар нь яваад байгаа юм? Би энэ 6 дугаар асуулттай холбогдуулж асууж байх шиг байна. Давхаргад тогтолцоо хөгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ ээ гэж байгаа юм. Давхар даатгалын тогтолцоог л яриад байх шиг байгаа юм. Энэ нэр нь бол энд олон давхаргад тогтолцоог яриад байна. Бид энэ систем нь яг алинаараа явж байгаа юм бэ? Солидарити хэвээрээ юм уу эсвэл бүр ямар ч системгүй болсон уу? Миний 2 дахь асуулт энэ.

3 дахь асуулт бол энэ сурталчилна аа, гэгээрүүлнэ ээ л гээд байна. Өнөөдөр хүртэл ерөөсөө юм хийгээгүй юм уу, өнөөдөр гэнэт ухаан ороод энийг хийх гэж байгаа юм уу?

4 дүгээр асуулт энэ итгэлцүүр тогтолцооны аргачлалын тал дээр ер нь бол сурталчилж судална л гээд байгаа юм. Ямар ч судалгаа байхгүй юм уу? Миний асуулт их ойлгомжтой байгаа гэж найдаж байна. Би тодорхой хариултууд авъя.

**О.Номинчимэг:** Хэдэн номер вэ? Ажлын хэсгээс асууж байна тийм үү? 4 номер Батжаргал дарга.

**Б.Батжаргал:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газар Батжаргал. Эхний асуулт нь Солидарити т системээр явж байна уу гэдэг асуулт байгаа. Тэгэхээр яг одоо бол бид нар Иссаны нэгдлийн тогтолцоо буюу олон улсын нэршлээрээ “pay-as-you-go” схемээр бол явж байна. Энэ бол эв санаагаар явж байгаа. Тэгээд цаашдын зорилт бол олон давхаргат буюу хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоо руу бол орох зорилт бол байгаа.

Хувилбар тооцооллуудыг бол бүгдийг нь хийсэн. Тэгээд энэ итгэлцүүрийг бол бид нар 2026 онд мөрдөх итгэлцүүрээ бас батлуулаад бас бид нар ажиллаад мөрдөөд явж байгаа. Харин итгэлцүүр нь бол окэй. Гол асуудал нь юу вэ гэхээр итгэлцүүрийг ашиглаад гарч байгаа доод хязгаар нь сая 404 байгааг дээшлүүлэх шаардлагатай байгаа. Судалгааг бүгдийг нь хийгээд бид нар бас Рэгдэл гишүүний ажлын хэсэгт бүгдийг нь танилцуулчихсан байгаа. Энэ дүн бол 2 сая 400 болгож өсөх юм бол 325-350 тэрбумын нэмэлт эх үүсвэр бас шаардлагатай гэсэн тооцооллыг бид нар бол нөгөө актуар тооцооллын аргаараа бүгдийг нь бод тооцоолж бодоод гаргаж танилцуулчихсан байгаа.

Сурталчилгааны хувьд нийгмийн даатгалын байгууллага бол нийт 21 аймаг 9 дүүрэгт байгаа нэгжүүдээрээ дамжуулаад сурталчилгаагаа хийж байгаа. Бид нар бол боломжоороо хийж байна. Энэ оны эхний 3 сарын байдлаар манай мэдээлэл нийтдээ 10 сая хүнд хүрсэн байна гэсэн ийм page-ийн тоололтыг бас бид нар сая энэ гаргаж авсан. Ноднин жил бол жилийн хэмжээнд 55 сая хүнд хүрсэн байна гэсэн ийм хандалтын тоог бол гаргасан байгаа. Гэхдээ бид нарт бас учир дутагдал байгаа. Илүү их сурталчлах, илүү их мэдээлэл өгөх, илүү их тайлбар бүр өгөх, тийм зөвлөмж өгөх ажлуудыг бид нар энэ жил илүү давтамжтай сайн хийх болно гэж төлөвлөж байна. Баярлалаа.

**О.Номинчимэг:** Сайнхүү Ганбаатар гишүүн тодруулъя.

**С.Ганбаатар:** Мөнгө хэрэгтэй байна. 2 аравны хэдэн их наяд юу мөнгө хэрэгтэй байна л гэж байна. Одоо байгаа Монголын ард түмнээс, ард иргэдээс төлөөд байгаа, төлж байгаа мөнгөөр бол бид дийлэхээ больсон гэдгээ бол албан ёсоор хэлж байна гэж би ойлгож болох уу? 1 дүгээр асуулт.

2 дугаарт, одоо өнөөдрийг хүртэл бараг олон жил, 30 жил зах зээлд ороод 34, 5-н жил ингээд төлсөн мөнгөнүүдээс менежмент нь хийгээд чадахаа болилоо, хасах гараад байна гэсэн үг үү?

Дараагийн асуулт гэвэл даатгал төлөгч энэ мөнгөний чинь эзэд даатгал төлсөн төлөгчдийн төлөөллийн дуу хоолой энэ шийдвэр дотор чинь орсон уу, тэдэнтэйгээ зөвлөлдсөн үү? Тэдний байр суурь эсрэг байгаа юу, дэмжиж байгаа юу? Энэ гадаа гудамд маш олон ахмадууд ингээд болохгүй байна л гээд орилоод байгаа энэ хүмүүсийн байр суурь орсон гэж би итгэж болох уу?

**О.Номинчимэг:** 4 номер Батжаргал дарга.

**Б.Батжаргал:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газар Батжаргал. Нийгмийн даатгалын ерөнхий газрын хувьд бол 4 санг хариуцаж ажиллаж байгаа. Тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, ажилгүйдэл гэсэн ийм 4 сан. Тэтгэврээс бусад сангууд бол ямар нэгэн байдлаар балансаа бариад явж байна. Зарим нь бол урсгал үлдэгдэл бол нэмэх баланстай байгаа. Тэтгэвэр дээр бол энэ жилийн хувьд нийт 6 их наядын зарлагыг

санхүүжүүлнэ. Энэ дээр 6 их наяд дээр бид нар бол заримыг нь бид нар шимтгэлээсээ авна. Улсын төсвөөс дэмжлэг бол 1.6 их наяд төгрөг бас байгаа. Тэгэхээр энэ мөнгөн дүн нь ямар утгатай вэ гэхээр 95 оноос өмнө тэтгэвэрт гарсан хүмүүсийн тоо бол 35 мянган хүн байна. Энийг бол төсвөөс санхүүжүүлдэг хуулийн зохицуулалттай. 24 мянган цэргийн тэтгэвэр авагч байгаа бас төсвөөс санхүүжүүлнэ. Яг алдагдал дээр бол 300 орчим тэрбум төгрөгийн алдагдал байгаа гэдгийг бас хэлье.

Санхүүжилтийн хувьд гэх юм бол 94 онд батлагдаад 95 онд мөрдөгдсөн нийгмийн даатгалын багц хуулиар бол хуримтлалын биш хуваарилалтын тогтолцоо буюу.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Ганбаатар гишүүн тодруулъя.

**С.Ганбаатар:** Манай орон ч дээ тэгээд ядарч байгаа учраас юун тэтгэвэр, эрүүл мэндийн даатгалтай ярихтай манатай л байна. Бусад оронд бол pension схем, медикэйр гэдэг л гол улс төр. Бид тэрэнтэйгээ манатай ядарч байна л даа. Тэгээд танаас асуух гэж байгаа зүйл гэвэл та улсаас мөнгө 6 их наяд майд гээд баахан юм ярилаа Нийгмийн даатгалын ерөнхий газар бол төрийн байгууллага биш шүү. Та нар бол нийгмийн даатгал төлсөн хүмүүсийн төлсөн мөнгөний 4 хувиар байх миний бодол ойлгож байгаагаар шимтгэлээр санхүүжиж байгаа. Та нар энэ даатгал төлсөн хүмүүсийн өмнөөс төртэй заргалдаж, өнөөдөр энэ 20, 30 жил аваад идчихсэн, төр аваад идчихсэн санхүүжүүлчихсэн мөнгөнүүдийг буцааж нэхэх ёстой шүү.

Тэгэхгүй зүгээр төрөөс мөнгө авах гэж байгаа юм шиг ярих биш. Төр харин даатгуулагчдын мөнгийг аваад залгичихсан мөнгөө буцааж өг гэдэг өнгөөр ярих нь бас энэ зүйд нийцнэ, шударга ёсонд нийцнэ гэж би ойлгож байна. Ингээд энэ.../минут дуусав./

**О.Номинчимэг:** Санал хэллээ. Өөр гишүүн байхгүй байгаад байгаа билүү? Би бол яах вэ нэг юм бас хэлмээр байгаа юм. Асуулт гэх үү яах вэ тодорхой санал гэх юм бол та хэд тооцоолол хийгээд ажлын хэсгээс бас яам маань хамтарч оролцсон юм шиг байна. Энэ итгэлцүүр, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ энэ итгэлцүүрийг зассанаар ерөнхийдөө Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсөвт 325 тэрбум төгрөг шаардлагатай гэж харж байгаа юм байна тээ? Энийг 27 онд тусгаж өгөх тодорхой ийм мөнгөн дүн байна. Яг одоо Улсын Их Хурлаар төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэж байгаа. Төсвийн хүрээний мэдэгдлээр ер нь бид нар нэлээн эдийн засгийн инфляцын нөхцөл байдлуудаа ярьж байгаа. Энийг бас бид нар одоо яг хэлэлцүүлгийн явцад илүү Засгийн газарт чиглэж бас хэлэх талаар санал, дүгнэлтийн хувьд яая. Энэ нөгөө хараад байхад бас их шударга бус байдал их байх шиг байгаа юм.

Яагаад гэвэл манай нийгмийн даатгалын тогтолцоо бүх хүнд хамаатай байгаа учраас улс төрчид их попрех дуртай. Улс төрчид попроод өөр өөрийн сегментдээ зориулсан хууль гаргадаг. Ингэснийхээ үр дүнд энэ системээ бэхжүүлэх гэхээсээ илүү задлаад хаячихсан юм байгаад байгаа юм. Тэгээд энэ яг энэ та бүхний санал, дүгнэлтийн 3-д бичсэн байна л даа нийгмийн даатгалын шимтгэлийн хамгийн бага хувиар төлж тэтгэвэр тогтоолгож сүүлийн 5 жилийг огцом өсгөж өндөр тэтгэвэр тогтоолгож байгаа ийм хууль, эрх зүйн орчны хийдлийг гарга гээд. Тэгээд яг энэнтэй холбоотой бас аягүй олон асуудал хэлж байсан. Бид

нар өмнө нь юу гэдэг юм ингээд социализмын үед ажиллаж байгаад тэтгэвэрт 90-ээд онд, 2000-аад онд тэтгэвэрт гарчихсан хүмүүс байдаг.

Тэгтэл сүүлд ийм хууль иргэдэд таалах гэсэн л популист л хууль шүү дээ энэ бол, гаргаад 5 жилээр нь тооцдог болсноос хойш сүүлийнхээ 5 жилийг өндрөөр тогтоолгох, мэдээж энэ бол иргэдийн хувьд бол угаасаа л тийм шийдэл рүү явна шүү дээ. Ийм нөхцөлийг нь хууль, эрх зүйн орчныг нь бүрдүүлээд өгөх юм бол. Хамгийн сүүлд 5 жилдээ нэг хувийн компани ч юм уу арай өндөр цалинтай байж байгаад тэтгэврээ өндөр тогтоолгоё гэдэг асуудал гарсан. Тэгээд түүнээс үүдээд шударга бус байдал буюу би адилхан л ажил хийж байхад миний тогтоолгосон тэтгэвэр сүүлд тогтоолгосон хүмүүсийн тэтгэвэр 2 ийм зөрүүтэй байна гэдэг юм байгаад байгаа. Тэгэхээр энэ Нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хөгжлийн яам Нийгмийн даатгалын сангаас та бүхэн яг энэ популизмд автахгүй бодлогын хүрээнд хийх ёстой ажлуудаа маш сайн ярьж ойлгуулж, Улсын Их Хурлын гишүүдэд ч гэсэн энэ шийдвэр гаргах гэж байгаа хүмүүст бас тайлбарлаж хэлмээр байна. Тэгэхгүй бол бид нар жилийн жилд л ийм гомдолтой, шударга бус байдалтай, тэтгэвэр бага байгаа байдалтай явсаар л байх болноо гэдгийг бас нэмж хэлмээр байна.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Ахмад настнуудаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилхан орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлж, цалингийн итгэлцүүрээр тэтгэврийг шинэчлэн тогтооход ахмадуудын тэтгэврийн хэмжээ багассан асуудлаар ирүүлсэн өргөдлийг судлан, санал, дүгнэлт болон шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцүүлж дууслаа бид. Энэ санал, дүгнэлтийг тэр том ажлын хэсэг рүү бас давхар өгч байгаа. Тэгэхээр энэ дээр гарсан тодорхой саналуудыг нь төсөвт суулгах санал байна, бусад хууль, эрх зүйн орчныг нь анхаарах асуудал дээр бас ажлын хэсгийн гарсан санал, дүгнэлтийг цаашид ажил хэрэг болгох асуудал дээр бид бүгд анхаарч ажиллах ёстой.

Ингээд Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал өндөрлөсөн тул өнөөдрийн хуралдаан дууссаныг мэдэгдье. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

13.56 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*

